



СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛ

СЭТГҮҮЛ

ДУГААР 2023/03

МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН
ЕРӨНХИЙ ХОРОО

СОНГОГЧИЙН
ӨДӨРЛӨГ



www.m-election.mn



GECMongolia



Монгол Улсын
Сонгуулийн
ерөнхий хороо

СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛ

СЭТГҮҮЛ

ДУГААР 2023/03

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ЭРХЛЭГЧ

Д.Бат-Эрдэнэ

Мэдээлэл, судалгаа, сургалтын төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

З.Бадмаараг

Хорооны хэвлэлийн төлөөлөгч-Референт

ЗӨВЛӨХ

Ж.Амарсанаа

Академич, хууль зүйн шинжлэх ухааны доктор

ГИШҮҮД

П.Алтанчимэг

Мэдээллийн технологийн төвийн ахлах референт

Ш.Сүхбаатар

Хууль зүйн ухааны доктор, судлаач

С.Оюунтуяа

Сонгогчдын боловсрол төв ТББ-ын гүйцэтгэх захирал

Ч.Сайнсанаа

Чимид сангийн тэргүүн

МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО

@Бүтээлийн зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан тул олшруулахыг хориглоно.



АГУУЛГА



01 СОНГУУЛЬД
СУРАЛЦАХУЙ



02 ДУГААРЫН ЗОЧИН



03 ХУУЛИЙН
БУЛАН



04 ЭНЭ ТУХАЙ



05 СОНГУУЛЬ ДЭЛХИЙ
ДАХИНД

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

СОНГУУЛЬД СУРАЛЦАХУЙ

УИХ-ЫН СОНГУУЛИЙН ТОГТОЛЦООНЫ ҮНДСЭН ЗАРЧИМ¹



БЯРААГИЙН ЧИМИД

Ардчилсан Үндсэн хуулийн эхийг баригч, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор

Орчин үед “сонгуулийн тогтолцоо” түүний “зарчим” гэдэг олон утгатай хэрэглэгдэх болов. Энэ тухай тус бүлгийн 2.4.2-т жагсаан тайлбарласан болно. Түүний дотор Монгол Улсын хууль болон сонин, сэтгүүлд сонгуулийн тогтолцоог “нийт, шууд, тэгш эрх”-ийн гэх уламжлалт ойлголтоор тодорхойлсноос гадна санал тооцох аргаар “олонхийн, хувь тэнцүүлсэн, холимог тогтолцоо” гэх нэр томъёо өргөн хэрэглэгдэж уг асуудлын утга салаалах явдал гарах болов. Энэ бол сонгуулийн ардчиллын хөгжлийн зүй ёсны тусгал бөгөөд цаашид холбогдох хуулиудад тусган хэрэглэх хэрэгцээ ч байж болох юм.

Гэхдээ Монгол Улсын хувьд өнөө үеийн сонгуулийн эрх зүйн гол эх сурвалж нь Үндсэн хууль мөн

учраас түүнд заасан зарчмыг уул тогтолцооны **анхдагч** буюу **үндсэн эхлэл** болгон баримтлах нь зайлшгүй билээ. Монгол Улсын Үндсэн хуульд УИХ-ын сонгуулийн үндсэн зарчмыг тодорхойлохдоо сонгогчдын буюу иргэдийн сонгох, сонгогдох үндсэн эрхийн шинж байдлыг гол шалгуур болгожээ. Тухайлбал **Үндсэн хуульд нийт, шууд, тэгш² эрхийн үндсэн дээр саналаа чөлөөтэй нууцаар гаргах журмыг** тодорхойлжээ. Энэ нь “олонхийн” зэрэгцээгээр “хувь тэнцүүлэх” аргыг сонгуулийн үр дүнг тооцох арга болгон хуульчилж улмаар хэрэглэхэд саад болохгүй юм. **“Сонгогчийн эрхийн зарчим”** (2.4.2-т үз.) гэх болсон **нийт, шууд, тэгш эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргах тогтолцоог** өмнө өгүүлсэнчлэн Хүний эрхийн

түгээмэл тунхаглал, Хүний Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пактаар хүлээн зөвшөөрсөн байдгийг энд шууд харгалзан үзэх нь зүйтэй. Энэ бүхнийг эс үндэс болговоос Үндсэн хуульд бататган тунхагласан дээрх зарчмыг УИХ-ын сонгуулийн тогтолцооны үндсэн зарчим гэж ойлгох нь зөв болно.

Иймийн учир Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцооны шинж байдлыг түүний үндсэн зарчмуудын агуулгаар дор хураангуйлан тодорхойлов.

¹ Б.Чимид. Сонгуульд суралцахуй, УБ, 2008, 54-62 дахь тал.

² Хүний болон иргэний тэгш эрх, төрийн үйл ажиллагааны тэгш байдлын тухай Үндсэн хуулийн 1.2; 14.1; 16 дугаар зүйлийн агуулгаар тайлбарлав.

УИХ-ЫН СОНГУУЛИЙН ТОГТОЛЦООНЫ ҮНДСЭН ЗАРЧИМ

 БҮХ НИЙТИЙН СОНГУУЛЬ	 ЧӨЛӨӨТЭЙ СОНГУУЛЬ	 ШУУД СОНГУУЛЬ
 Сонгох эрхийг Монгол Улсын 18 насанд хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай иргэн бүр эдэлнэ. Энэ эрхийг хэн ч ямар ч шийдвэрээр хязгаарлах ёсгүй.  Харин оюун ухаанаараа өөрийгөө жолоодох чадваргүй нь шүүхээр тогтоогдсон, түүнчлэн сонгуулийн өдөр хорих ял эдэлж байгаа иргэн сонгуульд оролцохгүй.  Сонгогдох эрхийг тухай албан тушаалд сонгогдож болох талаар хуульд заасан болзол хангасан сонгуулийн эрх бүхий иргэн бүр эдэлнэ. УИХ-ын гишүүнээр Монгол Улсын 25 насанд хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэн сонгогдох эрхтэй.	 Сонгуульд оролцож саналаа өгөх, сонгогдохоор нэрээ дэвшүүлэх эсэх нь тухайн иргэний өөрийн хүсэл зоригийн хэрэг байна.  Ямар ч байгууллага, албан тушаалтан хэн боловч хэнийг ч сонгуульд оролцох, саналаа өгөх, нэр дэвшүүлэх эсэхийг албадан шахаж болохгүй.  Хэрэв ийнхүү албадан шахсан байвал гэм буруутанд Эрүүгийн хуулийн хариуцлага хүлээлгэнэ.  Иргэнийг сонгуульд оролцсонгүй гэдэг үндэслэлээр хариуцлагад татах буюу хавчин гадуурхаж болохгүй.	 УИХ-ын гишүүнийг ямар нэг байгууллага, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээр дамжуулан дам сонгохгүйгээр тойргоос буюу нэр дэвшүүлсэн намын нэр дээр саналаа шууд гарган сонгохыг хэлнэ.  Харин багаас сумын Хуралд, сумаас аймгийн Хуралд, түүнээс УИХ-д сонгодог бол шууд биш олон шаттай сонгууль гэдэг байв.  Шууд сонгогдсоноороо УИХ-ын гишүүн нь УИХ-д байнга сууж, хууль тогтоох ажил хийлгэхээр илгээсэн ард түмний элч болдог.

НУУЦААР САНАЛ ГАРГАХ ЖУРАМ

Улсын Их Хурлын сонгуулийн төрөл, зүйл

Манай сонгуулийн тогтолцооны төрөл, зүйл нь олон орны нийтлэгээс гадна улсынхаа өвөрмөц байдал юуны өмнө парламентынхаа бүтэц бүрэлдэхүүнийг тусгадаг. Тэр бүтэц нь сонгуулийн тогтолцоонд шууд нөлөөлдөг.

Үндсэн хуульд зааснаар “Улсын Их Хурлын нэг танхимтай 76 гишүүнтэй байна. Танхим гэж үндсэн бүтэцийг нь, “гишүүн” гэж бүрэлдэхүүнийг нь хэлж байгаа юм. Зарим улс төрийн байгууламж, хүн амын үндэсний бүрэлдэхүүн зэргээ харгалзан ижил эрхтэй хоёр танхим бүхий Улсын Хурал буюу парламенттай байдаг.

Заримдаа өөр шалтгаанаар түүнээс олон танхимтай улс ч байсан түүх бий.

Монгол нь хэд хэдэн ястан угсаатны боловч нэг үндэстний нэгдмэл улс тул парламент нь нэг танхимтай, 76 гишүүнийг сонгосноор УИХ бүрдэнэ.

УИХ-ын сонгууль нь (сонгуулийн

тогтолцоо) гэсэн гарчиг өгүүлсэн олонхийн тогтолцоотой нийтлэг шинжтэй боловч зохион байгуулалтын хэлбэр, хугацаа, үйл явцын нөхцөл, журмын хувьд өөрийн гэсэн онцлогтой. Өөрийн нөхцөлөө зөв харгалзах нь үнэхээр чухал. УИХ-ын сонгууль нь:

1. Ээлжит сонгууль
2. Ээлжит бус сонгууль
3. Нөхөн сонгууль
4. Дахин сонгууль гэсэн зүйлтэй.

Ээлжит сонгууль бол УИХ-ын бүрэн эрхийн хугацааг хэмжээлж, бүрэлдэхүүнийг тогтмол шинэчлэн сэлбэж байх агуулгатай. Тэр нь ард түмний хяналт, гишүүний хариуцлагыг тодорхой болгож парламентыг шинэ хүчээр сэлбэж байхад чиглэнэ. Үндсэн хуульд зааснаар ээлжит сонгуулийг дөрвөн жилд нэг удаа явуулна.

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин нэгдүгээр зүйлээс:

“2. УИХ-ын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.

Энэ бол УИХ-ын бүрэн эрхийн хугацааны зэрэгцээгээр сонгуулийн тогтолцооны үндсэн зарчмыг тогтоосон заалт бөгөөд түүнийг дараах зүйлд тайлбарлав.

УИХ бүрэн эрхийнхээ хугацааг өөрийн дураар алгуурлаж болохгүй. Гагцхүү онцгой нөхцөл байдлаас шалтгаалбал болзолт хугацаагаар хойшлуулж болно. Энэ тухай Үндсэн хуулийн хорин хоёрдугаар зүйлд тухайлан заажээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин хорин хоёрдугаар зүйлээс:

“1. Улсын нийт нутаг дэвсгэр буюу зарим хэсгийг хамарсан гэнэтийн аюул тохиолдсон, дайны ба нийтийн эмх замбраагүй байдал үүссэн зэрэг онцгой нөхцөлийн улмаас ээлжит сонгууль явуулах боломжгүй бол мөнхүү нөхцөл арилж, шинэ сонгогдсон гишүүдээ тангараг өргөтөл УИХ бүрэн эрхээ хэрэгжүүлнэ.

“Мөнхүү нөхцөл байдал арилтал” гэдэг нь санаа нь болзолт хугацаа юм. Арилсан байтал сонгууль зарлахгүй, явуулахгүй бол засгийн эрхийг хууль бусаар эзэрхсэнд тооцогдоно. “Онцгой нөхцөл” гэдгийг “Онц байдлын тухай” зэрэг холбогдох хуулиар тогтоосон бий.

Ээлжит бус сонгуулийг УИХ бүрэн эрхийнхээ хугацаанаас өмнө тарах шийдвэрийг Үндсэн хуульд зааснаар өөрөө буюу эсвэл Улсын Ерөнхийлөгч гаргасан бол явуулна.

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин хоёрдугаар зүйлээс:

“2. УИХ бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь үзсэнээр буюу эсхүл мөнхүү шалтгаанаар Ерөнхийлөгч УИХ-ын даргатай зөвшилцөн санал болгосноор өөрөө тарах шийдвэр гаргаж болно. Ийнхүү тарах шийдвэр гагасан бол шинэ сонгогдсон гишүүдээ тангараг өргөтөл УИХ бүрэн эрхээ эдэлнэ.

Харин сонгуулийн тухай хуульд энэ заалтыг хэрэглэх нөхцөлийг төдий л тодруулсангүйн дээр сонгуулийн

тухай хуульд тодорхойлсон <<санал авах өдрөөс 45 хоногийн өмнө товлон зарлана>> гэдгийг эш татсан байна. Зүй нь энэ тухай биш, тарах шийдвэр гарсанаас хойш дээр дурдсан хэдий хугацаанд товлон зарлах ёстойг заасан бол сонгуулийг заавал хугацаанд нь товлон зарлах хууль ёсны зарчмыг хангахад нийцэх байжээ.

Нөхөн сонгуулийг УИХ-ын гишүүн орон гарсан, нас барсан бол орон гишүүнийг сонгохоор товлон зарлаж явуулна.

Дахин сонгуулийг дээр тайлбарласан ээлжит, ээлжит бус, нөхөн сонгууль нь аль нэг тойрогт хүчингүй болсон нөхцөлд явуулна.

Сонгуулийн тухай хуульд зааснаар:

1. тойрогт нэр дэвшигчдийн хэн ч 25, түүнээс дээш хувийн санал аваагүй;
2. тойргийн нийт сонгогчийн 50 хувь санал хураалтад оролцоогүй;
3. сонгуулийн аль нэг хэсэгт явуулсан дахин санал хураалт хүчингүй болсон нь тэр тойргийн сонгуулийн дүнд ноцтой нөлөөлөхөөр байвал дахин сонгууль явуулахаар заажээ.

“Ноцтой нөлөөлөх” гэдэг нь дахин санал хураасан дүн нь тус тойрогт өрсөлдөгчдөөс хамгийн олон саналыг авсан дүн өрсөлдөгчийн авсан саналын дүнд хүртэл буурах магадлалтайг хэлнэ. Жишээ нь ялсан, түүний дараа үлдсэн нэр дэвшигчийн авсан санал ганц нэг саналын, магадгүй зохих хэсгийн сонгогчдын саналын тооны дотор багтсан зөрөөтэй бол ноцтой гэж болох. Харин гурван өрсөлдөгчийн дотор ялагч 80 хувийн саналтай

боловч дараах хоёр нь 10, 10 хувийн саналтай бол тэр хэсгийн сонгогчдын дахин санал хураасан ч бусад нь ялахгүй нь тодорхой тул "ноцтой" гэж үзэх үндэслэлгүй.

Үүнээс гадна тойрогт сонгууль явуулахдаа албадах, сүрдүүлэх, хахуульдах, дахин санал өгүүлэх, өөр хэсгээс бөөнөөр авчирч санал өгүүлэх зэргээр сонгуулийн хууль тогтоомжийг зөрчиж сонгогчдын саналаа өөрийнхөөрөө илэрхийлэх боломжийг алдагдуулсан бол ноцтой нөлөөлөх гол шалтгаанд тооцохоос аргагүй.

Ээлжит болон ээлжит бус сонгууль нь УИХ-ын бүрэлдэхүүнийг буюу бүх гишүүнийг хамарсан улсын хэмжээний үйл явц юм. Сайхь хоёр сонгуулийн зарчим, журам нийтлэг бөгөөд түүнийг энэ номын бүх бүлэг зүйлд тайлбарласан. Харин нөхөн, дахин хоёр зүйл сонгууль нь зөвхөн зохих тойргийг хамаардаг. Иймээс зарчим нь нийтлэг боловч цаг хугацааны зэрэг үйл явцын журам нь зарим онцлогтой. Нөхөн болон дахин сонгуулийн үйл явцын хугацааг ээлжит сонгуулийнхаас ямар ялгаатайг дараах хүснэгтээр харуулав.

Дахин сонгуулийг тухайн тойрогт явуулсан өмнөх сонгуулийг хүчингүй болгох шийдвэр гарсанаас хойш 25 хоногийн дотор Сонгуулийн ерөнхий хороо товлон зарлаж 25 хоногийн дотор явуулна. Чингэхдээ "хэсгийн хороо шинэчлэн байгуулах", "нэр дэвшүүлэх" зэрэг уг сонгуулийг бэлтгэх, явуулах ажилд нөхөн сонгууль явуулах талаар тогтоосон заалтыг баримтална гэжээ.

"Холбогдох заалт" гэдгийг 25 хоногт нь багтах хугацаа, журам хамаарна гэж ойлгохоос өөр аргагүй. Жишээлбэл сонгуулийг 30-60 хоногийн дотор зарлах, түүнээс хойш 30 хоногийн дотор санал хураах зэргийг хэрэглэх боломжгүй. Харин дээрх хүснэгтийн зөвхөн нөхөн сонгуульд хамаарах 4-10-т заасан 17 хоногт доторх үйлдэлд хэрэглэж болно гэж ойлгоно.

№	Үйлдэл, үйл явц	Ээлжит сонгууль	Нөхөн сонгууль
1	Сонгууль зарлах	Санал авах өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө	Гишүүн орон гарсанаас хойш 14 хоногийн дотор, чуулган завсарласан бол эхэлмэгц 30 хоногийн дотор
2	Сонгууль бэлтгэн явуулах нийт хугацаа	45-аас доошгүй хоног	30 хоног
3	Сонгуулийн тойрог байгуулах	Санал хураах өдрөөс 6 сараас доошгүй хоногийн өмнө	Хуучин тойрог хэвээрээ байх
4	Сонгуулийн хэсэг байгуулах	Мөн өдрөөс 35 хоногийн өмнө	Санал хураах өдрөөс 17 хоногийн өмнө
5	Тойргийн хороо байгуулах	Мөн өдрөөс 40-өөс доошгүй хоногийн өмнө	Мөн өдрөөс 14 хоногийн өмнө
6	Салбар хороо байгуулах	Мөн өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө	Мөн өдрөөс 14 хоногийн өмнө
7	Хэсгийн хороо байгуулах	Мөн өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө	Мөн өдрөөс 14 хоногийн өмнө
8	Нэр дэвшүүлэх	Сонгууль зарласнаас хойш 10 хоногт эхэлж 7 хоногт	Зарласнаас хойш 5 хоногийн өмнө эхэлж 5 хоногт
9	Нэр дэвшигчийг бүртгэх	Нэр дэвшилт дууссанаас хойш 9 хоногт	Нэр дэвшилт дууссанаас 5 хоногт
10	Нэрийн жагсаалт гаргаж хэсгийн хороонд өгөх	Санал хураах өдрөөс 25-аас доошгүй хоногийн өмнө	Санал хураах өдрөөс 12 хоногийн өмнө
11	Жагсаалтыг сонгогчдод танилцуулах	Сонгууль зарласан өдрөөс 15-аас доошгүй хоногийн өмнө	Мөн өдрөөс 10 хоногийн өмнө
12	Санал авах өдөр	Мөн зарласнаас 45 дахь хоног	Зарласнаас 30 дахь хоног

УИХ.МН
СУДАЛГААНЫ САН



ДУГААРЫН ЗОЧИН

Г.БОЛОР-ЭРДЭНЭ:

ИРЦ ӨНДӨРТЭЙ СОНГУУЛИЙН ҮР ДҮН Ч ГОЛЧТОЙ ГАРДАГ САНАГДДАГ

Увс аймгийн сонгуулийн хорооны дарга, “Хариуцлагатай сонгогч” бэлтгэх сургагч багш Г.Болор-Эрдэнийг дугаарын зочноор урьж, ярилцлаа.

Та Аймгийн сонгуулийн хороог олон жил ахалж ажиллажээ. Сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулахад юу тулгамддаг вэ? Сонгуулийн байгууллагын ажилтан болсон дурсамжаасаа хуваалцана уу?

Улсад 33 дахь жилдээ ажиллаж байна. Анх 1993 онд сумын иргэдийн Төлөөлөгчдийн хуралд

нэр дэвшиж, сумын ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдон ажилласан. Сумын иргэдийн хуралд хоёронтоо сонгогдон Хархираа, Улаангом сумаас ИТХ-ын төлөөлөгч болж байлаа. Ер нь сонгууль бол маш том хариуцлага гэдгийг тэр үед ухаарсан. Сонгуульд нэр дэвшинэ гэдэг бүр их хариуцлага. Нэр дэвшигчийн хувьд сонгуулийн үйл явцыг нарийвчлан

судалдаг. Тиймээс сонгуулийн үйл явцыг чухал хариуцлага гэж ойлгоод цаашид удирдаж явна гэдэг бас их том асуудал. Тэр утгаараа аймгийн сонгуулийн хороог 3 дахь удаагаа удирдаж байна. Аливаа сонгуульд сонгогчийг оролцуулах, ирц, оролцоо ихээхэн чухал асуудал байдаг. Тийм учраас сонгогчдын боловсролын асуудал маш өндөр яригдаж байна.

Монгол Улсын хэмжээнд хамгийн том хариуцлагыг бидний ирээдүй болсон залуучууд үүрэх ёстой юм. Гэтэл залуучууд сонгуульд идэвхгүй, оролцоо сул байгаа гэсэн судалгаа байна. Би сүүлийн хоёр жил “Хариуцлагатай сонгогч” бэлтгэх сургагч багшаар сонгогчдоод ажиллаж байна. Ялангуяа анх удаа сонгуульд оролцож, саналаа өгөх залуучууд, оюутан, сурагчид, бусад хүнд сонгогчийн боловсрол олгох асуудал чухлаар тавигдаж байгаа. Тиймээс “Хариуцлагатай сонгогч” сургалтыг Сонгуулийн ерөнхий хороотой хамтран зохион байгуулж эхэлсэн нь үр дүнтэй, чухал ажил болоод байна. Залуу үедээ сонгуулийн мөн чанар, оролцохын ач холбогдлыг ойлгуулах маш чухал. Сургалтын явцад оролцогч залуусын улс төрийн мэдлэг, ойлголт хомс байдаг нь анзаарагдсан. Тиймээс бидний явуулж буй сургалтуудыг цаг үеэ олсон ажил хэмээн үнэлж, дүгнэж байна. Ирээдүйдээ итгэх итгэлийг олж, нийгэмд идэвхтэй ажиллаж, амьдрахын мөн чанарыг таниулахад сонгуулийн тухай ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх нь чухал юм. Увс аймагт гэхэд л сургагч багш Д.Баяраагийн хамт 4 дэх удаагийн сургалтаа зохион байгууллаа. Мөн сумдад ажиллахдаа бид залуучуудад энэ ойлголтыг тодорхой хэсэгт өгөөд яваад байгаа. Энэ ажил 2024 оны УИХ-ын сонгууль хүртэл үргэлжилнэ.

Та анх өөрөө нэр дэвшиж сонгуулийн оролцогч болж байжээ?

Тийм ээ.

Сонгуультай холбоотой ямар дурсамж танд үлдсэн бол?

Сонгуулийн үед мэдлэг, мэдээлэлтэй сонгогчдын оролцоо их чухал. Сонгогчдод мэдээлэл хүргэх их ач холбогдолтой юм байна гэдгийг олж харсан. Сонгуулиа хэрхэн өгөх, хэнийг дэмжвэл улс орны хөгжилд хувь нэмэртэй вэ гэдгийг манай сонгогчид нэг их анзаардаггүй. Олж мэдэхийг хичээдэггүй. Ялангуяа нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөртэй ерөөсөө танилцдаггүй. Дөнгөж сурталчилгаа эхлэнгүүт “Өө, би энэ хүнийг л дэмжинэ” гээд шууд итгэх хандлагатай. Бусад хүний ямар мөрийн хөтөлбөр дэвшүүлсэнийг судалдаггүй. Юу шийднэ гэв, өөрт нь хэрэгтэй юу? Баг, суманд

“ **СОНГУУЛЬ БОЛ МАШ ТОМ ХАРИУЦЛАГА** гэдгийг тэр үед ухаарсан. Сонгуульд нэр дэвшинэ гэдэг бүр их хариуцлага. ”

хэрэгтэй юу гэх мэтийг тоодоггүй, судалдаггүй. Хамгийн том алдаа бол тэнд байдаг. Тийм учраас нэг ёсондоо сохроор сонголтоо хийж байгаа нь улс орон, аймаг, сумынхаа хөгжлийг хойш татаж байна гэсэн үг. Ямар нэг аргаар сонгогчдын боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх, ядаж мөрийн хөтөлбөрийг уншаад шинжлэн дүгнэх чадварт сургах, судлах ёстой гэсэн сэтгэхүйтэй болгох ёстой. Энэ бол одоо ч, цаашид ч анхаарах ёстой асуудал гэж ойлгож байгаа.

Увс аймаг сонгуулийн ирц, оролцоо харьцангуй өндөр явж ирсэн үзүүлэлт бий. Гэхдээ?

Манай аймгийн сонгогчдын ирц харьцангуй өндөр байсан. Хамгийн

сүүлд хоёр жилийн өмнө болсон Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн дүнг харвал 50 хүрэхтэй, үгүйтэй хувь нь сонгуульд оролцож, саналаа өгсөн. Энэ нь идэвх, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр ажиллах шаардлагатайг илтгэж байна. Нөгөө талаар залуучуудад мэдлэг, мэдээлэл өгөх чухал байна.

Ахмад настнууд угаасаа сонгуульд оролцоод сурчихсан хүмүүс. Гэтэл манай залуус юуны төлөө, юу хийж, ирээдүйгээ хэрхэн төсөөлж амьдрах нь мэдэгдэхгүй, идэвх маш сул байна. Үүнийг сонгуулийн оролцооноос ажиглаж болох юм. Залуучууд ирж саналаа өгөх нь цөөрсөн. Талаас бага хувь нь сонгуульд оролцож байна. Санал өгөөгүй хүмүүс улс орон, аймаг, сумынхаа хөгжлийн төлөө “Чи миний төлөө ажиллах ёстой. Би ийм юмны төлөө саналаа өгсөн” гээд мөрийн хөтөлбөрийг нь бариад хариуцлагыг нь нэхдэг тогтолцоо руу шилжих зайлшгүй шаардлагатай болоод байгаа.

Орон нутагт сонгууль зохион байгуулж явуулахад ямар асуудалтай тулгардаг вэ? Энэ олон жилийн хугацаанд Та болон танай баг юуг даван туулж байв?

Асуудал байлгүй яах вэ. Байгаль, цаг уураас гадна мэдээллийн технологитой холбоотой асуудал үүсдэг. Манай аймгийн хамгийн хол сум нь 340-350 км зайтай. Малчид түүнээс цааш 400 гаруй км-ын цаана амьдарч байна. Төв сууринаас алслагдмал газарт амьдардаг малчид, багийн иргэд санал авах байранд ирж, санал өгөх асуудал хүндрэлтэй. Ялангуяа байгаль, цаг агаарын үзэгдэлтэй үед бүр хүндэрнэ. Хүмүүс сонгууль өгсөн ч яалаа, байсан ч яалаа

“

Нэг суманд 70-80 төрийн албан хаагч байгаа. Тэднээс түүврийн аргаар авч ажиллуулдаг бол цаашдаа их зүгээр гэж ойлгодог. Хуулиндаа төрийн албан хаагчийг ажиллуулна гээд заасан ч хэрэгжүүлэхгүй байна.

гэсэн ойлголттой болчихсон. Тэр хүмүүсийг авчраад сонгуульд оролцуулчихмаар байдаг. Гэтэл өөрийн унаагүй байдлаас болоод ирж амждаггүй зэрэг асуудлыг дагаад сөрөг үзэгдэл гарах энүүхэнд. Жишээ нь нөгөө сонгогчдыг нэр дэвшигч өөрийн унаагаар зөөж саналыг нь өгүүлдэг. Нэгэнт аваад ирсэн хүний төлөө саналаа өгөхгүй байх хэцүү, өгөх хэцүү. Сонголтод хүртэл нөлөөлдөг. Хоёрдугаарт, хэдийгээр бид мэдээллийн эрин зуунд амьдарч байгаа ч алслагдсан, хэдэн уулын цаана байгаа багт сүлжээ барьдаггүй. Тэр битгий хэл, зарим хэсгийн хороо хүртэл цахимаар мэдээлэл өгөх боломжгүй байдаг болохоор үүнийг цаашид боловсронгуй болгох, хөгжүүлэх нь чухал байгаа.

Таны оролцож зохион байгуулсан сонгуулийн тоо хэд вэ?

Би өөрөө нэр дэвшиж оролцсон нь гурван удаагийн сонгууль байдаг. Зохион байгуулсан нь сумын сонгуулийн хороонд хоёр удаа, аймгийнхад 3 дахь удаагаа ажиллаж

байна. Аймгийн сонгуулийн хорооны даргаар ажиллаж байна. Сонгуулийн бүх үйл явцыг хуулийн дагуу ямар нэг сөрөг үр дагавраас ангид, хэл амгүй зохион байгуулахыг хичээж ирсэн. Жил ирэх тусам хүмүүсийн сонгуульд хэрэглэдэг хар пиар ихэсч байгаа нь ажиглагддаг. Сөрөг мэдээлэл маш их ирдэг. “Тэр нэр дэвшигч хууль бус үйлдэл хийлээ” гэсэн гомдол ирнэ. Очоод үзэхээр тодорхой бус, баримтгүй байх жишээний. Сонгуулийн хороо бол сонгууль зохион байгуулах, сонгогчдын боловсролыг дээшлүүлж, идэвхжүүлэх мэдээлэл явуулах үүрэгтэй. Гэтэл энд тэндээс ирсэн сөрөг мэдээлэлд хамаг цаг нь зарцуулагдчих гээд байдаг муу үр дагавар их болсон.

Сонгуулийн байгууллагын ажилтнуудад үл итгэх хандлага та бүхний урмыг хугалдаг уу? Хэр эмзэглэдэг вэ?

Эмзэглэхгүй байхын аргагүй асуудал. Яагаад гэвэл сонгуулийн хэсгийн хороог тухайн шат, шатны хороод байгуулдаг учраас хүнээ сонгоод байгуулчихдаг. Хүнээ



үзэмжээр сонгодог нь хамгийн их зөрчилтэй. Намын угшлаар нь сонгоод авдаг. Эндээс хамаг зөрчил үүсдэг. Сонгож авдагаас зөрчил үүсдэг. Нэг суманд 70-80 төрийн албан хаагч байгаа. Тэднээс түүврийн аргаар авч ажиллуулдаг бол цаашдаа их зүгээр гэж ойлгодог. Хуулиндаа төрийн албан хаагчийг ажиллуулна гээд заасан ч хэрэгжүүлэхгүй байна. Тиймээс түүврийн аргаар тодруулаад, түүврээр сонгогдсон төрийн албан хаагчийг сонгуулийн хороод, хэсгийн хороодод ажиллуулахаар сургалтыг зохион байгуулах, цахимаар сургахад хангалттай. Мэргэшүүлээд авчих хэрэгтэй юм. Ямар ч төрийн албан хаагч төрийн сонгуулийг удирдан зохион байгуулж чадна.

Хүмүүсийг насаар нь сонгуулийн хороо, хэсгийн хороонд ажиллуулах нь сайн ч, саар ч талтай. Муу арга их хэрэглэж байна. Түүврийн аргыг сонгож шинэчлэлт хийвэл илүү үр дүнтэй.

Нэр дэвшигчдийн зүгээс хэр дарамт, шахалт ирдэг вэ?

Сонгуулийн дүн, мэдээ бүх зүйл цахимжсан болохоор дарамт харьцангуй багассан. Хуучин бол маш хэцүү байсан. Сонгуулийн хэсгийн хороон дээр санал тоолж байх үед гэрэл, цахилгааныг нь тасалдаг. Янз бүрийн аргаар, сонгуулийн дүнд нөлөөлөхийг оролддог байлаа. Одоо цахимжаад тэр үзэгдлүүд буурсан.

Сонгуулийг шударга зохион байгуулахын тулд юуг анхаарах ёстой вэ?

Бэлтгэлээ сайн хангаж ажиллах ёстой. Хуульд заасан хугацаанд хэсгийн хороогоо байгуулах, зүгээр байгуулаад зогсохгүй байгаль, цаг агаарын нөхцөл, эрсдэлт хүчин зүйлсээ тооцоолох, аюулгүй байдлыг хангах шаардлагатай. Хяналт сайтай байх. Хаана хяналт сул байна, тэнд булхай явдаг. Сонгогчдын ирцийн асуудалд анхаардаг. Ирц өндөртэй

сонгуулийн үр дүн голчтой гардаг юм шиг санагддаг. Тиймээс ирцийг нэмэгдүүлэх маш чухал.

Сонгуулийн байгууллагын шинэ ажилтнуудад хандаж таны өгөх зөвлөгөө?

Юуны түрүүнд хуулийг сайн судлах ёстой. Хуулийн мэдлэгээс гадна шударга ажиллах хэрэгтэй. Дөрвөн жилд нэг удаа болдог маш том хариуцлага. Аль нэг улс төрийн хүчний төлөө улайрч ажилладаг явдал байж болохгүй. Орон нутагт ийм зүйл ажиглагддаг. Үүнийг таслан зогсоох ёстой. Төрийн чиг, үүргийг хэрэгжүүлж байгаагаа умартаж болохгүй. Сонгуулийн хороонд ажиллаж байгаа хүн нэг нэр дэвшигч, нэг намын төлөө явна гэдэг байж боломгүй зүйл.

Та дандаа сонгогчийн боловсролын тухай ярилаа. Магадгүй багш мэргэжилтэй тань холбоотой юу?

Сая хэд хэдэн сургалт явуулахдаа олзуурхсан зүйл нь залуус бидний мэдээллийг маш соргоогоор, амьдралд ойрхноор хүлээж авч, шууд хэрэгжүүлэхээр сонирхож байсан явдалд багш хүний хувьд баярласан. Залуу үе өөр юм. Тэд ихэд сонирхож, идэвхтэй оролцсон. Мөрийн хөтөлбөрт дүн шинжилгээ хийж суралцсан. Үндсэн хууль дахь төрийн байгуулалтын бүтцээс эхлээд заахад хялбархан ойлгож, тусгаж авч байсан. Ойлгож эхэлсэн. Ингэж ойлгуулах нь их чухал.

Сонгуулийн санал авах өдрийн өглөө таны хувьд хэрхэн эхэлдэг вэ?

Сонгууль бол төрт ёсоо сонгодог, төрөө байгуулдаг онцгой үйл явц. Бидний ахмад үе, бидний үе, биднээс доошоо үе төрийн маш том ажил явагдаж байна гэж ойлгож, хүндэтгэлтэй хандаж, сонгуульдаа ирж оролцдог. Зах зээлийн үед залуучууд завгүй, завтай нь архи

дарс хэрэглэж, зугаа цэнгэлд хугацаа зарцуулдаг сөрөг байдал ажиглагддаг. Нэгэнт төрт ёсоо сонгож буй, төрөө байгуулж байгаа хүнийг гаднаас харахад ажиглагддаг. Өмссөн хувцас, оролцож байгаа оролцоо, цагаа барьж байгаа байдал зэрэг нь ухамсарласан хүнийх арай өөр. Санал авах хугацаа дуусаж байхад албаар очер дараалал үүсгээд үймүүлдэг, үйл ажиллагааг нь саармагжуулах үзэгдэл ажиглагдах нь ч бий. Бид төрт ёсны уламжлал, төрөө байгуулж буй үйл явцад хүндэтгэлтэй хандаж, иргэдэд зөв ойлголт өгөх нь чухал.

Сонгуулийн хороог ахлах үед үүнийг л би, бид хийсэн дээ гэх бахархал нь юу бол?

Сонгууль бол төрийн ажил юм. Төрийн ажлыг бид нугалдаг. Аймгийн сонгуулийн хороог удирдаж, хэсгийн хороодод заавар, зөвлөгөө өгч явдаг хүний хувьд аль болох сонгогчийн боловсрол талдаа илүү анхаарч, шат шатны сонгуулийн хороодод ажиллаж байгаа хүмүүст бүгдээрээ сонгогчдын идэвхтэй оролцоог нэмэх, нэр дэвшигчид хэн байх хамаагүй уулзалтад нь оролцож, “Та нар сонгуульдаа идэвхтэй оролцоорой” гэж сургалт, сурталчилгаа нөлөөллийн үйл ажиллагаа олонтаа зохион байгуулж гэмээнэ илүү үр дүн гарна.

УИХ-ын сонгуулийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаар Та ямар байр суурьтай байгаа вэ?

Сонгуулийн тогтолцоон өөрчлөлт оруулах ёстой. Тойрог том байх нь чухал. Жижиг тойрогт хууль бус үйлдэл их гардаг. Энэ нь Орон нутгийн сонгуульд ч бас хамааралтай.

*Ярилцсан: З.Бадмаарга
/Сонгуулийн ерөнхий хорооны
Хэвлэлийн төлөөлөгч/*



Э.Тунгалаг

СОНГУУЛИЙН НЭЭЛТТЭЙ ӨГӨГДӨЛ ХӨГЖҮҮЛЭХ НЬ ЧУХАЛ

“Тунгаахуй өгөгдлийн урлан” ХХК-ийг үүсгэн
байгуулагч Э.Тунгалагтай ярилцлаа.

**Сонгуулийн ерөнхий хороо
“Нээлттэй нийгэм форум”-ын
дэмжлэгтэйгээр сонгуулийн
дата, нээлттэй өгөгдлийг сонгогч,
судлаачдад хүргэх, хүртээмжтэй
болгох чиглэлээр танайхтай
хамтран ажиллаж байна. Үр дүнг
хэрхэн төсөөлж байгаа вэ?**

Төрийн өгөгдлийг нээлттэй өгөгдөл болгох, нээлттэй өгөгдлийг бодит хэрэглээнд оруулах үйл явц бол шинэ тутам зүйл. Хэрэглэгч, нийлүүлэгчийн хэн хэн нь энэ талын ур чадвар, хүний нөөц хомс, мэргэжлийн оролцогч талуудын оролцоо зайлшгүй шаардлагатай нь анзаарагдсан тул “Тунгаахуй өгөгдлийн урлан” ХХК “Нээлттэй нийгэм форум” ТББ-ын дэмжлэгээр төрийн нээлттэй өгөгдлийг хөгжүүлэх, чанар, хүртээмжийг сайжруулах, бодит хэрэглээг бий болгох, нээлттэй өгөгдөлд суурилсан нээлттэй засаглалыг дэмжих зорилготой “Нээлттэй өгөгдөлд суурилсан нээлттэй засаглалыг бэхжүүлэх нь” төслийг 2022 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Энэ төслийн хүрээнд төрийн жишиг нээлттэй өгөгдлийг хөгжүүлэх зорилгоор Сонгуулийн ерөнхий хороотой хамтран ажиллах чиглэл баталж, 2023 оны 1 дүгээр сараас хамтын ажиллагааг эхлүүлсэн. Сонгуулийн ерөнхий хороонд техникийн туслалцаа үзүүлэх замаар сонгуулийн нээлттэй өгөгдлийн хамрах хүрээ, чанар, хүртээмжийг сайжруулах, стандартжуулах, нээлттэй өгөгдлийн бүтээгдэхүүн хөгжүүлэхээр ажиллаж байна.

Сонгуулийн нээлттэй өгөгдлийг хөгжүүлэхийн тулд боломжит нээлттэй өгөгдлийг тодорхойлохоос ажиллаа эхэлсэн. Тухайлбал, сонгуулийн өгөгдлийн урсгал, нийлүүлэлтийг тодорхойлох, бэлэн байдлыг үнэлэх, эрэлтийг судалж, боломжит өгөгдлийн бүрдлийн жагсаалт гаргах зэргийг гүйцэтгэлээ. Дараагийн шатанд өгөгдлийг бэлтгэх буюу өгөгдлийг нэгтгэх, шалгах, цэвэрлэх, цаашлаад өгөгдлийн тодорхойлолт, мета өгөгдөл буюу өгөгдлийн тухай өгөгдлийг үүсгэх, өгөгдлийн стандартыг тодорхойлно. Дараа нь бэлэн болсон чанартай өгөгдлийг Сонгуулийн ерөнхий хорооны цахим хуудас, төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн порталд нийтлэх зэргээр шат дараатай төлөвлөн ажиллаж байна. Нээлттэй өгөгдлийн бодит хэрэглээг дэмжих зорилгоор өгөгдлийн бүтээгдэхүүн хөгжүүлнэ. Бид одоогоор сонгуулийн нээлттэй өгөгдлийн дүрслэлийг хөгжүүлсэн. Цаашлаад сонгуулийн нээлттэй өгөгдлийн тайлан, порталыг хөгжүүлэх болно.

**Сонгуулийн нээлттэй өгөгдлийг
хөгжүүлэхийн ач холбогдол юунд
оршдог бол?**

Сонгуулийн нээлттэй өгөгдлийг хөгжүүлснээр төрийн жишиг нээлттэй өгөгдлийг бий болгоно. Ингэснээр төрийн бусад байгууллага туршлага судлах, бодит жишээг харах боломж бүрдэнэ. Мөн стандартын дагуу нийтэлсэн нээлттэй өгөгдлийг

ашиглан сонгуулийн үйл явцад шинжилгээ хийх, хяналт тавих өргөн боломж нээгдэх юм.

Нээлттэй өгөгдлийн салбарын эрх зүйн орчин дөнгөж бүрэлдэж буй энэ цаг үед нэг талаас нээлттэй өгөгдлийн бодлогын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх замаар нээлттэй өгөгдлийн салбарыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах, нөгөө талаас нээлттэй өгөгдлийн бодит хэрэглээг сурталчлах, засаглалыг нээлттэй, ил тод, иргэдийн оролцоотой байлгахад нээлттэй өгөгдлийг хэрэглэх соёлыг бий болгоход дэмжлэг үзүүлнэ гэж итгэж байна.

Цаг хугацааны хувьд хамтын ажиллагааг хэрэгжүүлж эхэлсэн 2023 он нь сонгуулийн өмнөх жил тул бидний бий болгосон нээлттэй өгөгдөл сонгуулийн үйл ажиллагааг угтсан хэлэлцүүлгүүдэд ашиглах, ирэх оны сонгуулийн өгөгдлүүдийг стандартын дагуу нээлттэй өгөгдөл хэлбэрээр шуурхай нийтлэх боломж бүрдэж буй нь ач холбогдолтой.

Сонгуулийн нээлттэй өгөгдөлд суурилсан өргөн хүрээний бүтээгдэхүүн хөгжүүлэх, судалгаа хийх, сонгогчдын боловсрол болон сонгуулийн асуудлаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэхэд нээлттэй өгөгдлийг ашиглах, сонгуулийн нээлттэй өгөгдлийг өргөжүүлэх, тухайлбал орон нутгийн сонгуулийн архивын мэдээллийг нээлттэй өгөгдөл болгон хувиргах зэрэгт урт хугацаанд хамтран ажиллана гэдэгт найдаж байна.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 12 сарын 20 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийг зохион байгуулж явуулах үндсэн зарчим, журмыг тодорхойлж, түүнтэй холбогдсон харилцааг зохицуулах, Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хангахад оршино.

2 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хууль тогтоомж

2.1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

- 3.1.1."18 нас хүрсэн" гэж тухайн иргэний төрсөн он, сар, өдрөөс тоолоход сонгуулийн санал авах өдөр буюу түүнээс өмнө тухайн насанд хүрсэн байхыг;
- 3.1.2."25 нас хүрсэн" гэж тухайн иргэний төрсөн он, сар, өдрөөс тоолоход сонгуулийн санал авах өдөр буюу түүнээс өмнө тухайн насанд хүрсэн байхыг;
- 3.1.3."нэр дэвшигч" гэж 25 нас хүрсэн, энэ хуульд заасны дагуу Монгол Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшин бүртгүүлж, нэр дэвшигчийн үнэмлэх авсан Монгол Улсын иргэнийг;
- 3.1.4."итгэмжлэгдсэн ажилтан" гэж улсын бүртгэлийн байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж байгаа төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийг;
- 3.1.5."итгэмжилсэн хүн" гэж сонгогч өөрөө тухайлан сонгож, санал өгөхөд нь унших, бичих хэлбэрээр туслалцаа үзүүлэх чадвартай, насанд хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай иргэнийг;
- 3.1.6."сонгогч" гэж сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг;
- 3.1.7."сонгуулийн эрх бүхий иргэн" гэж Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх хэсэгт заасан 18 насанд хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай Монгол Улсын иргэнийг;
- 3.1.8."сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн болох нь тогтоогдсон" гэж сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн болохыг хуульд заасны дагуу тогтоож, энэ тухай холбогдох байгууллагын шийдвэр гарсан байхыг;
- 3.1.9."цахим хуудас" гэж бүх төрлийн контентыг интернэтийн домэйн нэр ашиглан хэрэглэгчид хүргэдэг программ хангамжийг;
[/Энэ заалтаас "болон цахим орчин дахь олон нийтийн сүлжээг" гэснийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хассан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)
- 3.1.10."ял эдэлж байгаа" гэж Эрүүгийн хуулийн 5.2 дугаар зүйлд заасан үндсэн болон нэмэгдэл ялыг эдэлж дуусаагүй, эсхүл торгох ялыг биелүүлээгүй байхыг ойлгоно.

4 дүгээр зүйл.Монгол Улсын Их Хурлын сонгууль

4.1.Монгол Улсын Их Хурлын сонгууль нь /цаашид "сонгууль" гэх/ Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, төрийн эрх барих дээд байгууллагыг өөрсдийн төлөөллөөр бүрдүүлж байгаа үндсэн арга мөн.

4.2.Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

4.3.Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын 126 гишүүнийг дараах байдлаар сонгоно:

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

4.3.1.Улсын Их Хурлын 78 гишүүнийг энэ хуульд заасны дагуу байгуулагдсан сонгуулийн тойргоос олныг төлөөлөх /мажоритар/ аргаар;

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

4.3.2.Улсын Их Хурлын 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх /пропорционал/ аргаар.

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

Тайлбар: "олныг төлөөлөх /мажоритар/ арга" гэж тухайн тойрогт ногдох мандатын тоотой тэнцүү бөгөөд хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцохыг ойлгоно.

"хувь тэнцүүлэн төлөөлөх /пропорционал/ арга" гэж сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвслийн авсан саналынх нь тоо, хувьд үндэслэн энэ хуульд заасны дагуу суудал хуваарилж, Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцохыг ойлгоно.

[/Энэ тайлбарыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

4.4. Сонгууль ээлжит, ээлжит бус, нөхөн сонгууль гэсэн төрөлтэй байна.

4.5. "Ээлжит сонгууль" гэж Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар дөрвөн жил тутам явагдах сонгуулийг ойлгоно.

4.6. "Ээлжит бус сонгууль" гэж Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин хоёрдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт зааснаар Улсын Их Хурал өөрөө тарах шийдвэр гаргасан, эсхүл Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах шийдвэр гаргасан тохиолдолд явагдах сонгуулийг ойлгоно.

[/Энэ хэсэгт "2" гэсний дараа "3" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

4.7. "Нөхөн сонгууль" гэж энэ хуулийн 77.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүний орон гарсан суудлыг нөхөх зорилгоор явагдах сонгуулийг ойлгоно.

[/Энэ хэсэгт "Нөхөн сонгууль" гэж гэсний дараа "энэ хуулийн 77.2-т заасны дагуу" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

4.8. Санал хураалт нэмэлт, дахин санал хураалт гэсэн төрөлтэй байна.

4.8.1. "нэмэлт санал хураалт" гэж энэ хуулийн 78 дугаар зүйлд заасны дагуу явагдах санал хураалтыг;

4.8.2. "дахин санал хураалт" гэж энэ хуулийн 79 дүгээр зүйлд заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд явагдах санал хураалтыг.

5 дугаар зүйл. Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрх

5.1. Сонгуулийн эрх бүхий Монгол Улсын иргэн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлагдахгүйгээр сонгох эрхтэй.

5.2. Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яам, Олон улсын байгууллагын дэргэд суугаа Монгол Улсын Байнгын Төлөөлөгчийн газар, Монгол Улсын Ерөнхий консулын газар, Консулын газар, Консулын төлөөлөгчийн газар /цаашид "Дипломат төлөөлөгчийн газар" гэх/ байрладаг гадаад улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэн сонгуульд оролцож, санал өгөх эрхтэй.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

5.3. 25 насанд хүрсэн, сонгуулийн эрх бүхий, энэ хуульд заасан шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдох эрхтэй.

[/Энэ хэсгийн "5.2" дугаарыг "5.3" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

5.4. Сонгогч саналаа нууцаар гаргах ба хөндлөнгийн нөлөөгүйгээр хүсэл зоригоо илэрхийлж саналаа өгөх боломжоор хангагдсан байна.

[/Энэ хэсгийн "5.3" дугаарыг "5.4" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

5.5. Эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон, эсхүл хорих ял эдэлж байгаа Монгол Улсын иргэн сонгуульд оролцох эрх эдлэхгүй.

[/Энэ хэсгийн "5.4" дугаарыг "5.5" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

5.6. Иргэний сонгох, сонгогдох эрхийг хууль бусаар хязгаарлах, сонгогчоос саналаа чөлөөтэй өгөхөд нь хөндлөнгөөс нөлөөлөх, саад учруулахыг хориглоно.

[/Энэ хэсгийн "5.5" дугаарыг "5.6" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

6 дугаар зүйл. Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлэх эрх

6.1. Энэ хуульд заасны дагуу сонгууль төвлөн зарлахаас өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам сонгуульд оролцож, энэ хуульд заасан шаардлага хангасан Монгол Улсын иргэнийг Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй.

[/Энэ хэсгийн "Энэ хуульд заасны дагуу сонгууль төвлөн зарлахаас өмнө ..." гэснийг Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон./](#)

6.2. Сонгуульд намууд эвсэл байгуулан оролцож, нэр дэвшүүлж болно.

6.3. Эвсэлд нэгдсэн бүх нам энэ хуулийн 6.1-д заасан шаардлагыг хангасан байна.

6.4. Энэ хуульд заасан шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн Улсын Их Хурлын гишүүнд бие даан нэрээ дэвшүүлэх эрхтэй.

7 дугаар зүйл. Сонгуулийн зарчим

7.1. Сонгуулийн зарчим нь Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хангахад үндэслэнэ.

7.2. Сонгууль бүх нийтийн байх бөгөөд түүнд сонгогч бүр оролцох эрхтэй.

7.3. Сонгогч сонгуульд шууд сонгох эрхийнхээ үндсэн дээр ямар нэг төлөөлөлгүйгээр оролцож, саналаа нууцаар гаргана.

7.4. Сонгууль зохион байгуулах төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, түүний албан тушаалтан, нэр дэвшигч, сонгуульд оролцогч нам, эвсэл, бусад байгууллага, түүний албан тушаалтан сонгууль зохион байгуулах, түүнд оролцоходоо дараах зарчмыг баримтална:

7.4.1. хууль дээдлэх;

7.4.2. ил тод байдлыг хангах;

7.4.3. шударга ёсыг сахих.

7.5. Сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зарчим нь сонгогч саналаа нууцаар гаргахад хамаарахгүй.

8 дугаар зүйл. Сонгуулийн үйл ажиллагааг автоматжуулах

8.1. Сонгуулийн үйл ажиллагааг автоматжуулахтай холбогдсон харилцааг Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулиар зохицуулна.

9 дүгээр зүйл. Сонгууль төвлөн зарлах

9.1. Улсын Их Хурал ээлжит сонгуулийг сонгуулийн жилийн 02 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө төвлөн зарлаж, санал авах өдрийг тогтооно.

9.2. Ээлжит сонгуулийн санал авах өдөр нь ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын сүүлийн хагасын аль нэг ажлын өдөр байна.

9.3. Гадаад улсад байгаа иргэдээс санал авах өдөр /цаашид "гадаадад санал авах өдөр" гэх/-ийг сонгуулийн төв байгууллага /цаашид "Сонгуулийн ерөнхий хороо" гэх/-ын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтоох бөгөөд гадаадад санал авах өдөр нь дөрөв хүртэл өдөр байна.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

9.4. Ээлжит болон ээлжит бус сонгуулийн санал авах өдөр бүх нийтээр амарна.

[/Энэ хэсгийн "9.3" дугаарыг "9.4" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

[/Энэ хэсэгт "Ээлжит" гэсний дараа "болон ээлжит бус" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01](#)

[дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

9.5.Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болсны улмаас ээлжит сонгууль явуулах боломжгүй болсон бол Улсын Их Хурал ээлжит сонгуулийг хойшлуулж болно.

[/Энэ хэсгийн "9.4" дугаарыг "9.5" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

9.6.Сонгууль товлон зарласны дараа энэ хуулийн 9.5-д заасан онцгой нөхцөл бий болсон тохиолдолд Улсын Их Хурал ээлжит сонгуулийн үйл ажиллагааг зогсоож болно.

[/Энэ хэсэгт "9.4-г" гэснийг "9.5-д" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

[/Энэ хэсгийн "9.5" дугаарыг "9.6" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

9.7.Улсын Их Хурал энэ хуулийн 9.5, 9.6-д заасан онцгой нөхцөл арилсны дараа 10 хоногийн дотор, санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө ээлжит сонгуулийг товлон зарлана.

[/Энэ хэсэгт "9.4, 9.5-д" гэснийг "9.5, 9.6-д" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

[/Энэ хэсгийн "9.6" дугаарыг "9.7" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

[/Энэ хэсэгт "ажлын долоон өдөрт багтаан" гэснийг "10 хоногийн дотор" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

9.8.Улсын Их Хурал энэ хуулийн 9.7-д заасан хугацаанд ээлжит сонгуулийг товлон зарлаагүй бол Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 35.5-д заасны дагуу сонгуулийг зохион байгуулна.

[/Энэ хэсэгт "9.6-д" гэснийг "9.7-д" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

[/Энэ хэсгийн "9.7" дугаарыг "9.8" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

[/Энэ хэсэгт 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

9.9.Улсын Их Хурал ээлжит бус сонгуулийг санал авах өдрийн хамт санал авах өдрөөс 70-аас доошгүй хоногийн өмнө ээлжит бус сонгууль явуулах нөхцөл байдал үүссэнээс хойш ажлын 10 өдрийн дотор энэ хуульд нийцүүлэн товлон зарлана.

[/Энэ хэсгийн "9.8" дугаарыг "9.9" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

9.10.Улсын Их Хурал нөхөн сонгуулийг санал авах өдрийн хамт санал авах өдрөөс 70-аас доошгүй хоногийн өмнө нөхөн сонгууль явуулах нөхцөл байдал үүссэнээс хойш 50 хоногийн дотор энэ хуульд нийцүүлэн товлон зарлана.

[/Энэ хэсгийн "9.9" дугаарыг "9.10" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

9.11.Сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах цаг хугацааны хуваарийг Сонгуулийн ерөнхий хороо батална.

[/Энэ хэсгийн "9.10" дугаарыг "9.11" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

10 дугаар зүйл. Сонгуулийн үйл ажиллагааны эдийн засгийн баталгаа

10.1.Сонгууль зохион байгуулахтай холбогдсон дараах зардлыг Сонгуулийн ерөнхий хорооны төсөвт тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлнэ:

10.1.1.сонгуулийн байгууллагын үйл ажиллагааны зардал;

10.1.2.нэр дэвшигч, нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, нэр дэвшигчийн шадар туслагч, менежер, ухуулагч болон сонгуулийн ажиглагчийн үнэмлэх, тээврийн хэрэгслийн таних тэмдэг, саналын хуудас, сонгуулийн дүн, мэдээний маягт, аймаг, сум, нийслэл, дүүргийн сонгуулийн болон хэсгийн хороо, төв комисс, салбар комисс /цаашид "сонгуулийн хороо" гэх/-ны албан бичгийн хэвлэмэл хуудас, үнэмлэх, батламж хэвлүүлэх, төрийн далбаа, тэмдэг хийлгэх, бэлтгэх, хүргэх зардал;

[/Энэ заалтад 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ заалтад "хороо" гэсний дараа ", төв комисс, салбар комисс" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

10.1.3.санал авах, тоолох, дүн гаргах ажиллагаанд хэрэглэх техник, тоног төхөөрөмж, тэдгээрийн сэлбэг хэрэгсэл, программ хангамж, сонгогч санал өгснийг тэмдэглэх бэх, түүний дагалдах хэрэгсэл, санал тэмдэглэх хэрэгсэл худалдан авах, түрээслэх, ашиглах, хамгаалах, хадгалах, засвар үйлчилгээ хийх, тээвэрлэх, даатгал, лицензийн төлбөр, санал хураалтын дүн болон ирцийн мэдээ дамжуулах зардал;

[/Энэ заалтад "дүнгийн" гэснийг "дүн болон ирцийн" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

[/Энэ заалтад "программ хангамж" гэсний дараа ", сонгогч санал өгснийг тэмдэглэх бэх, түүний дагалдах хэрэгсэл," гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

10.1.4.саналын нууцлалыг хангах зориулалт бүхий хавтас, брайль хавтас, дугтуй, саналын хуудасны уут, лац болон тэдгээрийг худалдан авах, тээвэрлэх, энэ хуульд заасан олон улсын буухиа шуудангийн зардал;

[/Энэ заалтад "тээвэрлэх" гэсний дараа ", энэ хуульд заасан олон улсын буухиа шуудангийн" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

10.1.5.саналын хайрцаг хийх, хүргэх, сонгуулийн хэсгийн хороодын ажиллах болон санал авах байр бэлтгэх зардал;

10.1.6.сонгуулийн тухай хууль тогтоомж болон сонгууль зохион байгуулахтай холбогдсон эрх зүйн бусад акт, гарын авлага, сургалт, сурталчилгааны материал боловсруулах, хэвлэх, хүргэх, архивын баримт үүсгэх, устгах зардал;

10.1.7.сонгуулийн тухай хууль тогтоомжийг сурталчлах болон сонгууль зохион байгуулах, түүний бэлтгэл ажлын явц, хугацааны талаар сонгогчдыг мэдээллээр хангах арга хэмжээ, түүнд холбогдох тоног төхөөрөмж, ажил, үйлчилгээний зардал;

[/Энэ заалтад "хэмжээний" гэснийг "хэмжээ, түүнд холбогдох тоног төхөөрөмж, ажил, үйлчилгээний" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

10.1.8.байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагад ажиллах ажилтанд гэрчилгээ олгох сургалт зохион байгуулах зардал;

- 10.1.9.сонгууль зохион байгуулахтай холбогдсон сургалтын зардал;
- 10.1.10.сонгуулийн хороодын ажилтан, мэдээллийн технологийн багийн болон ажлын хэсгийн гишүүн, даамал, нөөц даамлын ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал;
- 10.1.11.сонгуулийн хороодын бичиг хэрэг, шуудан, холбоо, унаа, албан томилолтын зардал;
- 10.1.12.онцгой нөхцөл байдал үүссэн үед гарч болзошгүй зардал;
- 10.1.13.дахин болон нэмэлт санал хураалт явуулах зардал;
- 10.1.14.гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажиллагааг зохион байгуулахтай холбогдон гарах зардал;
- /Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./
- 10.1.15.энэ хуулийн 46, 47 дугаар зүйл, 48.9, 48.10-т заасан сонгуулийн сурталчилгаанд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулахтай холбогдон гарах зардал;
- [/Энэ заалтын "10.1.14" дугаарыг "10.1.15" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)
- [/Энэ заалтад "46, 47, 48.9-д" гэснийг "46, 47 дугаар зүйл, 48.9, 48.10-т" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)
- 10.1.16.сонгууль зохион байгуулахтай холбогдон гарах бусад зардал.
- [/Энэ заалтын "10.1.15" дугаарыг "10.1.16" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)
- 10.2.Сонгууль зохион байгуулахтай холбогдсон дараах зардлыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тухайн жилийн төсөвт тусган батлуулж, улсын төсвөөс санхүүжүүлнэ:
- 10.2.1.сонгогчийг бүртгэх, түүнийг таньж оруулах техник хэрэгсэл, сэлбэг, программ хангамж худалдан авах, түрээслэх, ашиглах, хадгалах, хамгаалах, засвар үйлчилгээг хийх, тээвэрлэх, даатгал хийлгэх зардал, лицензийн төлбөр;
- 10.2.2.сонгогчийн нэрийн жагсаалт үйлдэх, түүнийг цахим хуудаст байршуулах, хэвлэх, хүргэх, мэдээлэл, сурталчилгаа явуулах, түүнтэй холбогдон гарах бусад зардал;
- 10.2.3.улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн болон гэрээт ажилтны мөнгөн урамшуулал, хоол, холбоо, унаа, томилолтын зардал;
- 10.2.4.улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн болон гэрээт ажилтны сургалт зохион байгуулах, түүнтэй холбогдон гарах бусад зардал;
- 10.2.5.сонгогчийг бүртгэх техник хэрэгслийн аюулгүй байдлыг хангах, хамгаалалтын ажилтны томилолт, унааны зардал, техник тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах үүрэг бүхий мэдээллийн технологийн шуурхай багийн мөнгөн урамшуулал, хоолны зардал;
- 10.2.6.онцгой нөхцөл байдал үүссэн үед гарч болзошгүй зардал;
- 10.2.7.сонгуулийг зохион байгуулахтай холбогдон гарах бусад зардал.
- 10.3.Сонгууль зохион байгуулахтай холбогдсон дараах зардлыг цагдаагийн байгууллагын тухайн жилийн төсөвт тусган батлуулж, улсын төсвөөс санхүүжүүлнэ:
- 10.3.1.саналын хуудас хэвлүүлэх, хадгалах, хамгаалах, хүргүүлэх үеийн хамгаалалт, санал авах байр болон зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах, дүн дамжуулах үеийн хамгаалалт, шатахуун, техник хэрэгслийн зардал;
- 10.3.2.цагдаагийн алба хаагчийн мөнгөн урамшуулал, хоол, холбоо, унаа, томилолтын зардал.
- 10.4.Төрийн аудитын дээд байгууллага, батлан хамгаалах болон архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, улсын хил хамгаалах, онцгой байдлын, тагнуулын, төрийн тусгай хамгаалалтын, шударга өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, сум, дүүрэг нь сонгуулийн үйл ажиллагаатай холбогдон гарах зардлаа тухайн жилийн төсөвтөө тусган батлуулсан байна.
- [/Энэ хэсгээс "улсын төсвөөс санхүүжих" гэснийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хассан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)
- [/Энэ хэсэгт "дээд байгууллага" гэсний дараа ", батлан хамгаалах болон архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, улсын хил хамгаалах, онцгой байдлын, тагнуулын, төрийн тусгай хамгаалалтын, шударга өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)
- 10.5.Сонгууль зохион байгуулахтай холбоотой нэмэлт зардал шаардлагатай тохиолдолд Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн Төсвийн тухай хуульд нийцүүлэн Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална.
- 10.6.Ээлжит бус болон нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдон гарах энэ хуулийн 10.1, 10.2, 10.3, 10.4-т заасан байгууллагын зардлыг Улсын Их Хурал тухай бүрд нь баталж улсын төсвөөс санхүүжүүлнэ.
- 10.7.Ээлжит бус болон нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдон гарах энэ хуулийн 10.6-д заасан зардлыг Засгийн газрын нөөц сангаас гаргана.
- 10.8.Энэ хуулийн 10.1, 10.2, 10.3, 10.4, 10.5, 10.6, 10.7-д заасан зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд төрийн аудитын байгууллага хяналт тавин, аудит хийж, дүгнэлт гаргана.
- 10.9.Энэ хуулийн 10.1, 10.2, 10.3, 10.4-т заасан зардлын зарцуулалт, гүйцэтгэлийн тайланг ээлжит сонгуулийн жилийн 10 дугаар сарын 15-ны дотор, ээлжит бус нөхөн сонгуулийн тухайд санал хураалт дууссан өдрөөс хойш 90 хоногийн дотор тус тус гаргаж, төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ.
- 10.10.Сонгуулийн ерөнхий хороо болон аймаг, сум, нийслэл, дүүргийн сонгуулийн хороо батлагдсан төсвийн хэмжээнд сонгуулийг зохион байгуулах, сонгуулийн автоматжуулах хэрэгслийн иж бүрдэл, сонгогчийн бүртгэлийн техник хэрэгсэл болон программ хангамж худалдан авахтай холбогдуулан хувь хүн, хуулийн этгээдтэй сонгон шалгаруулалтгүйгээр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулах ба уг үйл ажиллагаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн зохицуулалтад хамаарахгүй.
- [/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

ХОЁРДУГААР БҮЛЭГ СОНГУУЛИЙН НУТАГ ДЭВСГЭРИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

11 дүгээр зүйл. Сонгуулийн нутаг дэвсгэр, тойрог

- 11.1.Сонгуулийн нутаг дэвсгэр нь Монгол Улсын нутаг дэвсгэр байна.
- 11.2.Энэ хуулийн 4.3.1-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнийг сонгох сонгуулийн нутаг дэвсгэр нь тойрогт хуваагдана.

[/Энэ хэсэгт "Сонгуулийн" гэснийг "Энэ хуулийн 4.3.1-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнийг сонгох сонгуулийн" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

11.3. Сонгогчийн саналыг авах, тоолох зорилгоор тойрог нь хэсэгт хуваагдана.

11.4. Улсын Их Хурлын гишүүнийг энэ хуулийн 4.3.2-т заасан жагсаалтаар сонгох сонгуульд Монгол Улсын нутаг дэвсгэр сонгуулийн нэг тойрог байна.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

12 дугаар зүйл. Сонгуулийн тойрог байгуулах

12.1. Улсын Их Хурал ээлжит сонгуулийн жилийн 02 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө сонгуулийн тойрог /цаашид "тойрог" гэх/-ийг байгуулна.

12.2. Энэ хуулийн 4.6-д заасны дагуу ээлжит бус сонгууль явуулах тохиолдолд Улсын Их Хурал ээлжит бус сонгуулийн санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө энэ хуульд нийцүүлэн сонгуулийн тойргийг байгуулна.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

12.3. Сонгуулийн тойргийг байгуулахдаа аймаг, дүүргийн хүн амын тоо, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарь, газар нутгийн хэмжээ, байршил зэргийг харгалзан байгуулж, тойрогт ногдох мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтооно.

[/Энэ хэсгийн "12.2" дугаарыг "12.3" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

12.4. Тойрогт хамаарах засаг захиргааны нэгж нь нутаг дэвсгэрийн хувьд нэгдмэл, хилийн цэсийн хувьд зэргэлдээ байна.

[/Энэ хэсгийн "12.3" дугаарыг "12.4" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

12.5. Аймаг, нийслэлийн дүүргийн хүн амын тоо нь тойрог байгуулах улсын дунджаас цөөн байвал зэргэлдээ аймаг, нийслэлийн дүүрэгтэй нэг тойрог болгон нэгтгэж болно.

[/Энэ хэсгийн "12.4" дугаарыг "12.5" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

12.6. Сонгуулийн тойргийг ээлжит бус сонгууль явуулахаас бусад тохиолдолд дараагийн ээлжит сонгууль хүртэл өөрчлөхийг хориглоно.

[/Энэ хэсгийн "12.5" дугаарыг "12.6" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

[/Энэ хэсэгт "Ээлжит сонгуулиар байгуулагдсан сонгуулийн тойргийг" гэснийг "Сонгуулийн тойргийг ээлжит бус сонгууль явуулахаас бусад тохиолдолд" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

13 дугаар зүйл. Сонгуулийн хэсэг байгуулах

13.1. Сонгогчдын санал авч, тоолох зорилгоор сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал сонгуулийн хэсэг /цаашид "хэсэг" гэх/-ийг ээлжит сонгуулийн жилийн 03 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө байгуулж, хэсгийн нутаг дэвсгэрийг зарлана.

[/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсэгт "нутаг дэвсгэр, төвийг" гэснийг "нутаг дэвсгэрийг" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

13.2. Хэсэг байгуулахдаа улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг харгалзан иргэний улсын бүртгэлийн мэдээллийн цахим сан дахь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлтэй сонгогчийн тоог үндэслэнэ.

13.3. Хэсэг нь суманд 2000-аас дээшгүй, аймгийн төв болон дүүрэгт 3000-аас дээшгүй сонгогчтой байх бөгөөд нэг хэсэгт байх сонгогчийн тоо 200-аас доошгүй байна.

13.4. Сонгогчдын тооноос хамааран баг, хороог хувааж сонгуулийн хэсэг байгуулж болох бөгөөд хороог бусад хороотой нэгтгэн хэсэг байгуулахыг хориглоно.

13.5. Энэ хуулийн 13.1-д заасны дагуу байгуулагдсан хэсгийн сонгогчдыг онцгой нөхцөл байдлын улмаас зохион байгуулалттайгаар тухайн хэсгээс тусгаарлах, хэсгийг нэгтгэх, шинээр байгуулах асуудлыг санал авах өдрөөс 35-аас доошгүй хоногийн өмнө Сонгуулийн ерөнхий хорооны зөвшөөрлөөр шийдвэрлэж болно.

13.6. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал сонгуулийн хэсгийг байгуулсан өдрөөс хойш гурав хоногийн дотор энэ хуулийн 13.1-д заасан мэдээллийг улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтэст хүргүүлнэ.

[/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсэгт "тав" гэснийг "гурав" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

13.7. Улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтэс энэ хуулийн 13.6-д заасан мэдээллийг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нэгтгэн гурав хоногийн дотор улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

[/Энэ хэсэгт "тав" гэснийг "гурав" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

13.8. Энэ хуулийн 13.6-д заасан мэдээллийг үндэслэн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэсгийн дугаарыг улсын хэмжээнд давхардахгүй байхаар тогтооно.

13.9. Ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш санал авах ажиллагаа дуустал засаг захиргаа, нутаг дэвсгэрийн анхан шатны нэгжийн бүтэц, нэр, дугаарт өөрчлөлт оруулахыг хориглоно.

13.10. Ээлжит сонгуулиар байгуулагдсан хэсгийг энэ хуульд зааснаас бусад тохиолдолд дараагийн ээлжит сонгууль хүртэл өөрчлөхгүй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

14 дүгээр зүйл. Сонгуулийн байгууллага

14.1. Сонгуулийг улсын хэмжээнд Сонгуулийн ерөнхий хороо удирдан зохион байгуулж, аймаг, сум, нийслэл, дүүргийн сонгуулийн болон хэсгийн хороо, гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажлыг зохион байгуулах төв болон салбар комиссыг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.

[/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсэгт "хороог" гэснийг "хороо, гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажлыг зохион байгуулах төв болон салбар комиссыг" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

14.2.Аймаг, сум, нийслэл, дүүргийн сонгуулийн болон хэсгийн хороо, төв комисс, салбар комисс нь байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллага /цаашид "сонгуулийн хороо" гэх/ бөгөөд хэсгийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хорооны бүрэлдэхүүнд хамаарна.

[/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсэгт "болон хэсгийн хороо" гэсний дараа "төв комисс, салбар комисс" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

14.3.Сонгуулийн хороодод нээлттэй сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийг томилон ажиллуулна.

[/Энэ хэсэгт "хороодод" гэсний дараа "нээлттэй" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

14.4.Сонгуулийн хороодод ажиллах ажилтны сургалт зохион байгуулах, гэрчилгээ олгох журмыг Сонгуулийн ерөнхий хороо батална.

14.5.Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороодын даргаар тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дарга, эсхүл Тамгын газрын даргын үүрэг гүйцэтгэгчийг томилно.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

14.6.Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны бүрэлдэхүүнд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны төлөөлөл, цагдаагийн болон улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн байгууллагын дарга орсон байна.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

14.7.Сургалтад хамрагдаж, гэрчилгээ аваагүй төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийг сонгуулийн хороодод томилохыг хориглоно.

[/Энэ хэсгийн "14.5" дугаарыг "14.7" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

14.8.Сонгуулийн хороодын үйл ажиллагаа тэдгээрийг байгуулсан этгээд нь татан буулгах тухай шийдвэр гаргаснаар дуусгавар болно.

[/Энэ хэсгийн "14.6" дугаарыг "14.8" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

14.9.Сонгуулийн хороод шатлан захирагдах зарчмаар ажиллах ба дээд шатны сонгуулийн хорооны бүрэн эрхийнхээ хүрээнд гаргасан шийдвэрийг доод шатны сонгуулийн хороо биелүүлэх үүрэгтэй.

[/Энэ хэсгийн "14.7" дугаарыг "14.9" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

14.10.Дээд шатны сонгуулийн хороо нь доод шатны сонгуулийн хорооны хуульд нийцээгүй шийдвэрийг хүчингүй болгох эрхтэй.

[/Энэ хэсгийн "14.8" дугаарыг "14.10" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

14.11.Дээд шатны сонгуулийн хорооноос бүрэн эрхийнхээ хүрээнд өгсөн үүргийг биелүүлээгүй нь тухайн доод шатны сонгуулийн хороо, түүний бүрэлдэхүүнийг өөрчлөх үндэслэл болно.

[/Энэ хэсгийн "14.9" дугаарыг "14.11" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

14.12.Сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүн сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар байр сууриа илэрхийлэх, сурталчилгаа явуулах, энэ зорилгоор сонгогчоос сонгуулийн эрхээ эдлэхэд болон санал авах, тоолох, дүн дамжуулах ажиллагаанд саад учруулах, бусдыг төлөөлж санал өгөх, гарын үсэг хуурамчаар үйлдэх зэрэг хууль бус аливаа үйлдэл хийх, зохион байгуулах, бусад хэлбэрээр дэмжихийг хориглоно.

[/Энэ хэсгийн "14.10" дугаарыг "14.12" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

14.13.Сонгуулийн ерөнхий хорооноос санал хураалтын дүнгийн талаар албан ёсны мэдээлэл гаргаагүй байхад аливаа этгээд санал хураалтын дүнгийн талаар мэдэгдэл хийхийг хориглоно.

[/Энэ хэсгийн "14.11" дугаарыг "14.13" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

14.14.Сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүн нь Улсын Их Хурлаас баталсан сонгуулийн хорооны гишүүний ёс зүйн дүрмийг баримтлан ажиллана.

[/Энэ хэсгийн "14.12" дугаарыг "14.14" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

14.15.Сонгуулийн хорооноос сонгууль зохион байгуулах, сонгуулийн хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгахад төрийн албан хаагч, нэр дэвшигч, сонгуульд оролцож байгаа нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, түүний ажилтан, нэр дэвшигчийн шадар туслагч, менежер, ухуулагч болон бусад этгээд хөндлөнгөөс оролцох, саад учруулахыг хориглоно.

[/Энэ хэсгийн "14.13" дугаарыг "14.15" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

14.16.Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, аж ахуйн нэгж, бусад байгууллага нь сонгууль зохион байгуулахад энэ хууль холбогдох бусад хуульд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд оролцож, сонгуулийн зохих шатны байгууллагаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлж, тэдгээрийн ажилд туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

[/Энэ хэсгийн "14.14" дугаарыг "14.16" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

14.17.Сонгуулийн нэг тойрогт хоёр ба хэд хэдэн аймаг, дүүрэг багтаж байвал аль олон сонгогчтой аймаг, дүүргийн сонгуулийн хороо нь тухайн тойрог дахь сонгуулийн зохион байгуулалтын ажлыг хариуцна.

[/Энэ хэсгийн "14.15" дугаарыг "14.17" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

14.18.Сонгуулийн хорооны ажиллах байр, санал авах байрыг төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд үнэ төлбөргүй гаргаж өгнө.

[/Энэ хэсгийн "14.16" дугаарыг "14.18" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

14.19.Сонгуулийн хороог аюулгүй байдлыг хангасан ажиллах байр, тээвэр, холбооны болон бусад шаардлагатай хэрэгслээр хангах асуудлыг тухайн шатны Засаг дарга хариуцна.

[/Энэ хэсгийн "14.19" дугаарыг "14.19" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

14.20.Сонгуулийн хороод нь тогтоосон журмын дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

[/Энэ хэсгийн "14.18" дугаарыг "14.20" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

14.21.Энэ хуулийн 14.12-т заасныг зөрчсөн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүнийг сонгуулийн хорооны бүрэлдэхүүнээс хасах бөгөөд энэ нь түүнийг төрийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах үндэслэл болно.

[/Энэ хэсгийн "14.19" дугаарыг "14.21" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

[/Энэ хэсэгт "14.10-т" гэснийг "14.12-т" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

15 дугаар зүйл. Сонгуулийн ерөнхий хорооны бүрэн эрх

15.1.Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийг зохион байгуулж явуулахдаа энэ хууль болон Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

16 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны эрх

16.1.Сонгуулийн ерөнхий хороо санал авах өдрөөс 70-аас доошгүй хоногийн өмнө аймаг, нийслэлийн сонгуулийн хороог тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ирүүлсэн саналыг харгалзан дарга, нарийн бичгийн дарга болон тав, эсхүл долоон гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, нийтэд мэдээлнэ.

[/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

16.2.Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

16.2.1.сонгууль зохион байгуулах ажлыг төлөвлөх, түүнийг зохион байгуулах арга хэмжээг авах;

16.2.2.сонгуулийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;

16.2.3.сум, дүүргийн сонгуулийн хороодын үйл ажиллагааг зохион байгуулалт, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах;

16.2.4.сонгууль зохион байгуулахтай холбогдсон асуудлаар тухайн нутаг дэвсгэр дэх зохих шатны төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, тэдгээрийн удирдах албан тушаалтны мэдээллийг сонсож, шаардлагатай арга хэмжээ авах;

16.2.5.сонгуулийн ерөнхий хорооноос хуваарилсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, зохих журмын дагуу харьяалах сонгуулийн хороодод хуваарилах, зарцуулалтад нь хяналт тавих;

16.2.6.саналын хуудас болон сонгуульд ашиглах техник хэрэгслийг хүргүүлэх, хадгалах үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих;

16.2.7.харьяалах сонгуулийн хороодын шийдвэрийн талаарх өргөдөл, гомдлыг бүрэн эрхийнхээ хүрээнд хянан шийдвэрлэх, хариуг бичгээр өгөх, доод шатны сонгуулийн хорооны хуульд нийцээгүй шийдвэрийг хүчингүй болгох;

16.2.8.санал хураалтын дүн, холбогдох баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан журмын дагуу нэгтгэж, хүргүүлэх;

16.2.9.дахин болон нэмэлт санал хураалтыг хуульд заасны дагуу зохион байгуулах;

16.2.10.сонгууль зохион байгуулахтай холбогдуулан дээд шатны сонгуулийн хорооноос хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд өгсөн үүргийг биелүүлэх;

16.2.11.хуульд заасан бусад эрх.

17 дугаар зүйл. Сум, дүүргийн сонгуулийн хорооны эрх

17.1.Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хороог санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ирүүлсэн саналыг харгалзан дарга, нарийн бичгийн дарга болон гурав, эсхүл таван гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нийтэд мэдээлнэ.

[/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

17.2.Сум, дүүргийн сонгуулийн хороо харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд энэ хуулийн 16.2.1, 16.2.2, 16.2.4, 16.2.9-д зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

17.2.1.харьяалах хэсгийн хорооны үйл ажиллагааг зохион байгуулалт, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах;

17.2.2.аймаг, нийслэлийн сонгуулийн хорооноос хуваарилсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, харьяалах хэсгийн хорооны хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах зардлыг гаргах, зарцуулалтад хяналт тавих;

17.2.3.өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэж, хариуг бичгээр өгөх;

17.2.4.харьяалах хэсгийн хороодоос ирүүлсэн санал хураалтын дүнг нэгтгэж, харьяалагдах аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд хүргэх;

17.2.5.дээд шатны сонгуулийн хорооноос хуульд заасны дагуу өгсөн үүргийг биелүүлэх;

17.2.6.сонгуулийн баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан журмын дагуу гаргаж, харьяалагдах аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд хүлээлгэн өгөх;

17.2.7.саналын хуудас болон сонгуульд ашиглах техник хэрэгслийг хүргүүлэх, хадгалах үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих;

17.2.8.хуульд заасан бусад эрх.

18 дугаар зүйл. Хэсгийн хорооны чиг үүрэг

18.1.Сум, дүүргийн сонгуулийн хороо хэсгийн хороог санал авах өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө дарга болон зургаа, эсхүл найман гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтэд мэдээлнэ.

18.2.Хэсгийн хороо дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

18.2.1.хэсгийн хорооны хаяг, ажиллах цагийн хуваарь, санал авах өдөр, цагийг сонгогчдод мэдээлэх;

18.2.2.санал авах байр, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаг, сонгогчийн бүртгэлийн болон санал авах, тоолох, дүн гаргах, дамжуулах төхөөрөмж /цаашид "санал тоолох төхөөрөмж" гэх/ зэрэг санал авахад шаардлагатай бусад зүйлийг бэлтгэж, сонгогчдын санал авах ажлыг зохион байгуулах;

18.2.3.санал хураалтын дүн танилцуулах, нэн даруй дамжуулах;

18.2.4.сонгуулийн баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан журмын дагуу гаргаж, сум, дүүргийн сонгуулийн хороонд хүлээлгэн

өгөх;

18.2.5.дээд шатны сонгуулийн хорооноос хуульд заасны дагуу өгсөн үүргийг биелүүлэх;

18.2.6.хуульд заасан бусад чиг үүрэг.

18.3.Хэсгийн хорооны дарга хэсгийн хорооны чиг үүрэгт хамаарах ажлыг удирдан зохион байгуулж, хууль зүйн хариуцлагыг хүлээнэ.

18.4.Хэсгийн хороо санал тоолох, дүн гаргах үйл ажиллагаатай холбоотой өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэхгүй.

19 дүгээр зүйл. Сонгуулийн хороодын ажлын зохион байгуулалт

19.1.Сонгуулийн хороод энэ хуульд заасан эрхэд хамаарах асуудлыг хуралдаанаараа хэлэлцэж хуралдаанд оролцсон бүрэлдэхүүний олонхын саналаар шийдвэрлэж, тогтоол гаргана.

19.2.Хуралдаанд сонгуулийн хорооны бүрэлдэхүүний гуравны хоёроос доошгүй нь оролцсон бол тухайн сонгуулийн хорооны хуралдааныг хүчинтэйд тооцно.

19.3.Сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр сонгуулийн хорооны үйл ажиллагаанд оролцохгүй байх, хуралдаанд ирэхгүй байх, таслах, хуралдааныг орхих, хуралдааны тэмдэглэлд гарын үсэг зурахаас татгалзахыг хориглоно.

19.4.Сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүн хуралдааныг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр орхисон тохиолдолд түүнийг хуралдаанд оролцож тухайн асуудлаар татгалзсан санал гаргасанд тооцно.

19.5.Сонгуулийн хорооны тогтоолд тухайн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.

19.6.Тогтоолд тухайн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн даргын аль нэг нь гарын үсэг зураагүй нь уг тогтоолыг хүчингүй, эсхүл хүчин төгөлдөр бус гэж тооцох үндэслэл болохгүй.

19.7.Сонгуулийн хороод санал авах өдрөөс бусад өдөр ажлын цагаар ажиллах бөгөөд шаардлагатай тохиолдолд ажлын бус өдөр болон илүү цагаар ажиллаж болно.

19.8.Сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга хуралдаанаар хэлэлцэх асуудал, хуваарийг долоо хоногоор гаргаж, тухайн сонгуулийн хорооны мэдээллийн самбарт ил тавина.

19.9.Сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас сонгуулийн хорооны үйл ажиллагаа болон хуралдаанд оролцох боломжгүй болсон бол энэ тухайгаа бичгээр болон бусад хэлбэрээр урьдчилан мэдэгдэх үүрэгтэй.

19.10.Энэ хуулийн 19.3-т заасныг зөрчсөн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүнийг сонгуулийн хорооны бүрэлдэхүүнээс хасах асуудлыг тухайн сонгуулийн хороог байгуулсан дээд шатны сонгуулийн хороо гурав хоногийн дотор шийдвэрлэж, нэн даруй нөхөн томилно.

19.11.Сонгуулийн хороо Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан хуралдааны дэг, тэмдэглэл хөтлөх журмыг баримтлах ба сонгуулийн хорооны дарга нь гишүүдийн ажил үүргийн хуваарийг тогтооно.

19.12.Сонгуулийн хорооны хуралдаанд сонгуульд оролцож байгаа нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл, ажиглагчийг байлцуулж болно.

19.13.Сонгуулийн хорооны хуралдааныг ажиглах, дуу болон дүрс бичлэг хийх боломжоор хангах асуудлыг хуралдааны дэгээр зохицуулна.

19.14.Сонгуулийн хорооны хуралдааныг ажиглаж байгаа этгээд нь тухайн сонгуулийн хорооны бүрэн эрхийн асуудалд хөндлөнгөөс оролцох, даргалагчийн зөвшөөрөлгүй үг хэлэх зэргээр хуралдааны хэвийн үйл ажиллагаанд саад учруулахыг хориглоно.

19.15.Сонгуулийн хорооны хуралдааны хэвийн үйл ажиллагаанд саад учруулсан этгээдийг хуралдааны танхимаас нэн даруй гаргана.

19.16.Сонгуулийн хорооны хуралдааны шийдвэрийг нэн даруй нийтэд ил тод мэдээлнэ.

19.17.Сонгуулийн баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан журмын дагуу бүртгэнэ.

19.18.Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны дарга дотоод ажлын асуудлаар захирамж гаргана.

19.19.Сонгуулийн хороодын ажилтныг энэ хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх хугацаанд үндсэн ажлаас нь чөлөөлөх, огцруулах, түүнчлэн өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр ажил, албан тушаалд шилжүүлэхийг хориглоно.

19.20.Төрийн албан хаагчийг сонгуулийн хороонд ажиллах хугацаанд харьяалах байгууллага нь цалинтай чөлөө олгоно.

19.21.Хуульд өөрөөр заагаагүй бол доод шатны сонгуулийн хорооны шийдвэр, сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны талаар дээд шатны сонгуулийн хороонд гомдол гаргаж болох бөгөөд зохих шатны сонгуулийн хороо гомдлыг хүлээж авснаас хойш гурван хоногийн дотор хянан шийдвэрлэж, гомдол гаргагчид хариуг бичгээр мэдэгдэнэ.

19.22.Сонгуулийн хороо сонгууль зохион байгуулахтай холбогдсон, түүнчлэн хууль зөрчсөн тухай асуудлыг шалгуулах, эсхүл зөрчлийг таслан зогсоох асуудлаар сонгуулийн хууль тогтоомжоор үүрэг хүлээсэн аливаа байгууллага, албан тушаалтанд хууль ёсны шаардлага тавих эрхтэй.

19.23.Энэ хуулийн 19.22-т заасан шаардлагыг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан ажлын гурван өдрийн дотор хариуг бичгээр мэдэгдэнэ.

19.24.Сонгуулийн хорооноос бүрэн эрхийнхээ хүрээнд гаргасан шийдвэрийг тухайн нутаг дэвсгэр дэх бүх байгууллага, албан тушаалтан, иргэн биелүүлэх үүрэгтэй.

19' дүгээр зүйл. Гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажлыг зохион байгуулах төв болон салбар комиссын чиг үүрэг

/Энэ зүйлийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

19'.1.Сонгуулийн ерөнхий хороо гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг харгалзан гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажлыг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах, хяналт тавих үүрэг бүхий төв комиссыг гадаадад санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө дарга, нарийн бичгийн дарга болон ес, эсхүл арван нэгэн гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулна.

/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

19'.2.Төв комисс нь салбар комиссыг гадаадад санал авах өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө дарга болон хоёр, эсхүл дөрвөн гишүүний бүрэлдэхүүнтэйгээр Дипломат төлөөлөгчийн газрын дэргэд байгуулна.

/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

19'.3.Төв комиссын дарга дотоод ажлын асуудлаар захирамж гаргана.

/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

19'.4.Төв комиссыг ажиллах байр, нөхцөл, боломжоор хангах үүргийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, салбар комиссыг ажиллах байр, нөхцөл, боломжоор хангах үүргийг тухайн улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар хүлээнэ.

/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

19'.5.Төв комисс нь Сонгуулийн ерөнхий хорооны шууд удирдлагын доор сонгуулийн санал авах ажлыг зохион байгуулна.

/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

19'.6.Салбар комисс нь төв комиссын шууд удирдлагын доор гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажлыг зохион байгуулна.

/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

19¹.7.Төв комисс дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

19¹.7.1.гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажлыг төлөвлөх, түүнийг зохион байгуулах арга хэмжээг авах;

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

19¹.7.2.эрх хэмжээнийхээ хүрээнд сонгуулийн хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгаж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

19¹.7.3.сонгууль зохион байгуулахтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооноос хуульд заасны дагуу өгсөн үүргийг биелүүлэх;

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

19¹.7.4.салбар комиссын үйл ажиллагааг зохион байгуулалт, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах;

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

19¹.7.5.Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн саналын хуудас, сонгууль зохион байгуулах болон санал авахтай холбоотой бусад баримт бичгийг олон улсын буухиа шуудангаар салбар комисст хүргүүлэх;

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

19¹.7.6.шаардлагатай тохиолдолд салбар комисст сургалт зохион байгуулах, төлөөлөгч томилох ажиллуулах;

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

19¹.7.7.Сонгуулийн ерөнхий хорооноос хуваарилсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, салбар комисст хуваарилах, зарцуулалтад нь хяналт тавих, холбогдох журмын дагуу тайлагнах;

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

19¹.7.8.өөрийн эрх хэмжээнд хамаарах асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэж, бичгээр хариуг өгөх;

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

19¹.7.9.санал авах ажлыг зохион байгуулсан тухай тайлан, сонгуулийн бусад баримт бичиг, саналын хуудсыг Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх;

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

19¹.7.10.хуульд заасан бусад чиг үүрэг.

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

19¹.8.Салбар комисс дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

19¹.8.1.салбар комиссын буюу санал авах байрны хаяг, ажиллах цагийн хуваарь, санал авах өдөр, цагийг сонгогчдод мэдээлэх;

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

19¹.8.2.өөрийн байрладаг улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэдийг бүртгэж, сонгогчдын бүртгэлийг гарган төв комисст хүргүүлэх;

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

19¹.8.3.санал авах байр, саналын хайрцаг, санал бэлтгэх бүхээг, санал авахад шаардлагатай бусад зүйлийг бэлтгэж, сонгогчдын санал авах ажлыг зохион байгуулах;

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

19¹.8.4.санал хураалт дууссаны дараа битүүмжилсэн дугтуйтай саналын хуудас, санал авахад зарцуулагдаагүй үлдсэн, хураагдсан, хүчингүй саналын хуудас, санал хураалтын тухай салбар комиссын хуралдааны тэмдэглэл, сонгуулийн бусад баримт бичгийг төв комисст олон улсын буухиа шуудангаар нэн даруй хүргүүлэх;

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

19¹.8.5.өөрийн эрх хэмжээнд хамаарах асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, бичгээр хариуг өгөх;

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

19¹.8.6.дээд шатны сонгуулийн байгууллагаас хуульд заасны дагуу өгсөн үүргийг биелүүлэх;

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

19¹.8.7.хуульд заасан бусад чиг үүрэг.

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТ

20 дугаар зүйл.Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх

20.1.Сонгогчдын нэрийн жагсаалтыг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд үндэслэн үйлдэх бөгөөд түүнийг нягтлан шалгах, давхардлыг арилгах, сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй сонгуулийн эрх бүхий иргэнийг бүртгэх, эдгээртэй холбоотой гомдлыг шийдвэрлэх ажлыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангана.

20.2.Сонгогчдын нэрийн жагсаалтад тухайн хэсгийн нутаг дэвсгэрт байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэл бүхий сонгогчийн эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, нас, хүйс, иргэний бүртгэлийн дугаар, оршин суугаа газрын хаяг гэсэн дарааллаар бичнэ.

[/Энэ хэсэгт 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

20.3.Улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтэс тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн хэсэг байгуулсан нутаг дэвсгэр, төвийн мэдээллийг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан дахь тухайн хэсгийн нутаг дэвсгэрт байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэл бүхий сонгогчийн бүртгэлтэй тулган шалгаж, улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

[/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

20.4.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага сонгогчдын нэрийн жагсаалтад байгаа сонгуулийн эрх бүхий иргэний эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, нас, хүйс, иргэний бүртгэлийн дугаар, байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн мэдээллийг аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хороогоор болон хэсэг нэг бүрээр нэгтгэн гаргах бөгөөд уг жагсаалтыг ээлжит сонгуулийн жилийн 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, сонгууль дуустал өөрийн цахим хуудсанд байршуулна.

[/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

20.5.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага сонгогчийг энэ хуулийн 20.4-т заасан цахим хуудсанд байршуулсан

сонгогчдын нэрийн жагсаалт дахь өөрийн болон өөрийн байнга оршин суугаа хаягийн бүртгэлд бүртгэгдсэн нийт сонгогчийн мэдээлэлтэй танилцах боломжоор хангана.

[/Энэ хэсэгт "жагсаалтаас өөрт нь холбогдох" гэснийг "жагсаалт дахь өөрийн болон өөрийн байнга оршин суугаа хаягийн бүртгэлд бүртгэгдсэн нийт сонгогчийн" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

20.6. Доор дурдсан байгууллага дараах иргэний эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, иргэний бүртгэлийн дугаар, төрсөн он, сар, өдөр, хүйс, бусад шаардлагатай мэдээллийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ээлжит сонгуулийн жилийн 05 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ:

[/Энэ хэсэгт 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсгээс " Сонгуулийн ерөнхий хороо уг мэдээллийг хүлээн авснаас хойш гурав хоногийн дотор улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ" гэснийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хассан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

[/Энэ хэсэгт "Сонгуулийн ерөнхий хороонд" гэснийг "улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

20.6.1.эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон сонгуулийн насны иргэдийн мэдээллийг Улсын дээд шүүх;

20.6.2.хорих ял эдэлж байгаа болон эрүүгийн хэрэгт холбогдуулан баривчлагдсан сонгуулийн насны иргэдийн мэдээллийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага;

[/Энэ заалтаас " захиргааны журмаар албадан эмчлүүлж байгаа болон зөрчлийн хэрэгт холбогдуулан баривчлагдсан" гэснийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хассан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

20.6.3.60 түүнээс дээш хоногийн хугацаагаар гадаад улсад зорчсон иргэдийн мэдээллийг Улсын хил хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;

20.6.4.тухайн сум, дүүргийн нутаг дэвсгэрт байнга оршин суух газрын хаягийн бүртгэлгүй боловч санал авах өдөр харьяа тусгай анги, салбарт нь алба хааж байгаа алба хаагч болон ажилтны мэдээллийг Улсын хил хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;

20.6.5.тухайн сум, дүүргийн нутаг дэвсгэрт байнга оршин суух газрын хаягийн бүртгэлгүй боловч санал авах өдөр зэвсэгт хүчний цэргийн анги, нэгтгэлд алба хааж байгаа алба хаагч болон ажилтны мэдээллийг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

20.6.6.тухайн сум, дүүргийн нутаг дэвсгэрт байнга оршин суух газрын хаягийн бүртгэлгүй боловч тухайн нутаг дэвсгэрт ажиллаж байгаа цагдаагийн алба хаагч, дотоодын цэргийн анги, нэгтгэлд алба хааж байгаа алба хаагч болон ажилтны мэдээллийг цагдаагийн төв байгууллага;

20.6.7.зөрчлийн хэрэгт холбогдуулан баривчлагдсан сонгуулийн насны иргэдийн мэдээллийг цагдаагийн төв байгууллага;

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

20.6.8.тухайн жилд Монгол Улсын харьяат болсон, иргэний харьяаллаа сэргээн тогтоолгосон, харьяатаас гарсан иргэдийн мэдээллийг гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага.

20.7.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 20.6.1, 20.6.2, 20.6.3-д заасны дагуу ирүүлсэн мэдээллийг үндэслэн тухайн сонгогчийг сонгогчдын нэрийн жагсаалтаас хасалгүйгээр "Тайлбар" хэсэгт "Түр хасав" гэсэн нэмэлт тэмдэглэгээ хийх бөгөөд нэмэлт тэмдэглэгээ хийгдсэн тухайн сонгогчийг сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчдын тоонд оруулан тооцохгүй.

[/Энэ хэсгээс " 20.6.7, 20.6.8" гэснийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хассан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

20.8.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 20.6.4, 20.6.5, 20.6.6-д заасны дагуу ирүүлсэн мэдээллийг үндэслэн тухайн нутаг дэвсгэрийн хамаарч байгаа сонгуулийн хэсэгт саналаа өгөх сонгогчдын нэрийн жагсаалтад тухайн сонгогчийг нэмж бүртгэн байнга оршин суугаа газрынх нь хаягийн дагуу бүртгэгдсэн сонгогчдын нэрийн жагсаалтаас хасна.

20.9.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 20.4-т заасны дагуу цахим хуудсанд байршуулсан сонгогчдын нэрийн жагсаалтад дараах өөрчлөлтийг тусган уг жагсаалтыг цаасан болон цахим хэлбэрээр үйлдэж, цаасан хэлбэрээр үйлдсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг санал авах өдрөөс 25-аас доошгүй хоногийн өмнө улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтсээр дамжуулан хэсгийн хороонд хүргүүлнэ:

20.9.1.сонгогчоос энэ хуулийн 20.4-т заасан сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй, эсхүл буруу бүртгэгдсэн талаар гаргасан гомдлын дагуу оруулсан өөрчлөлт;

20.9.2.энэ хуулийн 25 дугаар зүйлд заасан хугацаанаас өмнө хийгдсэн сонгогчийн байнга оршин суугаа газрын хаягийн өөрчлөлт;

20.9.3.сонгогчийн эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, хүйс зэрэг иргэний бүртгэлтэй холбоотой өөрчлөлт;

[/Энэ заалтад 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ заалтаас " иргэний бүртгэлийн дугаар" гэснийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хассан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

20.9.4.нас барсан иргэний улсын бүртгэлтэй холбоотой өөрчлөлт;

20.9.5.энэ хуулийн 20.6-д заасан иргэдийн мэдээлэлтэй холбоотой өөрчлөлт.

20.10.Хэсгийн хороо сонгогчдын нэрийн жагсаалтыг хүлээн авсан өдрөөс эхлэн өөрийн ажиллах байранд, өөрийн ажиллах байргүй бол сум, хорооны Засаг даргын Тамгын газрын байранд итгэмжлэгдсэн ажилтныг ажиллуулж, сонгогчдод өөрийн болон өөрийн байнга оршин суугаа хаягийн бүртгэлд бүртгэгдсэн нийт сонгогчийн мэдээлэлтэй чөлөөтэй танилцах боломж олгоно.

[/Энэ хэсэгт "сонгогч өөрт нь холбогдох" гэснийг "итгэмжлэгдсэн ажилтныг ажиллуулж, сонгогчдод өөрийн болон өөрийн байнга оршин суугаа хаягийн бүртгэлд бүртгэгдсэн нийт сонгогчийн" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

20.11.Сонгогч сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн эсэхээ санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө шалгасан байвал зохино.

20.12.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 20.9-д заасан хугацаанд хүргүүлсэн сонгогчдын нэрийн жагсаалтад энэ хуулийн 20.9.1, 20.9.3, 20.9.4, 20.9.5 дахь заалт, 23, 24 дүгээр зүйлд заасан үндэслэлээр оруулсан өөрчлөлт, гадаад улсад саналаа өгсөн сонгогчдын өөрчлөлтийг тусгаж сонгогчдын нэрийн жагсаалтыг санал авах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтсээр дамжуулан хэсгийн хороонд хүргүүлнэ.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

20.13.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуульд нийцүүлэн гадаад улсад байгаа иргэдийн сонгогчдын нэрийн

жагсаалт үйлдэх, хүргүүлэх журмыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батална.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

20.14. Сонгогчдын нэрийн жагсаалт зөвхөн нэг нэрийн жагсаалтаас бүрдэх бөгөөд энэ хуульд заасныг зөрчин сонгогчдын нэрийн жагсаалт шинээр үйлдэх, түүнд өөрчлөлт оруулахыг хориглоно.

[/Энэ хэсгийн "20.12" дугаарыг "20.14" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

20.15. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага ээлжит сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвслийг төлөөлөх эрх бүхий этгээдийн хүсэлтийн дагуу энэ хуулийн 20.9-т заасан сонгогчдын нэрийн жагсаалтын сонгогчдын эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, иргэний бүртгэлийн дугаар, байнга оршин суугаа газрын хаяг бүхий хэсгийг санал авах өдрөөс 20-иос доошгүй хоногийн өмнө болон санал авах өдрөөс 3 хоногийн өмнө тус тус цахим хэлбэрээр олгоно.

[/Энэ хэсэгт 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсгийн "20.13" дугаарыг "20.15" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

[/Энэ хэсэгт "цахим хэлбэрээр нэг удаа" гэснийг "болон санал авах өдрөөс 3 хоногийн өмнө тус тус цахим хэлбэрээр" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

20.16. Энэ хуульд заасан сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх үйл ажиллагаа болон нэрийн жагсаалттай танилцах, ашиглах журмыг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нийцүүлэн, Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, тагнуулын байгууллага хамтран батална.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

20.17. Сонгогчдын нэрийн жагсаалт цаасан болон цахим хэлбэртэй нэгдсэн нэг сантай байх бөгөөд сонгогчийг сонгуулийн зөвхөн нэг хэсэгт бүртгэнэ.

[/Энэ хэсгийн "20.14" дугаарыг "20.17" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

[/Энэ хэсэгт "хэлбэртэй" гэснийг дараа "нэгдсэн нэг сантай" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

20.18. Сонгогчдын нэрийн жагсаалтыг энэ хуульд зааснаас бусад тохиолдолд хэвлэж тараахыг хориглоно.

[/Энэ хэсгийн "20.15" дугаарыг "20.18" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

[/Энэ хэсэгт "хувилж олшруулах" гэснийг "энэ хуульд зааснаас бусад тохиолдолд хэвлэж" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

20.19. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Сонгуулийн ерөнхий хороотой хамтран сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, нягтлан шалгах, давхардал, зөрчлийг арилгах, танилцуулах, сонгогч шилжих журам болон маягт, загварыг энэ хуульд нийцүүлэн, Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн тагнуулын байгууллагатай хамтран баталж мөрдүүлнэ.

[/Энэ хэсгийн "20.16" дугаарыг "20.19" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

[/Энэ хэсэгт "байгууллага" гэснийг дараа "Сонгуулийн ерөнхий хороотой хамтран" гэж "нийцүүлэн" гэснийг дараа "Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн тагнуулын байгууллагатай хамтран" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

20.20. Энэ хуулийн 20.1-д заасан үйл ажиллагааг зохион байгуулахад төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, холбогдох бусад байгууллага энэ хууль, холбогдох бусад хуульд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд оролцож, улсын бүртгэлийн байгууллагаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлж, туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

[/Энэ хэсгийн "20.17" дугаарыг "20.20" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

20.21. Энэ хуульд заасан журмын дагуу Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн нам, эвсэл, бие даан нэр дэвшигч, төрийн бус байгууллагын төлөөлөл сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх ажиллагаатай танилцаж болно.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

20.22. Гадаад улсад байгаа иргэн гадаадад санал авах өдрөөс таваас доошгүй хоногийн өмнө сонгуульд оролцохоо мэдэгдэж, бүртгүүлнэ.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

21 дүгээр зүйл. Ээлжит бус, нөхөн сонгуулиар сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх

21.1. Сонгогчдын санал авч, тоолох зорилгоор сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг харгалзан иргэний улсын бүртгэлийн мэдээллийн цахим сан дахь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлтэй сонгогчийн тоог үндэслэн хэсгийг ээлжит бус, нөхөн сонгууль товлон зарласнаас хойш 7 хоногийн дотор байгуулж, хэсгийн нутаг дэвсгэрийг зарлана.

[/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсэгт "20" гэснийг "7" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

[/Энэ хэсэгт "нутаг дэвсгэр, төвийг" гэснийг "нутаг дэвсгэрийг" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

21.2. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага сонгогчдын нэрийн жагсаалтыг ээлжит бус, нөхөн сонгууль товлон зарласнаас хойш 14 хоногийн дараагаас эхлэн сонгууль дуустал өөрийн цахим хуудаст байршуулна.

[/Энэ хэсэгт "50" гэснийг "14" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

21.3. Энэ хуулийн 20.6-д заасан байгууллага холбогдох мэдээллийг санал авах өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

[/Энэ хэсэгт "40-өөс доошгүй хоногийн өмнө Сонгуулийн ерөнхий хороонд" гэснийг "45-аас доошгүй хоногийн өмнө улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

[өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.](#)

21.4. Сонгуулийн ерөнхий хороо энэ хуулийн 21.3-т заасны дагуу хүргүүлсэн мэдээллийг хүлээн авсан өдрөөс хойш нэг хоногийн дотор улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

[Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.](#)

21.5. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага сонгогчдын нэрийн жагсаалтад энэ хуулийн 20.9-д заасан өөрчлөлтийг тусгана.

21.6. Энэ хуульд заасан өөрчлөлтийг тусгасан сонгогчдын нэрийн жагсаалтыг цаасан болон цахим хэлбэрээр үйлдэж, цаасан хэлбэрээр үйлдсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг санал авах өдрөөс 5-аас доошгүй хоногийн өмнө улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтсээр дамжуулан хэсгийн хороонд хүргүүлнэ.

[Энэ хэсэгт "хуулийн 21.5-д заасны дагуу" гэснийг "хуульд заасан" гэж, "15-аас" гэснийг "5-аас" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.](#)

21.7. Элжит бус, нөхөн сонгуулиар сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэхэд энэ хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

22 дугаар зүйл. Итгэмжлэгдсэн ажилтан

22.1. Итгэмжлэгдсэн ажилтан улсын бүртгэлийн байгууллагын сургалтад хамрагдсан, төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагч байна.

22.2. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга итгэмжлэгдсэн ажилтны ажиллах орон тооны хязгаарыг батална.

22.3. Итгэмжлэгдсэн ажилтныг тагнуулын байгууллагын саналыг үндэслэн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын орон нутаг дахь газар, хэлтсийн дарга энэ хуулийн 22.2-т заасан хязгаарт багтаан томилоно.

22.4. Итгэмжлэгдсэн ажилтан холбогдох хууль тогтоомжийн дагуу нууцын баталгаа гаргаж сонгогчдын нэрийн жагсаалтыг хэсгийн хороонд хүргүүлсэн өдрөөс эхлэн ажиллана.

22.5. Итгэмжлэгдсэн ажилтан энэ хуульд заасны дагуу сонгогчдын нэрийн жагсаалтын цаасан болон цахим хувилбартай танилцах, өөрчлөлт оруулах, сонгогчийн бүртгэлийг тулган шалгах, санал авах өдөр сонгогчдыг бүртгэх, таньж оруулах, техник хэрэгсэл, программ хангамжийг хариуцан ажиллана.

23 дугаар зүйл. Сонгогчдын нэрийн жагсаалттай холбогдсон гомдлыг шийдвэрлэх журам

23.1. Сонгогч сонгогчдын нэрийн жагсаалт дахь өөрийн болон гэр бүлийн гишүүний мэдээлэлтэй танилцах эрхтэй бөгөөд сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй, эсхүл буруу бүртгэгдсэн бол өөрийн болон гэр бүлийн гишүүний нэрийн өмнөөс гомдлоо итгэмжлэгдсэн ажилтан, эсхүл улсын бүртгэлийн байгууллагад санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө бичгээр болон цахимаар гаргана.

[Энэ хэсэгт "гомдлоо" гэсний дараа "итгэмжлэгдсэн ажилтан, эсхүл" гэж, "бичгээр" гэсний дараа "болон цахимаар" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.](#)

23.2. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санг үндэслэн энэ хуулийн 23.1-д заасны дагуу гомдол гаргасан иргэний мэдээллийн талаар болон иргэний улсын бүртгэлтэй холбоотой өөрчлөлтийн талаар лавлагаа гаргах ба сонгогчийн мэдээлэлтэй холбогдсон өөрчлөлтийг санал авах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө сонгогчдын нэрийн жагсаалтад оруулна.

[Энэ хэсэгт "иргэний мэдээллийн талаар" гэсний дараа "болон иргэний улсын бүртгэлтэй холбоотой өөрчлөлтийн талаар" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.](#)

23.3. Энэ хуульд зааснаас бусад үндэслэлээр сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг хориглоно.

23.4. Итгэмжлэгдсэн ажилтан сонгогчдын нэрийн жагсаалтад "Түр хасав" гэсэн нэмэлт тэмдэглэгээ хийлгэсэн иргэний сонгогчдын нэрийн жагсаалтад нэмэлт тэмдэглэгээ хийлгэсэн шалтгаан арилсан тохиолдолд тухайн сонгогчийн өөрийнх нь хүсэлт, үндэсний гадаад паспорт, холбогдох нотлох баримтыг үндэслэн сонгогчдын нэрийн жагсаалт дахь зохих тэмдэглэгээг хүчингүй болгож, тухайн сонгогчийн бүртгэлийг сэргээн, энэ тухай тэмдэглэл үйлдэн хэсгийн хороонд мэдэгдэнэ.

23.5. Ажиглагч нь сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах талаар энэ хуульд заасан хугацаа дууссанаас хойш сонгогчдын нэрийн жагсаалт болон түүнд оруулсан өөрчлөлттэй танилцах эрхтэй.

23.6. Ажиглагч энэ хуулийн 23.5-д заасны дагуу сонгогчдын нэрийн жагсаалттай танилцахдаа зураг авах, бичлэг хийх зэргээр сонгогчдын нэрийн жагсаалтыг хувилж, олшруулахыг хориглоно.

23.7. Энэ хуулийн 23.5-д заасны дагуу сонгогчдын нэрийн жагсаалтыг танилцуулах үйл ажиллагааг итгэмжлэгдсэн ажилтан болон хэсгийн хорооны дарга хамтран зохион байгуулж, хяналт тавина.

23.8. Сонгуулийн ерөнхий хороо шаардлагатай гэж үзвэл сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой гомдол, мэдээллийн дагуу тухайн гомдол, мэдээллийг шалгахад шаардлагатай мэдээлэл, баримтыг холбогдох байгууллагаас гаргуулан авч, зөрчлийг арилгах асуудлаар эрх бүхий байгууллагад хугацаатай шаардлага хүргүүлэх эрхтэй.

[Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.](#)

24 дүгээр зүйл. Сонгогч шилжих

24.1. Сонгуулийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтан, мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, санал авах байр болон сонгуулийн үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангахаар ажиллаж байгаа цагдаагийн албан хаагчийн сонгогчийн шилжилтийг хийх, бүртгэхдээ тухайн байгууллагынх нь албан бичгийг үндэслэн санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө шийдвэрлэнэ.

24.2. Нэр дэвшигч болон энэ хуулийн 37.3-т заасан менежер, шадар туслагч нь сонгуулийн нэг хэсгээс нөгөө хэсэгт шилжих бол санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө сонгогчийн шилжилтийг хийлгэж болно.

24.3. Энэ хуулийн 24.1, 24.2-т заасан сонгогч санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө сонгогчийн шилжилтийг бүртгүүлнэ.

25 дугаар зүйл. Иргэний шилжилт хөдөлгөөнийг зогсоох

25.1. Иргэний шилжилт хөдөлгөөнийг санал авах өдрөөс 60 хоногийн өмнө зогсоож, санал авах өдрийн дараах өдрөөс сэргээнэ.

[Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.](#)

[Энэ хэсэгт 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан.](#)

25.2. Энэ хуулийн 25.1-д заасан иргэний шилжилт хөдөлгөөнийг зогсоох, сэргээх тухай шийдвэрийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга гаргана.

25.3. Нэмэлт болон дахин санал хураалт явагдах нөхцөл байдал үүссэн тохиолдолд энэ хуулийн 25.1, 25.2-т заасан иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг түр зогсоох хугацааг тухайн нэмэлт болон дахин санал хураалт явагдаж дуусал

үргэлжлүүлж, санал авах өдрийн дараах өдрөөс сэргээнэ.

25.4.Ээлжит бус, нөхөн сонгууль явуулахаар товлон зарласан эрх бүхий байгууллага тухайн шийдвэрийг ажлын гурван өдрийн дотор улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ НАМ, ЭВСЭЛ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ

26 дугаар зүйл. Нам, эвсэл сонгуульд оролцохоо илэрхийлэх

26.1. Нам, эвсэл Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөхөө илэрхийлэн, сонгуульд оролцох тухай зөвхөн нэг хүсэлтээ санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ.

/Энэ хэсэгт "тухай" гэсний дараа "зөвхөн нэг" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

26.2. Сонгуульд оролцох хүсэлтэд нам, эвслийн дарга гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ даран баталгаажуулсан байна. Эвслийн тухайд эвсэлд нэгдэн орсон бүх намууд тамга /тэмдэг/ даран баталгаажуулна.

26.3. Нам сонгуульд оролцох хүсэлтдээ дараах баримт бичгийг хавсаргана:

26.3.1. сонгуульд оролцох тухай намын Их хурал, эсхүл төлөөллийн төв байгууллагын шийдвэр;

26.3.2. намын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

26.3.3. намын улсын бүртгэлд бүртгүүлсэн дүрмийн Улсын дээд шүүхээр баталгаажуулсан хуулбар;

/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

26.3.4. сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүний эдийн засгийн тооцоонд хийсэн төрийн аудитын байгууллагын дүгнэлт;

/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

26.3.5. энэ хуульд нийцсэн нэр дэвшүүлэх ажиллагааны талаарх намын дотоод журам;

26.3.6. ээлжит сонгуулийн жилийн 03 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд, ээлжит бус, нөхөн сонгуулийн тухайд тухайн сонгуулийн жилийн өмнөх тайлант жилийн хугацаанд уг намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын төрийн аудитын байгууллагаар хянуулж баталгаажуулсан тайлан;

/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

26.3.7. намын сонгууль эрхэлсэн байгууллагын бүтэц, бүрэлдэхүүн, хаяг, харилцах утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажиллах хүний тоо зэргийг агуулсан мэдээлэл;

26.3.8. намыг төлөөлж Сонгуулийн ерөнхий хороотой харилцах, нэр дэвшигчдийн бүртгэлийн асуудлыг хариуцан ажиллах гурван хүний эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, хүн тус бүрийн харилцах утасны дугаар, цахим шуудангийн хаяг.

/Энэ заалтад "хороотой харилцах" гэсний дараа "нэр дэвшигчдийн бүртгэлийн асуудлыг хариуцан ажиллах" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

26.3.9. энэ хуулийн 26.2-т заасан шаардлагатай холбоотойгоор нам, намын даргын Улсын дээд шүүхийн лавлагаа, тамга, тэмдгийн улсын бүртгэлийн лавлагаа.

/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

26.4. Эвсэл сонгуульд оролцох хүсэлтдээ энэ хуулийн 26.3.9-д заасан лавлагаа болон дараах баримт бичгийг хавсаргана:

/Энэ хэсэгт "хүсэлтдээ" гэсний дараа "энэ хуулийн 26.3.9-д заасан лавлагаа болон" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

26.4.1. сонгуульд оролцох тухай эвслийг төлөөлөх байгууллагын шийдвэр;

26.4.2. эвсэлд нэгдсэн нам тус бүрийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

26.4.3. эвсэлд нэгдсэн нам тус бүрийн улсын бүртгэлд бүртгүүлсэн дүрмийн Улсын дээд шүүхээр баталгаажуулсан хуулбар;

/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

26.4.4. эвслийг төлөөлөх байгууллагаар батлагдсан сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүний эдийн засгийн тооцоонд хийсэн төрийн аудитын байгууллагын дүгнэлт;

/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

26.4.5. энэ хуульд нийцсэн нэр дэвшүүлэх ажиллагааны талаарх эвслийн дотоод журам;

/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

26.4.6. ээлжит сонгуулийн жилийн 03 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд, ээлжит бус, нөхөн сонгуулийн тухайд тухайн сонгуулийн жилийн өмнөх тайлант жилийн хугацаанд уг намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын төрийн аудитын байгууллагаар хянуулж баталгаажуулсан тайлан;

/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

26.4.7. эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын бүтэц, бүрэлдэхүүн, хаяг, харилцах утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажиллах хүний тоо зэргийг агуулсан мэдээлэл;

26.4.8. эвслийг төлөөлж Сонгуулийн ерөнхий хороотой харилцах, нэр дэвшигчдийн бүртгэлийн асуудлыг хариуцан ажиллах гурван хүний эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, харилцах утасны дугаар, цахим шуудангийн хаяг;

/Энэ заалтад "хороотой харилцах" гэсний дараа "нэр дэвшигчдийн бүртгэлийн асуудлыг хариуцан ажиллах" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

26.4.9. эвслийн гэрээ;

/Энэ заалтад "гэрээний хуулбар" гэснийг "гэрээ" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

26.4.10.эвсэл байгуулах тухай нам тус бүрийн шийдвэр.

27 дугаар зүйл. Намуудын эвсэл

27.1.Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлэх эрх бүхий намууд сонгуульд эвсэл байгуулж оролцох бол түүнд нэгдэн орох нам тус бүр дараах асуудлыг шийдвэрлэсэн байна:

27.1.1.эвслийн нэр, сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хэлэлцэн батлах;

27.1.2.нам тус бүрд ногдох нэр дэвшигчдийн тоог тогтоох;

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

27.1.3.нам тус бүрд ногдсон тоонд багтаан нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцэн, нэр дэвшигчийн нэр, нэр дэвших тойргийг шийдвэрлэх;

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

27.1.4.цаашид сонгуультай холбогдсон асуудлаар эвсэлд тухайн намыг төлөөлөн шийдвэр гаргах эрхтэйгээр оролцох эрх бүхий төлөөлөгчид /цаашид "намыг төлөөлөх байгууллага" гэх/-ийг томилох;

27.1.5.эвслийн гэрээг хэлэлцэж батлах.

27.2.Эвсэлд нэгдэж байгаа намын Их хурал, эсхүл төлөөллийн төв байгууллага нь нэр дэвшүүлэх асуудлыг нууц санал хураалтаар шийдвэрлэнэ.

27.3.Эвсэлд нэгдсэн намууд тус бүрдээ эвсэлд нэгдэн орох талаарх энэ хуульд заасан асуудал тус бүрийг хэлэлцэн шийдвэрлэж, нэгдсэн тохиролцоонд хүрсэн бол эвслийн гэрээ байгуулж, намуудын дарга нар гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулснаар эвсэл байгуулагдсанд тооцно.

27.4.Эвсэл албан ёсны нэр, бэлгэдэлтэй байх бөгөөд түүнийг хувь хүн, улс, үндэстэн, овгийн нэрээр болон өмнөх сонгуульд хэрэглэсэн өөр намуудын эвслийн нэрээр нэрлэхийг хориглоно.

27.5.Эвслийн нэрийг сонгуулийн явцад болон шинээр сонгогдсон Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд өөрчлөхийг хориглоно.

27.6.Нэгэнт байгуулагдсан эвсэлд аль нэг нам, эвсэл шинээр нэгдэн орохыг хориглоно.

27.7.Эвслийг төлөөлөх байгууллага нь эвсэлд нэгдэн орсон нам бүрээс томилогдсон төлөөлөгчдөөс бүрдэх бөгөөд дараах асуудлыг олонхоороо шийдвэрлэх эрхтэй:

27.7.1.эвслийн мөрийн хөтөлбөр батлах;

27.7.2.эвслийн гэрээнд өөрчлөлт оруулах;

27.7.3.нөхөн сонгуульд эвслээс нэр дэвшүүлэх;

27.7.4.эвслийн гэрээг цуцлах.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

27.8.Эвслийг төлөөлөх байгууллага нь тухайн эвсэлд нэгдэн орсон нам тус бүрд ногдсон суудлын тоог өөрчлөх эрхгүй:

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

27.9.Эвсэлд нэгдэн орсон намууд нь Улсын Их Хурлын нөхөн сонгууль, түүнчлэн шинээр сонгогдсон Улсын Их Хурлын үйл ажиллагаанд нэг этгээд болж оролцоно.

27.10.Эвслийн аль нэг нам дангаараа нэр дэвшүүлэх, намын сонгуулийн зардлын данснаас бие даан зарлага гаргах, өөр намуудын эвсэлд нэгдэн орох, бие даан болон өөр эвсэл байгуулан нөхөн сонгуульд оролцохыг хориглоно. Эвсэлд нэгдсэн намуудын олонх нь эвслээс гарсан тохиолдолд эвслийг тарсанд тооцно.

27.11.Эвслийн гэрээнд дараах зүйлийг тусгана:

27.11.1.эвслийн нэр;

27.11.2.талуудын нийтлэг болон харилцан хүлээх эрх үүрэг;

27.11.3.эвслийг төлөөлөх байгууллага болон түүний удирдах бүрэлдэхүүнд орсон иргэний эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, ажил, албан тушаал;

27.11.4.эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, түүнийг төлөөлөх албан тушаалтны эцэг /эх/-ийн болон өөрийн нэр;

27.11.5.харилцан тохиролцсон бусад асуудал.

27.12.Эвслийн гэрээ нь тухайн сонгууль, түүний үр дүнд байгуулагдсан Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд хамаарна.

28 дугаар зүйл. Сонгуульд оролцох нам, эвслийг бүртгэх

28.1.Сонгуулийн ерөнхий хороо сонгуульд оролцохоо илэрхийлсэн нам, эвслийг бүртгэхдээ тэдгээрийн ирүүлсэн баримт бичгийг нягтлан шалгана.

28.2.Сонгуулийн ерөнхий хороо сонгуульд оролцох тухай нам, эвслийн баримт бичгийг хүлээн авснаас хойш тав хоногт багтаан сонгуульд оролцох нам, эвслийг бүртгэх эсэх тухай шийдвэр гаргана.

28.3.Дараах шаардлагыг хангасан нам, эвслийг бүртгэнэ:

28.3.1.Энэ хуульд заасны дагуу нам, эвсэл сонгуульд оролцохоо илэрхийлэх хугацаанаас өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн;

[/Энэ хэсгийн "Энэ хуульд заасны дагуу нам, эвсэл сонгуульд оролцохоо илэрхийлэх хугацаанаас өмнө ..." гэснийг Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон./](#)

28.3.2.сонгуульд оролцох хүсэлтийг хуульд заасан хугацаанд ирүүлсэн;

28.3.3.сонгуульд оролцох хүсэлтэд хавсарган ирүүлэх баримт бичиг бүрэн гүйцэд;

28.3.4.сонгуулийн мөрийн хөтөлбөр нь энэ хуульд заасан шаардлага хангасан тухай төрийн аудитын байгууллагын дүгнэлт гарсан;

28.3.5.эвсэл байгуулах тухай энэ хуульд заасан журам, шаардлагыг хангасан;

28.3.6.эвсэлд нэгдэн орсон намуудын олонх нь бүртгэсэн тухай шийдвэр гарахаас өмнө энэ хуульд заасны дагуу эвслээс гарахаа илэрхийлээгүй.

28.3.7.сонгуулийн зардлын тайлан гаргах талаарх энэ хуульд заасан журмыг зөрчөөгүй.

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

28.4.Энэ хуулийн 28.3-т заасан шаардлагыг хангаагүй нам, эвслийг бүртгэхээс татгалзана.

28.5.Сонгуулийн ерөнхий хороо энэ хуульд заасны дагуу нам, эвслийг бүртгэх эсэх асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах баримт, лавлагааг холбогдох этгээдээс гаргуулан авах эрхтэй.

28.6.Сонгуулийн ерөнхий хороо нам, эвслийг бүртгэсэн тухай шийдвэр гаргасан бол батламж олгоно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНД НЭР ДЭВШҮҮЛЭХ, НЭР ДЭВШИГЧИЙГ БҮРТГЭХ

29 дүгээр зүйл. Нэр дэвшүүлэх нийтлэг журам

29.1. Сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвсэл нэр дэвшүүлэх ажиллагааг санал авах өдрөөс 45 хоногийн өмнө эхлүүлж, долоо хоногийн хугацаанд дуусгана.

29.2. Бие даан нэрээ дэвшүүлэх ажиллагааг санал авах өдрөөс 45 хоногийн өмнө эхлүүлж, долоо хоногийн хугацаанд дуусгана.

29.3. Нэр дэвшигч хуульд заасан нийтлэг шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

29.3.1. банк, бусад хуулийн этгээд, иргэнд шүүх болон арбитрын шийдвэрээр тогтоогдсон төлбөл зохих зээл, барьцаа болон батлан даалтын өр төлбөргүй байх;

29.3.2. татварын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх, аль нэг компанийн 51, түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшдэг бол тухайн компани нь албан татварын хугацаа хэтэрсэн өргүй байх.

29.3.3. сүүлийн 6 хүртэл жилийн хугацаанд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд гишүүнээр ажиллаж байгаагүй.

/Энэ заалтыг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмсэн./

29.4. Нэр дэвшигч нь дараах ажил, албан тушаал эрхэлж байгаа бол ээлжит сонгуулийн тухайд ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө, ээлжит бус, нөхөн сонгуулийн тухайд энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө эрхэлсэн ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байна:

29.4.1. төрийн жинхэнэ албан хаагч;

29.4.2. төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан;

29.4.3. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дарга, дэд дарга, захирал, дэд захирал.

29.5. Нэг намын гишүүнийг өөр намаас, эвслийн тухайд түүнд нэгдэн орсон намуудаас өөр намын гишүүнийг нэр дэвшүүлэхийг хориглоно.

29.6. Нэр дэвшигч нь нэгээс илүү тойрогт нэр дэвшихийг хориглоно.

29.7. Тойрогт болон жагсаалтад зэрэг нэр дэвшихийг хориглоно.

/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

29.8. Гэмт хэрэг үйлдэж шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор ял эдэлж байгаа хүн нэр дэвшихийг хориглоно.

/Энэ хэсгийн "29.7" дугаарыг "29.8" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

29.9. Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглоно.

/Энэ хэсгийн "29.8" дугаарыг "29.9" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

29.10. Нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ ардчилсан ёс, шударга ёсны зарчмыг баримталж, нийгмийн бүлгийн төлөөллийг харгалзана.

/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

30 дугаар зүйл. Нам, эвслээс нэр дэвшүүлэх

30.1. Нам, эвсэл нь 78 хүртэл хүнийг энэ хуульд заасны дагуу байгуулагдсан сонгуулийн тойрогт, 48 хүртэл хүнийг нам, эвслийн нэр дэвшигчдийн жагсаалтаар тус тус нэр дэвшүүлнэ.

/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

30.2. Нам, эвслээс нэр дэвшүүлэхдээ 2024 оны ээлжит сонгуулиар нийт нэр дэвшигчийн 30-аас доошгүй хувь нь, 2028 оны ээлжит сонгуулиар 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байна.

/Энэ хэсэгт "нэр дэвшигч байгаа нийт нэр дэвшигчийн 20-оос доошгүй" гэснийг "нэр дэвшүүлэхдээ 2024 оны ээлжит сонгуулиар нийт нэр дэвшигчийн 30-аас доошгүй хувь нь, 2028 оны ээлжит сонгуулиар 40-өөс доошгүй" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

30.3. Нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ намын гишүүн, дэмжигчээсээ мөнгөн болон мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээ, барьцаа, дэнчин авахыг хориглоно.

/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

30.4. Нам, эвсэл тойрогт нэр дэвшүүлэхдээ тухайн тойрогт ногдсон мандатын тооноос илүүгүй хүний нэрийг дэвшүүлнэ.

/Энэ хэсгийн "30.3" дугаарыг "30.4" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

/Энэ хэсэгт "эвсэл" гэсний дараа "тойрогт" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

30.5. Намаас нэр дэвшүүлэх асуудлыг тухайн намын Их хурал, эсхүл төлөөллийн төв байгууллага хуралдаанаараа хэлэлцэж, нууцаар санал хурааж, олонхын саналаар шийдвэрлэнэ.

/Энэ хэсгийн "30.4" дугаарыг "30.5" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

30.6. Нам, эвсэл жагсаалтаар нэр дэвшүүлэхдээ 1:1 хүйсийн харьцаатай жагсаалтын дарааллыг үндэслэн нэр дэвшүүлнэ.

/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

31 дүгээр зүйл. Бие даан нэр дэвшүүлэх

31.1. Энэ хуульд заасан шаардлагыг хангасан иргэн сонгуулийн тойрогт бие даан нэр дэвшигч болно.

/Энэ хэсэгт "иргэн" гэсний дараа "сонгуулийн тойрогт" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

31.2. Бие даан нэр дэвшүүлэгч нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна.

31.3. Аймаг, дүүргийн сонгуулийн хороо нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтыг тэмдэг дарж баталгаажуулан бие даан нэр дэвшүүлэгчид энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа явагдаж эхэлсэн өдрөөс олгоно.

31.4. Сонгогчдын гарын үсэг цуглуулах маягтад сонгогчийн эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, иргэний бүртгэлийн дугаар, оршин суугаа газрын хаяг, хөдөлгөөнт, эсхүл суурин утасны дугаарыг тодорхой бичсэн байна.

/Энэ хэсэгт 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

31.5.Бие даан нэр дэвшүүлэгч нь гарын үсэг зуруулахдаа А4 хэмжээнээс хэтрэхгүй хэмжээтэй өөрийн танилцуулах хуудсыг тарааж болно.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

32 дугаар зүйл.Нэр дэвшигчээр бүртгэх

32.1.Сонгуулийн ерөнхий хороо нэр дэвшигчийг бүртгэж, үнэмлэх олгоно.

32.2.Нэр дэвшүүлсэн нам, эвсэл нь нэр дэвшүүлэх ажиллагааны талаарх хуульд заасан хугацаа дууссан өдрөөс хойш тав хоногт багтаан дараах баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ:

32.2.1.нэр дэвшүүлсэн тухай хуралдааны шийдвэр, сонгуулийн тойрогт нэр дэвшигчдийн жагсаалт болон жагсаалтаар нэр дэвшүүлсэн нийт нэр дэвшигчийн нэрийн жагсаалт;

[/Энэ заалтад "шийдвэр" гэсний дараа "сонгуулийн тойрогт нэр дэвшигчдийн жагсаалт болон жагсаалтаар нэр дэвшүүлсэн" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

32.2.2.нэр дэвшигч бүрийн бичгээр өгсөн зөвшөөрөл;

32.2.3.энэ хуулийн 29.4-д заасан албан тушаалтан бол ажил, албан тушаалаас чөлөөлөгдсөн тухай шийдвэрийн хуулбар;

32.2.4.энэ хуулийн 29.3.1-д заасан нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хангасан эсэх талаарх Улсын дээд шүүхийн лавлагаа;

32.2.5.энэ хуулийн 29.3.2-т заасан нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хангасан эсэх талаарх татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тодорхойлолт;

32.2.6.нэр дэвшигчийн намтар;

32.2.7.нэр дэвшигчийн иргэний үнэмлэхийн хуулбар;

32.2.8.ял эдэлж байгаа эсэх талаарх цагдаагийн төв байгууллагын мэдээллийн сан хариуцсан нэгжийн лавлагаа;

32.2.9.авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож байсан эсэх талаарх холбогдох байгууллагын лавлагаа.

32.3.Бие даан нэрээ дэвшүүлэгч нь бие даан нэрээ дэвшүүлэх ажиллагааны талаарх хуульд заасан хугацаа дууссан өдрөөс хойш тав хоногт багтаан дараах баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ:

32.3.1.нэрээ дэвшүүлснээ илэрхийлсэн мэдэгдэл;

32.3.2.сонгогчдын гарын үсэг зуруулсан маягт;

32.3.3.энэ хуулийн 29.4-т заасан албан тушаалтан бол ажил, албан тушаалаас чөлөөлөгдсөн тухай шийдвэрийн хуулбар;

32.3.4.энэ хуулийн 29.3.1-д заасан нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хангасан эсэх талаарх Улсын дээд шүүхийн лавлагаа;

32.3.5.энэ хуулийн 29.3.2-т заасан нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хангасан эсэх талаарх татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тодорхойлолт;

32.3.6.нэр дэвшигчийн намтар;

32.3.7.нэр дэвшигчийн иргэний үнэмлэхийн хуулбар;

32.3.8.бие даан нэр дэвшигчийг төлөөлж сонгуулийн төв байгууллагатай харилцах хоёр хүний эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, хүн тус бүрийн харилцах утасны дугаар;

32.3.9.энэ хуульд заасны дагуу төрийн аудитын дээд байгууллагаар хянуулсан бие даан нэрээ дэвшүүлэгчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, аудитын дүгнэлт;

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

32.3.10.ял эдэлж байгаа эсэх талаарх цагдаагийн төв байгууллагын мэдээллийн сан хариуцсан нэгжийн лавлагаа;

32.3.11.авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож байсан эсэх талаарх холбогдох байгууллагын лавлагаа.

32.4.Нэр дэвшигч энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа дууссанаас хойш гурав хоногт багтаан нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт мэдүүлнэ. Авлигын эсрэг хуульд заасны дагуу хөрөнгө орлогын мэдүүлгээ гаргасан этгээд хамаарахгүй.

32.5.Авлигатай тэмцэх газар нь нийт нэр дэвшигчид хөрөнгө орлогын мэдүүлгээ мэдүүлсэн эсэх талаарх лавлагааг энэ хуулийн 32.4-т заасан хугацаа дууссанаас хойш нэг хоногийн дотор Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлнэ.

32.6.Сонгуулийн ерөнхий хороо нэр дэвшигчийн бүртгэлтэй холбоотой холбогдох баримт бичгийн маягт, загварыг батална.

32.7.Сонгуулийн ерөнхий хороо нэр дэвшигчийн баримт бичгийг хүлээн авахдаа бүрэн гүйцэд эсэхийг нягтлан шалгах ба хэрэв баримт бичгийн бүрдэл дутуу бол энэ хуульд заасан хугацаанд багтаан нөхөн ирүүлж болно.

32.8.Сонгуулийн ерөнхий хороо бие даан нэр дэвшигчийн цуглуулсан сонгогчдын гарын үсэг үнэн зөв эсэхийг түүвэрлэн тулгах, тухайн иргэнтэй уулзан нягтлан шалгах болох бөгөөд шаардлагатай гэж үзвэл уг ажлыг аймаг, дүүргийн сонгуулийн хороогоор гүйцэтгүүлж болно.

32.9.Сонгуулийн ерөнхий хороо шаардлагатай гэж үзвэл нэр дэвшигчийн талаарх лавлагааг эрх бүхий этгээдээс гаргуулан авч болно.

32.10.Энэ хуулийн 32.9-д заасан эрх бүхий этгээд нь холбогдох лавлагаа, мэдээллийг Сонгуулийн ерөнхий хорооноос тогтоосон хугацаанд хүргүүлэх үүрэгтэй.

32.11.Сонгуулийн ерөнхий хороо нэр дэвшигчийн баримт бичгийг хүлээн авах хугацаа дууссанаас хойш долоо хоногийн дотор бүртгэх эсэх асуудлыг шийдвэрлэж, тогтоол гаргана.

[/Энэ хэсэгт "хүлээн авснаас хойш тав" гэснийг "хүлээн авах хугацаа дууссанаас хойш долоо" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

32.12.Нэр дэвшигчийг бүртгэх тухай шийдвэр гарсан бол Сонгуулийн ерөнхий хороо нэр дэвшигчийн үнэмлэхийг санал авах өдрөөс 18 хоногийн өмнө нэг өдөр олгож, нийтэд мэдээнэ.

[/Энэ хэсэгт "22" гэснийг "18" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

32.13.Нэр дэвшигчээр бүртгэх тухай шийдвэр гарснаас хойш нэр дэвшигчээс татгалзахыг хориглоно.

32.14.Нэр дэвшигчийн эрх нь үнэмлэх авснаар эхэлж, санал хураалтын албан ёсны дүн гарснаар дуусгавар болно.

32.15.Энэ хуулийн 32.12-т заасны дагуу нэр дэвшигчид үнэмлэх олгосон өдрөөс эхлэн Авлигатай тэмцэх газар нэр дэвшигчээр бүртгэгдсэн нийт нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг өөрийн байгууллагын цахим мэдээллийн сүлжээнд нээлттэйгээр байршуулна.

33 дугаар зүйл.Нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах

33.1.Нэр дэвшигчээр дараах тохиолдолд бүртгэхээс татгалзана:

33.1.1.энэ хуульд заасан хугацаанд нэр дэвшүүлэх ажиллагааг явуулаагүй;

33.1.2.энэ хуульд заасан нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хангаагүй;

- 33.1.3.өөр намын гишүүнийг нэр дэвшүүлсэн;
 33.1.4.нэр дэвшигчээр бүртгүүлэхэд шаардагдах энэ хуульд заасан баримт бичиг дутуу;
 33.1.5.энэ хуулийн 32.2, 32.3-д заасны дагуу бүрдүүлсэн нэр дэвшүүлэгчийн баримт бичиг хуурамч болохыг нь шүүх тогтоосон;
 33.1.6.энэ хуулийн 29.6-д заасныг зөрчиж нэр дэвшсэн;
 33.1.7.энэ хуулийн 48.1-д заасан хориглосон үйл ажиллагаа явуулсан болох нь хуульд заасны дагуу тогтоогдсон;
 33.1.8.ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш бусдын нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, ийм агуулга бүхий мэдээллийг хэвлэмэл материалын хэлбэрээр, эсхүл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин дахь олон нийтийн сүлжээгээр тараасан болох нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон;
 33.1.9.бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр энэ хуульд заасан шаардлагад нийцээгүй.
 33.1.10.энэ хуулийн 30.1, 30.2, 30.4, 30.6-д заасан нэр дэвшүүлэх ажиллагааны журам зөрчсөн бол нийт нэр дэвшигчийг, энэ хуулийн 29.7-д заасныг зөрчсөн бол тухайн нэр дэвшигчийг.

/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

33.2.Нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан тохиолдолд санал авах өдрөөс 25-аас доошгүй хоногийн өмнө зөрчлийг арилгасны үндсэн дээр дахин бүртгүүлэхээр шаардагдах баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлж болно.

33.3.Сонгуулийн ерөнхий хороо дахин бүртгүүлэхээр ирүүлсэн баримт бичгийг хүлээн авч, энэ хуулийн 32.12-т заасан хугацаанаас өмнө бүртгэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

33.4.Энэ хуульд заасан сонгогчдын гарын үсэг зуруулсан маягтыг нягтлан шалгахад бие даан нэрээ дэвшүүлэгчээс үл хамаарах, сонгогчийн бичиг баримттай холбоотой зөрчил илэрсэн бөгөөд маягтын зөрчилгүй гарын үсгийн тоо нь энэ хуулийн 31.2-т заасан тооноос доошгүй бол дээрх зөрчил нь бие даан нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах үндэслэл болохгүй.

34 дүгээр зүйл. Нөхөн нэр дэвшүүлэх

34.1.Дараах тохиолдолд санал авах өдрөөс 25-аас доошгүй хоногийн өмнө өөр хүнийг нөхөн нэр дэвшүүлж болно:

34.1.1.нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан;

/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

34.1.2.нэр дэвшигч нас барсан;

34.1.3.нэр дэвшигч шүүхээр ял шийтгүүлсэн.

34.2.Сонгуулийн ерөнхий хороо нөхөн нэр дэвшүүлэхээр ирүүлсэн баримт бичгийг хүлээн авч, энэ хуулийн 32.12-т заасан хугацаанаас өмнө бүртгэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

35 дугаар зүйл. Нэр дэвшигчийн үйл ажиллагааны баталгаа

35.1.Нэр дэвшигч өөрт шаардлагатай мэдээлэл, лавлагааг холбогдох байгууллагаас зохих журмын дагуу гаргуулан авч болно.

35.2.Зөрчил болон гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл хэргийн болон зөрчлийн газарт нотлох баримттай нь баривчилснаас бусад тохиолдолд нэр дэвшигчид холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон зөрчил шалган шийдвэрлэх дараах ажиллагаа явуулахыг хориглоно:

35.2.1.эрүүгийн хариуцлагад татах буюу эрүүгийн хэрэг үүсгэх, баривчлах, цагдан хорих;

/Энэ заалтаас "саатуулах, албадан саатуулах" гэснийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хассан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

35.2.2.орон байр, албан тасалгаа, тээврийн хэрэгсэл болон биед нь үзлэг, нэгжлэг хийх.

35.3.Нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэх, ийм агуулга бүхий хэвлэмэл материалыг нийтэд тараах, эсхүл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин дахь олон нийтийн сүлжээгээр тараахыг хориглоно.

ДОЛДУГААР БҮЛЭГ СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР, СУРТАЛЧИЛГАА

36 дугаар зүйл. Сонгууль эрхэлсэн байгууллага

36.1.Нам, эвсэл, нэр дэвшигчээс сонгогчидтой уулзах, сонгуулийн мөрийн хөтөлбөрөө сурталчлах зэрэг сонгуулийн сурталчилгааны ажлыг нам, эвслийн болон нэр дэвшигчийн сонгууль эрхэлсэн байгууллага эрхлэн явуулна.

36.2.Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага нам, эвслийн болон нэр дэвшигчдийнхээ сонгуулийн сурталчилгааг эрхлэн явуулах бөгөөд хуулийн этгээдийн эрхгүй байна.

37 дугаар зүйл. Сонгууль эрхэлсэн байгууллагын бүрэлдэхүүн

37.1.Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын бүрэлдэхүүнд нам, эвслийн дарга, эсхүл түүний итгэмжлэл олгосон албан тушаалтан, ажилтан болон нэр дэвшигч, түүний менежер, шадар туслагч, ухуулагч хамаарна.

37.2.Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага нь улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах 500 хүртэл, аймаг, нийслэлд 100 хүртэл, дүүрэгт 50 хүртэл, сум, хороонд 20 хүртэл ажилтантай байж болно.

/Энэ хэсэгт "100 хүртэл, нийслэлд 20 хүртэл, аймаг" гэснийг "500 хүртэл, аймаг, нийслэлд 100 хүртэл" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

37.3.Нэр дэвшигч өөрийн итгэмжлэл олгосон нэг менежер, аймаг, сум, нийслэл, дүүрэг, хороо, аймгийн төвийн баг тус бүрд нэг шадар туслагч, нийслэл болон аймгийн төвд 400 сонгогч тутамд нэг ухуулагч, бусад газарт 200 хүртэлх сонгогч тутамд нэг ухуулагчтай байж болно.

/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

/Энэ хэсэгт "туслагч" гэсний дараа "нийслэл болон аймгийн төвд 400 сонгогч тутамд нэг ухуулагч, бусад газарт" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

37.4.Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтны үнэмлэхийг Сонгуулийн ерөнхий хороо, аймаг, нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах ажилтны үнэмлэхийг аймаг, нийслэлийн сонгуулийн хороо, сум, дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах ажилтны үнэмлэхийг сум, дүүргийн сонгуулийн хороо тус тус олгоно.

37.5.Нэр дэвшигчийн менежер, шадар туслагчийн үнэмлэхийг аймаг, нийслэлийн сонгуулийн хороо, ухуулагчийн үнэмлэхийг сум, дүүргийн сонгуулийн хороо тус тус олгоно.

37.6.Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтны үнэмлэх авах хүсэлтийг тухайн нам эвслийг бүртгэсэн тухай шийдвэр гарснаас

хойш, нэр дэвшигчийн менежер, шадар туслагч, ухуулагчийн үнэмлэх авах хүсэлтийг тухайн нэр дэвшигчийг бүртгэх тухай шийдвэр гарснаас хойш холбогдох сонгуулийн хороо хүлээн авч, Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан журмын дагуу олгоно.

37.7.Бие даан нэр дэвшигчид нэгдэж сонгууль эрхэлсэн байгууллага байгуулахыг хориглоно.

37.8.Ухуулагч нь сайн дурын үндсэн дээр ажиллах бөгөөд урамшууллын хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувиас хэтрэхгүй байна.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

38 дугаар зүйл. Сонгуулийн мөрийн хөтөлбөр

38.1.Сонгуульд оролцох нам, эвсэл, бие даан нэр дэвшигч дөрвөн жилийн хугацаанд хэрэгжих сонгуулийн мөрийн хөтөлбөртэй байна.

38.2.Нам, эвслээс нэр дэвшигч тухайн нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрөөс тусдаа мөрийн хөтөлбөртэй байхыг хориглоно.

38.3.Сонгуулийн мөрийн хөтөлбөрт дараах зүйлийг тусгахыг хориглоно:

38.3.1.мөнгө, эд хөрөнгө, эд хөрөнгөтэй холбоотой эрх олгох;

38.3.2.уул уурхай, газрын тос, эрдэс баялгийн болон бусад салбарын орлого, түүнчлэн улс, орон нутгийн төсвөөс иргэдэд аливаа хишиг, хувь, тэдгээртэй адилтгах бусад зүйл хүртээх;

38.3.3.эээлийн болон бусад өр төлбөрийг хүчингүйд тооцох, хөрвүүлэх;

38.3.4.иргэдэд үнэ төлбөргүй, эсхүл хямдралтай үнээр үйлчилгээ үзүүлэх;

38.3.5.ажлын байранд зуучлах, ажилд оруулах;

38.3.6.улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгийг иргэдэд тараан олгох, шууд зарцуулахтай холбогдсон асуудал.

38.4.Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн мөрийн хөтөлбөрийн агуулгад нийцсэн уриатай байж болно.

38.5.Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогод нийцсэн эсэх болон санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэх талаар төрийн аудитын байгууллагаар хянуулж дүгнэлт гаргуулсан байна.

[/Энэ хэсэгт 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

38.6.Нам, эвсэл нь ээлжит сонгуулийн жилийн 03 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө, бие даан нэр дэвшигч нь ээлжит сонгуулийн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрөөс өмнө сонгуулийн мөрийн хөтөлбөртөө дүгнэлт гаргуулахаар төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ.

38.7.Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь ээлжит сонгуулийн жилийн 04 дүгээр сарын эхний долоо хоногт багтаан энэ хуулийн 38.13-т заасан хандивын тайландаа дүгнэлт гаргуулахаар төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ.

[/Энэ хэсэгт "26.3.6, 26.4.6-д" гэснийг "38.13-т" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

38.8.Ээлжит бус, нөхөн сонгуулиар нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь төрийн аудитын дээд байгууллагаас тогтоосон хугацаанд сонгуулийн мөрийн хөтөлбөр болон энэ хуулийн 38.13-т заасан хандивын тайландаа дүгнэлт гаргуулахаар хүргүүлнэ.

[/Энэ хэсэгт "26.3.6, 26.4.6-д" гэснийг "38.13-т" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

38.9.Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр нь энэ хуульд заасан шаардлага хангаагүй гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд тав хоногийн дотор зөрчлийг арилгасны үндсэн дээр дахин дүгнэлт гаргуулахаар хүргүүлнэ.

38.10.Төрийн аудитын дээд байгууллага нам, эвслийн мөрийн хөтөлбөр болон хандивын тайланд хийсэн дүгнэлтийг санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө гаргаж, Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ.

[/Энэ хэсэгт "энэ хуульд заасан шаардлагад нийцэж байгаа эсэх талаарх" гэснийг "болон хандивын тайланд хийсэн" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

38.11.Төрийн аудитын дээд байгууллага нь бие даан нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөр энэ хуульд заасан шаардлагад нийцэж байгаа эсэх талаарх дүгнэлтийг санал авах өдрөөс 33-аас доошгүй хоногийн өмнө гаргаж, Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ.

38.12.Төрийн аудитын дээд байгууллага нь энэ хуулийн 38.13-т заасан тайлан, сонгуулийн мөрийн хөтөлбөр болон түүнд хийсэн дүгнэлтийг санал авах өдрөөс 18 хоногийн өмнөөс эхлэн энэ хуульд заасны дагуу нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа хүргүүлэх өдрийг дуустал өөрийн байгууллагын цахим хуудаст нээлттэйгээр байршуулна.

[/Энэ хэсэгт "26.3.6, 26.4.6-д" гэснийг "38.13-т" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

[/Энэ хэсэгт "22" гэснийг "18" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

38.13.Төрийн аудитын дээд байгууллага нь нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн энэ хуулийн 38.5-д заасан мөрийн хөтөлбөр, 38.7-д заасан хандивын тайланд тус бүр нэг дүгнэлт гаргана. Хандивын тайлан нь ээлжит сонгуулийн жилийн 03 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацааг, ээлжит бус, нөхөн сонгуулийн тухайд тухайн сонгуулийн жилийн өмнөх тайлант жилийн хугацааг хамаарна.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

38.14.Төрийн аудитын дээд байгууллага энэ хуулийн 38.13-т заасан дүгнэлт гаргахад шаардлагатай лавлагааг холбогдох этгээдээс гаргуулан авах эрхтэй.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

39 дүгээр зүйл. Сонгуулийн сурталчилгаа

39.1.Сонгуулийн сурталчилгааг нэр дэвшигчид үнэмлэх олгосон өдрөөс эхлүүлж, санал авах өдрөөс 24 цагийн өмнө буюу санал авах өдрийн өмнөх өдрийн 00:00 цагаас өмнө зогсооно.

39.2.Сонгуулийн сурталчилгааг дараах арга, хэлбэрээр явуулна:

39.2.1.сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах;

39.2.2.нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар байрлуулах;

39.2.3.хуульд өөрөөр заагаагүй бол намын далбааг гудамж, талбайд байрлуулах, таних тэмдэг, уриа ашиглах;

39.2.4.сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх;

39.2.5.ухуулах байр ажиллуулах;

39.2.6.радио, телевизийн сурталчилгааны нэвтрүүлэг ашиглах;

39.2.7.цахим орчин ашиглах;

39.2.8.өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд сонгуулийн сурталчилгааны материал нийтлүүлэх.

39.3.Сонгуулийн сурталчилгааны уулзалт, хандивын талаар сонгогчдод зар, урилга явуулсныг сурталчилгааны хэвлэмэл материалд оруулан тооцохгүй. Зар, урилга нь А5 хэмжээнээс илүүгүй байна.

39.4.Сонгуулийн сурталчилгааны аливаа материалын баруун доод хэсэгт сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг тодорхой харагдахуйц байдлаар товчлохгүй бичих бөгөөд энэ нь телевизийн нэвтрүүлгийн нийт хугацаанд хамаарна. Радиогийн нэвтрүүлгийн тухайд эхлэл, төгсгөлд нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг дурдана.

39.5.Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх бүхий радио, телевизийн үйлчилгээ эрхлэгч байгууллага сонгуулийн сурталчилгаа дууссанаас хойш 10 хоногийн дотор сурталчилгаа явуулсан талаарх тайланг нийтэд мэдээлнэ.

[/Энэ хэсэгт "явуулсан хэвлэл мэдээллийн" гэснийг "нэвтрүүлэх эрх бүхий радио, телевизийн үйлчилгээ эрхлэгч" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

39.6.Энэ хуулийн 39.1-д заасныг зөрчсөн радио, телевизийн байгууллагын олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн сүлжээгээр дамжих эрхийг Харилцаа холбооны зохицуулах хороо зөрчил гарсан өдрөөс эхлэн гурван сар хүртэл хугацаагаар хязгаарлана.

39.7.Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх бүхий радио, телевиз нь энэ хуулийн 39.5-д заасны дагуу нийтэд мэдээлсэн тайланг шударга өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад нийтэд мэдээлснээс хойш ажлын 5 өдрийн дотор хүргүүлнэ.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

40 дүгээр зүйл. Сонгуулийн сурталчилгаанд тээврийн хэрэгсэл ашиглах

40.1.Сонгуулийн тойрогт нэр дэвшигч нь нь сонгуулийн сурталчилгааны зорилгоор нэг хэсэгт хоёроос илүүгүй тээврийн хэрэгсэл ашиглаж болно. Тээврийн хэрэгслийн таних тэмдгийн загварыг Сонгуулийн ерөнхий хороо батална.

[/Энэ хэсэгт "Нэр дэвшигч нь" гэснийг "Сонгуулийн тойрогт нэр дэвшигч нь" гэж, "дөрвөөс" гэснийг "хоёроос" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

40.2.Сонгуулийн сурталчилгаанд ашиглах тээврийн хэрэгслийн улсын дугаарыг аймаг, дүүргийн сонгуулийн хороонд бүртгүүлэн, таних тэмдгийг авч, ил харагдахуйц байрлуулна.

40.3.Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан таних тэмдэггүй авто машин, автобус, мопед, мотоцикл болон бусад тээврийн хэрэгслийг сонгуулийн сурталчилгаанд ашиглахыг хориглоно.

40.4.Сонгуулийн сурталчилгаанд ашиглаж байгаа тээврийн хэрэгсэлд сонгуулийн сурталчилгааны ухуулах хуудас, зурагт самбар, дэлгэц, уриа, намын далбаа, чанга яригч байрлуулж болно.

41 дүгээр зүйл. Сонгуулийн сурталчилгааны хэвлэмэл материал хэвлүүлэх, тараах, хүргэх

41.1.Сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээд сонгуулийн сурталчилгааны хэвлэмэл материалыг дараах хэлбэр, хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр сонгогчдод тараах эрхтэй:

41.1.1.хоёр хэвлэлийн хуудас сонин;

[/Энэ заалтад "гурван" гэснийг "хоёр" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

41.1.2.хоёр хэвлэлийн хуудас сэтгүүл;

[/Энэ заалтад "гурван" гэснийг "хоёр" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

41.1.3.нэг хэвлэлийн хуудас ухуулах буюу зурагт хуудас.

[/Энэ заалтад "ухуулах" гэснийг дараа "буюу зурагт" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

41.2.Нэг нам, эвслийн тойрогт нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгааны хэвлэмэл материалаа нэгдмэл байдлаар хамтран гаргаж болно.

[/Энэ хэсэгт "эвслийн" гэснийг дараа "тойрогт" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

41.3.Зурагт самбарыг нийтийн эзэмшлийн гудамж, талбай, олон нийтийн газарт үнэ төлбөргүйгээр байрлуулах байршлыг тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө тогтоож, нийтэд мэдээлнэ.

[/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсэгт "Ухуулах хуудас болон зурагт" гэснийг "Зурагт" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

41.4.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ хуулийн 41.3-т заасан байршил тогтоохдоо аливаа нам, эвсэл, нэр дэвшигчийн нэр заахыг хориглоно.

[/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

41.5.Энэ хуулийн 41.3-т заасны дагуу тогтоосон байршилаас өөр газарт зурагт самбар байршуулахыг хориглоно.

[/Энэ хэсгээс "ухуулах хуудас" гэснийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хассан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

41.6.Нэр дэвшигч нь ухуулах хуудсыг нэг хэсэгт 20-оос илүүгүй байршуулах бөгөөд гудамж талбайд байрлуулахдаа цавуу, цавуулагд эд зүйл ашиглан тогтоож, орчин бөхирдуулахыг хориглоно.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

41.7.Ухуулах хуудас нэг хэвлэлийн хуудас хүртэлх хэмжээнээс илүүгүй байна.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

41.8."Нэг хэвлэлийн хуудас" гэж А4 бичгийн цаасны найман нүүрийг ойлгоно.

41.9.Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй.

41.10.Сурталчилгааны хэвлэмэл материалыг шуудангаар хүргүүлж болно.

41.11.Сонгуулийн сурталчилгааны хугацаанд гудамж, талбайд байрлуулсан зурагт самбарыг гэмтээх, устгахыг хориглоно.

[/Энэ хэсэгт "нам, эвсэл, нэр дэвшигчийн зурагт болон ухуулах хуудсыг" гэснийг "зурагт самбарыг" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

41.12.Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага нэр дэвшигчийн танилцуулга, намтар, нам, эвслийн мөрийн хөтөлбөрийг нэгтгэн хэвлэж,

сөнөгчдөд хүргэх ажлыг зохион байгуулж болно.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

41.13.Өдөр тутмын болон бусад сонин, сэтгүүлд нийтлүүлэх сурталчилгааны материал энэ хуулийн 41.1.1, 41.1.2-т заасан хэмжээнд хамаарна.

41.14.Энэ хуулийн 39.2.8-д заасан сонин, сэтгүүл нь сүүлийн 12 сарын турш тогтмол гарсан байх бөгөөд түүнд нийтлүүлэх сурталчилгааны төлбөр нь ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд баримталсан зар сурталчилгаа, мэдээ, мэдээллийн үнийн дунджаас хэтрэхгүй байна.

41.15.Сонгуулийн сурталчилгааны хэвлэмэл материалыг бүхэлд нь брайль үсэгтэйгээр хэвлүүлж болно. Брайль үсэг бүхий хэвлэмэл материал энэ хуулийн 41 дүгээр зүйлд заасан хэмжээнд хамаарахгүй.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

41.16.Нам, эвслээс жагсаалтаар нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны нэгдсэн хэвлэмэл материал нь гурван хэвлэлийн хуудаснаас хэтрэхгүй байна.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

42 дугаар зүйл. Сонгуулийн сурталчилгаанд зурагт самбар ашиглах

[/Энэ зүйлийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

42.1.Тойрогт нэр дэвшигчийн зурагт хуудсыг байрлуулсан нэгдсэн самбар /цаашид "нэгдсэн самбар" гэх/-ыг сум, дүүргийн Засаг дарга дараах шаардлагын дагуу бэлтгэж, байршуулах ажлыг зохион байгуулна:

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

42.1.1.нэр дэвшигчийн зурагт хуудас нь нэг хэвлэлийн хуудасны дөрөвний нэг хэмжээтэй байх;

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

42.1.2.зурагт хуудас байрлуулах дарааллыг энэ хуулийн 60 дугаар зүйлд заасныг үндэслэн тогтоох;

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

42.1.3.сонгогчийн тоонд үндэслэн суманд хоёр хүртэл, аймгийн төвийн суманд тав хүртэл, хороонд дөрөв хүртэл нэгдсэн самбарыг үнэ төлбөргүй байрлуулах.

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

42.2.Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага нь найман хэвлэлийн хуудаснаас илүүгүй хэмжээтэй зурагт самбарыг суманд нэг, хороонд хоёр хүртэл байрлуулж болно.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

42.3.Зурагт самбарыг зөвхөн нийтийн эзэмшлийн газар буюу гудамж, талбайд сурталчилгааны хугацаанд түр хугацаагаар, үнэ төлбөргүй байрлуулна. Зурагт самбарт тухайн нам, эвслийн нэрийг дурдсан байна.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

42.4.Бизнесийн зорилгоор байнга ашиглагддаг сурталчилгааны самбар, дэлгэц, түүний орон зайг сонгуулийн сурталчилгаанд ашиглахгүй.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

42.5.Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, нэр дэвшигчийн ухуулах байр байрлаж байгаагаас бусад байшин, барилга байгууламжид сонгуулийн сурталчилгааны самбар байрлуулахгүй.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

42.6.Нэгдсэн самбар болон зурагт самбар байрлуулахдаа замын тэмдэг, тэмдэглэгээ, гэрлэн дохио, хөдөлгөөн зохицуулах бусад хэрэгслийг халхлах, бүсдын эд хөрөнгө, явган зорчигчдод аюул учруулж болзошгүй байдлаар байрлуулах, замын хөдөлгөөнд саад учруулахыг хориглоно.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

43 дугаар зүйл. Намын далбааг сонгуулийн сурталчилгаанд ашиглах

43.1.Сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээд намын далбаа, уриа, таних тэмдгийг сурталчилгааны явцад ашиглах эрхтэй.

43.2.Намын далбаа, уриа, таних тэмдгийг нэр дэвшигчийн ухуулах байр, сонгогчидтой хийх уулзалт, хурал цуглааны танхимд, сурталчилгааны самбар, дэлгэц, ухуулах хуудас, сонгуулийн сурталчилгаанд ашиглах зөвшөөрөл бүхий тээврийн хэрэгсэл, сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээдийн хэрэглэж байгаа хувцас дээр байрлуулж болох бөгөөд бусад газарт байрлуулахыг хориглоно.

44 дүгээр зүйл. Сонгогчтой хийх уулзалт, хурал, цуглаан

44.1.Сонгогчтой хийх уулзалт, хурал, цуглааныг сонгуулийн сурталчилгааны хугацаанд багтаан хийнэ.

44.2.Сонгогчтой хийх уулзалт, хурал, цуглаан зохион байгуулахад нь тухайн шатны Засаг дарга дэмжлэг үзүүлж, сонгуульд оролцогч талуудад тэгш хандах үүрэгтэй.

44.3.Дараах байгууллага, хуулийн этгээд сонгуулийн уулзалт, хурал, цуглаан хийхэд нь зориулж өөрийн эзэмшиж байгаа соёлын төв, биеийн тамирын болон хурлын заал, бусад байр, танхимыг үнэ төлбөргүй ашиглуулах үүрэгтэй:

44.3.1.төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага;

44.3.2.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;

44.3.3.төрийн болон орон нутгийн өмчийн 51 хувь ба түүнээс дээш оролцоотой хуулийн этгээд.

44.4.Энэ хуульд заасны дагуу санал авах байр болгон бэлтгэсэн, эсхүл сонгуулийн хороод тухайн байр, танхимд үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд энэ хуулийн 44.3 дахь хэсэг хамаарахгүй.

44.5.Энэ хуулийн 44.3 дахь хэсэгт шүүх, прокурор, тагнуул, цагдаа, онцгой байдлын болон эмнэлгийн байгууллага хамаарахгүй.

44.6.Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй.

45 дугаар зүйл. Ухуулах байр ажиллуулах

45.1.Нэр дэвшигч сонгуулийн хэсэг бүрд хоёроос илүүгүй ухуулах байр ажиллуулж болно.

45.2.Нэг нам, эвслээс нэр дэвшигчид хамтран нэг ухуулах байранд үйл ажиллагаа явуулж болно.

45.3.Ухуулах байрыг дараах зорилгоор ажиллуулна:

45.3.1.сонгуулийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлах, танилцуулах;

45.3.2.сонгуулийн сурталчилгааны материалыг сонгогчдод тараах;

45.3.3.уулзалт, хурал зохион байгуулах.

46 дугаар зүйл. Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах

- 46.1. Сонгуулийн сурталчилгаатай холбогдсон нэвтрүүлэг /цаашид "сурталчилгааны нэвтрүүлэг" гэх/-ийг радио, телевизээр нэвтрүүлж болно.
- 46.2. Олон нийтийн радио, телевиз сурталчилгааны болон мэтгэлцээний нэвтрүүлгийг Харилцаа холбооны зохицуулах хорооноос баталсан хуваарь, цагийн дагуу зөвхөн төлбөргүй нэвтрүүлнэ.
/Энэ хэсэгт "тогтоосон" гэснийг "баталсан" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./
/Энэ хэсэгт "сурталчилгааны" гэсний дараа "болон мэтгэлцээний" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./
- 46.3. Олон нийтийн радио, телевиз нь нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдэд сонгуулийн сурталчилгааны болон мэтгэлцээний төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цаг олгох саналаа Харилцаа холбооны зохицуулах хороонд хүргүүлэхдээ нам, эвслээс нэр дэвшигчдэд намын Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн дарааллыг, эвслийн тухайд эвсэлд нэгдэн орсон намын Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн дарааллыг, бие даан нэр дэвшигчийн тухайд Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн дарааллыг баримтлан ижил нөхцөл, тэнцүү хугацаа ногдохоор тооцно.
/Энэ хэсэгт "сурталчилгааны" гэсний дараа "болон мэтгэлцээний" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./
- 46.4. Харилцаа холбооны зохицуулах хороо олон нийтийн радио, телевизээс ирүүлсэн сурталчилгааны болон мэтгэлцээний төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цагийн талаарх саналыг хянан үзэж, сурталчилгааны болон мэтгэлцээний нэвтрүүлгийн хуваарь, цагийг тэнцүү байхаар тооцож сурталчилгаа эхлэхээс долоогоос доошгүй хоногийн өмнө батална.
/Энэ хэсэгт "үзсэний үндсэн дээр сонгуулийн" гэснийг "үзэж, сурталчилгааны болон мэтгэлцээний нэвтрүүлгийн хуваарь, цагийг тэнцүү байхаар тооцож" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./
/Энэ хэсэгт "сурталчилгааны" гэсний дараа "болон мэтгэлцээний" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./
- 46.5. Олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевиз сурталчилгааны нэвтрүүлгийг гэрээний үндсэн дээр нэвтрүүлнэ.
- 46.6. Олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн нийт хугацаа нь хоногт нэг цаг /60 минут/-аас илүүгүй байна.
- 46.7. Сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хоногт гарах нийт хугацаа /60 минут/-ны хорин таваас илүүгүй хувь /15 минут/ нь нэг нам, эвсэлд, түүнчлэн бие даан нэр дэвшигчдэд ногдоно.
- 46.8. Сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн төлбөр нь ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд баримталсан зар сурталчилгаа, мэдээ, мэдээллийн төлбөрийн дундаж хэмжээнээс хэтрэхгүй байна.
- 46.9. Олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевиз сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлэх бол сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх тухай мэдэгдлийг дараах баримт бичиг, мэдээллийн хамт Харилцаа холбооны зохицуулах хороонд санал авах өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө хүргүүлж, бүртгүүлнэ:
- 46.9.1. сурталчилгааны нэвтрүүлэг явуулахаар төлөвлөсөн цагийн хуваарь;
/Энэ заалтад "тогтоосон нарийвчилсан" гэснийг "төлөвлөсөн" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./
- 46.9.2. ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хийж байсан гурваас доошгүй зар сурталчилгаа нэвтрүүлэх гэрээ;
- 46.9.3. сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх үнийн санал.
/Энэ заалтад "дундаж үнийн талаарх мэдээлэл" гэснийг "үнийн санал" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./
- 46.10. Энэ хуулийн 46.9-д заасны дагуу бүртгүүлсэн радио, телевиз сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрхтэй бөгөөд бүртгүүлээгүй радио, телевизээр сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлэхийг хориглоно.
- 46.11. Радио, телевиз нэгээс илүү сувагтай бол сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийг аль нэг сувгаар нэвтрүүлнэ.
/Энэ хэсэгт "зөвхөн үндсэн" гэснийг "аль нэг" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./
- 46.12. Сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлэх радио, телевиз нь сонгуульд оролцогч бүх нам, эвсэл, нэр дэвшигчид тэгш хандах үүрэгтэй.
- 46.13. Радио, телевиз нь мэдээллийн хөтөлбөрөөрөө нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх сонгуулийн үйл явцын мэдээллийг хүргэхдээ бодит, тэнцвэртэй, нэг талыг барихгүй, хараат бус байх зарчмыг баримтална.
- 46.14. Радио, телевизийн мэдээллийн хөтөлбөрөөр нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар гарсан мэдээ нь сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хугацаанд хамаарахгүй боловч нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээг хоногт таван минутаас хэтрүүлэхийг хориглоно.
- 46.15. Радио, телевиз сонгогчдын боловсролд зориулсан мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг, хөтөлбөр бэлтгэж түгээх үүрэгтэй.
- 46.16. Радио, телевизийн редакцид бэлтгэгдээгүй, сонгуульд оролцогч нам, эвсэл, нэр дэвшигчийн зүгээс бэлтгэн нийлүүлсэн мэдээ, нэвтрүүлгийг тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийн сурталчилгааны нэвтрүүлэгт хамааруулна.
- 46.17. Улс төрийн мэтгэлцээний нэвтрүүлэг, хөтөлбөр сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэгт хамаарахгүй боловч уг нэвтрүүлэг, хөтөлбөрт нэг намын бус, түүнчлэн бие даагч хэд хэдэн нэр дэвшигч, эсхүл өөр өөр нам, эвслийн төлөөлөл оролцсон байна.
/Энэ хэсгээс "талаарх" гэснийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хассан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./
- 46.18. Сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хуваарь, цагийг бусад нам, эвсэл, нэр дэвшигчид шилжүүлэхийг хориглоно.
- 46.19. Хэвлэл мэдээллийн байгууллага, түүний ажилтан, албан тушаалтан сонгуулийн үйл ажиллагааны талаар бодит мэдээллийг түгээх үүрэгтэй.
- 46.20. Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзах журмыг Харилцаа холбооны зохицуулах хорооны саналыг үндэслэн, энэ хуульд нийцүүлэн Сонгуулийн ерөнхий хороо батална.
/Энэ хэсэгт "журмыг Сонгуулийн ерөнхий хороо, Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран энэ хуульд нийцүүлэн" гэснийг "радио, телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзах журмыг Харилцаа холбооны зохицуулах хорооны саналыг үндэслэн, энэ хуульд нийцүүлэн Сонгуулийн ерөнхий хороо" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./
- 46.21. Харилцаа холбооны зохицуулах хороо олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны төлбөргүй нэвтрүүлгийн баталсан хуваарь, цаг болон сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлэх зөвшөөрөл олгосон радио, телевизийн жагсаалтыг сонгуульд оролцож байгаа

нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдэд хүргүүлж, өөрийн байгууллагын цахим хуудаст байршуулан нийтэд мэдээлнэ.

46.22.Радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгаанд Харилцаа холбооны зохицуулах хороо хяналт тавьж ажиллана.

46.23.Харилцаа холбооны зохицуулах хороо энэ хуульд заасан зөрчил гаргуулахгүй байх, гарсан зөрчлийг зогсоох арга хэмжээг цагдаагийн болон сонгуулийн байгууллагатай хамтран хэрэгжүүлж болно.

46.24.Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх талаар энэ хуулийн 46.20-д заасан журам зөрчсөн бол эхний удаад сануулах арга хэмжээ авах, эсхүл радио, телевизийн сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрхийг санал авах өдөр хүртэл цуцлах тухай шийдвэр гаргана.

46.25.Энэ хуулийн 46.10-т заасныг зөрчсөн телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчийн зөвшөөрлийг Харилцаа холбооны зохицуулах хороо хүчингүй болгоно.

46.26.Энэ хуулийн 39.1-д заасан сонгуулийн сурталчилгаа зогсоох хугацаанаас өмнөх 48 цагт энэ хуулийн 46.6, 46.7, 48.9-д заасныг зөрчсөн бол телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчийн зөвшөөрлийг Харилцаа холбооны зохицуулах хороо хүчингүй болгоно.

46.27.Нам, эвсэл, нэр дэвшигчийн бэлтгэсэн сонгуулийн сурталчилгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор хадмал тайлбар, эсхүл дохионы хэлний орчуулгатай байж болно.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

46.28.Радио, телевизийн хүүхдэд зориулсан нэвтрүүлэг дундуур сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

47 дугаар зүйл. Сонгуулийн сурталчилгаанд цахим орчин ашиглах

47.1.Сонгуулийн сурталчилгаанд дараах хэлбэрийн цахим хуудас ашиглаж болно:

47.1.1.нэр дэвшигчийн болон нам, эвслийн өөрийн тус бүр нэг цахим хуудас;

47.1.2.цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудас;

47.1.3.бусад цахим хуудас.

47.2.Нэр дэвшигч энэ хуулийн 47.1.1, 47.1.2-т заасан цахим хуудсыг сонгуулийн сурталчилгаанд ашиглах тохиолдолд цахим хуудсыг нэр дэвшигчийн үнэмлэх авсан өдрөөс хойш гурав хоногийн дотор тухайн аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд бүртгүүлнэ.

47.3.Энэ хуулийн 47.1.1, 47.1.3-т заасан цахим хуудас ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулахдаа сэтгэгдэл бичигдэхгүй тохиргоотойгоор нийтэлнэ.

47.4.Энэ хуулийн 47.2-т заасны дагуу бүртгүүлээгүй цахим хуудсыг сонгуулийн сурталчилгаанд ашиглах, бусдын нэр болон хуурамч хаяг ашиглахыг тус тус хориглоно.

47.5.Энэ хуулийн 47.1.3-т заасан цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах төлбөр нь ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд баримталсан зар сурталчилгаа, мэдээ, мэдээллийн төлбөрийн дундаж хэмжээнээс хэтрэхгүй байна.

47.6.Сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээд сонгуулийн сурталчилгааны материалыг цахим хэлбэрээр буюу цахим шуудангаар сонгогчдод хүргүүлж болно.

47.7.Энэ хуулийн 35.3, 47.4-т заасныг зөрчсөн талаарх гомдлын дагуу Харилцаа холбооны зохицуулах хороо, тагнуулын байгууллага, цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн дараах арга хэмжээг нэн даруй авна:

[/Энэ хэсэгт "хороо" гэсний дараа, "тагнуулын байгууллага" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

47.7.1.энэ хуулийн 47.1.1, 47.1.3-т заасан цахим хуудасны Монгол Улсаас хандах хандалтыг сонгуулийн дүн гарч дуусталх хугацаагаар хаах;

47.7.2.энэ хуулийн 47.1.2-т заасан тухайн цахим хуудсыг хаах, эсхүл түр хязгаарлах арга хэмжээ авах.

47.8.Үүрэн холбооны болон интернетийн үйлчилгээ эрхлэгч нь холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу зөрчил гаргасан цахим хуудас болон тухайн мэдээ, мэдээллийг өөрийн сүлжээнд хаах үүрэг хүлээнэ.

47.9.Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журмыг цагдаагийн төв байгууллага болон Харилцаа холбооны зохицуулах хорооны саналыг үндэслэн Сонгуулийн Ерөнхий хороо хамтран баталж, мөрдүүлнэ.

47.10.Нэр дэвшигч болон нам, эвсэл нь энэ хуулийн 47.1.1, 47.1.2-т заасан цахим хуудсаа энэ хуулийн 39.1-д заасан сонгуулийн сурталчилгаа дуусах хугацаанд хаана.

47.11.Харилцаа холбооны зохицуулах хороо нь Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн цахим орчин дахь олон нийтийн сүлжээний хандалтыг хязгаарлах, тархалтыг бууруулах технологийн арга хэмжээг сонгуулийн сурталчилгаа дууссан өдрөөс санал авах өдрийн дараах өдөр хүртэл авч болно.

47.12.Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах зардал энэ хуулийн 50.1-д заасны дагуу тогтоосон зардлын дээд хэмжээний 15 хувиас хэтрэхгүй байна.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

48 дугаар зүйл. Хууль бус сурталчилгааг хориглох

48.1.Ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш санал авах өдрийг дуустал, нөхөн, ээлжит бус сонгуулийн тухайд сонгууль товлон зарласан шийдвэр гарснаас хойш санал авах өдрийг дуустал аливаа этгээд өөрөө болон бусдаар дамжуулж сонгогчдын саналыг татах зорилгоор дараах үйлдэл, үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

48.1.1.мөнгө, эд зүйл тараах, бараа, эд зүйл хөнгөлөлттэй үнээр худалдах, аливаа үйлчилгээ төлбөргүйгээр болон хөнгөлөлттэй үзүүлэх;

48.1.2.нийтийг хамарсан биеийн тамирын уралдаан, тэмцээн, баяр наадам, урлагийн тоглолт, хүлээн авалт, дайллага, цайллага, төлбөрт таавар, бооцоот, мөрийтэй тоглоом зохион байгуулах, ивээн тэтгэх;

48.1.3.сонгогчдыг гадаад, дотоодод аялал зохион байгуулан оролцуулах, амралт, сувилалд амраах, сувилуулах;

48.1.4.ирээдүйд өөрийн болон бусдын хөрөнгөөр мөнгө, эд бараа өгөхөөр гэрээ байгуулах, хэлцэл хийх;

48.1.5.хишиг, хувь, хувьцаа өгөх, ажлын байранд зуучлах, ажилд оруулах зэрэг амлалт авах;

48.1.6.сонгуульд оролцохоос татгалзахыг болон сонгуулийн хууль тогтоомж зөрчихийг уриалсан агуулга бүхий сурталчилгаа явуулах;

48.1.7.хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин, мессеж ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт, санал асуулга зохион байгуулах, нийтлэх;

[/Энэ заалтад "байгуулах" гэснийг "байгуулах, нийтлэх" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

48.1.8.тухайн жилийн төсөвт тусгаагүй нийгмийн халамж, хамгааллын хөтөлбөр хэрэгжүүлэх, амлалт өгөх, зарлах.

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

48.2.Улс төрийн намаас зөвхөн гишүүдийнхээ хүрээнд зохион байгуулсан сургалт, уулзалтыг сонгогчдын саналыг татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаараулахгүй.

48.3.Сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, нэр дэвшигч болон түүний менежер, шадар туслагч, ухуулагчаас бусад этгээд сонгуулийн сурталчилгаа хийхийг хориглоно.

48.4.Төрийн улс төрийн албан хаагч сонгуулийн сурталчилгаанд оролцож болно.

48.5.Сонгуулийн сурталчилгааны явцад дараах үйлдэл гаргах, үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

/Энэ хэсгээс "сурталчилгаа явуулах эрх бүхий этгээд нь сонгуулийн" гэснийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хассан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

48.5.1.энэ хуульд зааснаас өөр арга, хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа хийх;

48.5.2.зөвшөөрснөөс бусад хугацаанд сонгуулийн сурталчилгаа хийх;

48.5.3.сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй аливаа зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх талаар амлалт авах, ийм агуулга бүхий аливаа үйлдлийг сонгуулийн сурталчилгаанд ашиглах;

48.5.4.энэ хуульд зааснаас бусад тохиолдолд төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, бусад өмч хөрөнгийг аливаа хэлбэрээр сонгуулийн сурталчилгаанд ашиглах;

48.5.5.оройн 22:00 цагаас дараа өдрийн 08:00 цаг хүртэлх хугацаанд чанга яригч ашиглах;

48.5.6.олон нийтийг хамарсан аливаа шашны зан үйл ашиглах, түүнийг зохион байгуулах, оролцох, ивээн тэтгэх, шашны холбогдолтой эд зүйл тараах.

48.6.Сонгуулийн мөрийн хөтөлбөрт туссан иргэдийн шүтэх, эс шүтэх эрх чөлөө, төр, сүм хийдийн харилцаа, шашны талаарх бодлого, үзэл баримтлалыг сонгогчдод тайлбарлан таниулах үйл ажиллагааг шашны зан үйл ашигласан гэж үзэхгүй.

48.7.Аливаа хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн сурталчилгааны үеэр аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээ, мэдээллийг дагнан гаргах, эсхүл гаргахгүй байхаар амлалт авах, гэрээ байгуулахыг хориглоно.

48.8.Дахин болон нэмэлт санал хураалт дуусталх хугацаанд сонгуулийн сурталчилгаа явуулахыг хориглоно.

48.9.Нам, эвслийн дарга, нэр дэвшигч нь сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс хойш санал авах ажиллагаа дуустал сонгуулийн сурталчилгааны бус бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, ярилцлагад орох, нам, эвслээс жагсаалтаар нэр дэвшигч ухуулах байр ажиллуулахыг хориглоно.

/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

48.10.Радио, телевиз нь сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс хойш санал авах ажиллагаа дуустал нам, эвслийн дарга, нэр дэвшигч оролцсон энэ хуульд зөвшөөрснөөс бусад хэлбэрийн бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, ярилцлага нэвтрүүлэхийг хориглоно.

/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

48.11.Сонгуулийн сурталчилгаа хийх эрх бүхий этгээдэд хариуцлага хүлээлгэх зорилгоор тэдгээрийн нэрийн өмнөөс аливаа этгээд санаатайгаар хууль бус сурталчилгаа хийхийг хориглоно.

/Энэ хэсгийн "48.10" дугаарыг "48.11" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

48.12.Харилцаа холбооны зохицуулах хороо энэ хуулийн 48.9, 48.10-д заасан үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах бөгөөд энэ хуулийн 48.8, 48.9, 48.10-д заасныг зөрчсөн тохиолдолд радио, телевизийн байгууллагын олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн сүлжээгээр дамжих эрхийг зөрчил гарсан өдрөөс эхлэн гурван сар хүртэл хугацаагаар хязгаарлана.

/Энэ хэсгийн "48.11" дугаарыг "48.12" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

/Энэ хэсэгт "48.9", "48.8, 48.9" гэснийг дараа "48.10" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

48.13.Шударга өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 46.13, 48.1.7, 48.7-д хяналт тавьж ажиллана.

/Энэ хэсгийн "48.12" дугаарыг "48.13" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

48.14.Шударга өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэвлэл мэдээллийн байгууллагад эхний удаа сануулах арга хэмжээ авч болно.

/Энэ хэсгийн "48.13" дугаарыг "48.14" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

48.15.Энэ хуулийн 48.13-т заасны дагуу зөрчлийг шалгах хугацаанд шударга өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага санал хураалтын дүн гарах хүртэлх хугацаанд үйл ажиллагааг нь зогсоох тухай дүгнэлтийг зөвшөөрөл олгосон байгууллагад нь хүргүүлэх арга хэмжээг авч болно.

/Энэ хэсгийн "48.14" дугаарыг "48.15" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

/Энэ хэсэгт "48.12-т" гэснийг "48.13-т" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

48.16.Харилцаа холбооны зохицуулах хороо энэ хуулийн 48.15-д заасан дүгнэлтийг үндэслэн тухайн телевизийн олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн сүлжээгээр дамжих эрхийг дүгнэлтэд дурдсан хугацаагаар хязгаарлах арга хэмжээг авна.

/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

НАЙМДУГААР БҮЛЭГ СОНГУУЛИЙН ЗАРДАЛ

49 дүгээр зүйл. Сонгуулийн зардал

49.1.Сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, түүнчлэн нэр дэвшигч сонгуулийн мөрийн хөтөлбөрөө сонгогчдод сурталчлах, тайлбарлан таниулах зорилгоор сонгуулийн сурталчилгааны шууд болон шууд бус зардал /цаашид "сонгуулийн зардал" гэх/ гаргана.

49.2.Сонгуулийн зардал дараах хөрөнгөөс бүрдэнэ:

49.2.1.хандив;

49.2.2.намын өөрийн хөрөнгө;

49.2.3.нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө.

49.3. Сонгуулийн зардлын мөнгөн хөрөнгийг энэ хуульд заасны дагуу нээлгэсэн сонгуулийн зардлын дансанд төвлөрүүлж, зарцуулна.

49.4. Сонгуулийн зардлын данснаас өөр дансанд сонгуулийн зардал цуглуулах, зарцуулахыг хориглоно.

50 дугаар зүйл. Сонгуулийн зардлын дээд хэмжээ

50.1. Төрийн аудитын дээд байгууллага нам, эвсэл болон тойрогт нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг ээлжит сонгуулийн жилийн 03 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө энэ хуулийн 50.2-т заасан аргачлалын дагуу тогтоож, нийтэд мэдээлнэ.

[Энэ хэсэгт "болон" гэсний дараа "тойрогт" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.](#)

50.2. Сонгуулийн зардлын дээд хэмжээ тогтоох аргачлал нь сонгуулийн зардлыг бууруулахад чиглэх бөгөөд сонгуулийн нутаг дэвсгэрийн хэмжээ, байршил, өрхийн болон сонгогчийн тоо, энэ хуульд заасан бусад шаардлагад үндэслэнэ. Аргачлалыг төрийн аудитын дээд байгууллагын саналаар Сонгуулийн ерөнхий хороо батална.

[Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.](#)

50.3. Энэ хуулийн 50.1-д заасны дагуу тогтоосон зардлын дээд хэмжээг дараагийн ээлжит сонгууль хүртэл мөрдөх бөгөөд хэрэв өөрчлөлт оруулах шаардлагатай бол нөхөн, ээлжит бус сонгууль товлон зарласан шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор энэ хуульд нийцүүлэн тогтоож, нийтэд мэдээлнэ.

51 дүгээр зүйл. Сонгуулийн зардлын данс

51.1. Сонгуульд оролцож байгаа нам, эвсэл болон нэр дэвшигч тус бүр улсын хэмжээнд сонгуулийн зардлын төгрөгийн нэг данстай байна.

51.2. Нам аймаг, нийслэл, сум, дүүрэгт салбартай бол тухайн аймаг, сум, нийслэл, дүүрэгт сонгуулийн зардлын данстай байж болно.

[Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан.](#)

51.3. Нам, эвсэл болон сонгуулийн тойрогт нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэх тухай шийдвэр гарснаас хойш энэ хууль болон банкны тухай хууль тогтоомжид нийцүүлэн сонгуулийн зардлын дансыг нээлгэнэ.

[Энэ хэсэгт "эвсэл болон" гэсний дараа "сонгуулийн тойрогт" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.](#)

51.4. Нам, эвсэл болон нэр дэвшигч сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 15-аас доошгүй хоногийн өмнө төрийн аудитын дээд байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй.

[Энэ хэсэгт "20-оос" гэснийг "15-аас" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.](#)

51.5. Эвслийн сонгуулийн зардлын данс тухайн эвсэл тарах хүртэл хугацаанд ашиглагдана.

51.6. Сонгуулийн зардлын дансанд хуримтлагдах хөрөнгийн хэмжээнд тусгайлан хязгаар тогтоохгүй боловч тухайн сонгуулийн сурталчилгааны хугацаанд сонгуулийн зардлын данснаас зарцуулах зардлын хэмжээ энэ хуульд заасны дагуу тогтоосон сонгуулийн зардлын дээд хэмжээнээс хэтрэхгүй.

51.7. Энэ хуульд тусгайлан зааснаас бусад хугацаанд нам, эвсэл сонгуулийн зардлын дансаа битүүмжлүүлэх бөгөөд зөвхөн орлого оруулахыг зөвшөөрнө.

51.8. Сонгуулийн зардлын дансны зарлагын битүүмжлэлийг энэ хуульд заасан хугацаагаар нээж өгөх хүсэлтийг нам, эвслийг бүртгэсэн тухай Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрийн хамт банканд хүргүүлснээр тухайн банк сонгуулийн зардлын дансны битүүмжлэлийг нээнэ.

52 дугаар зүйл. Сонгуулийн зардлын данснаас зарлага гаргах

52.1. Нам, эвсэл болон нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэсэн өдрөөс эхэлж, сонгуулийн зардлын тайлан гаргах өдрийг дуустал хугацаанд энэ хуулийн 39.2-т заасан арга хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа явуулах зориулалтаар сонгуулийн зардлын данснаас дансанд шилжүүлэх хэлбэрээр зарлага гаргаж болно.

52.2. Нам нь эвсэл байгуулан сонгуульд оролцож байгаа бол эвслийн сонгуулийн зардлын дансанд сонгуулийн зардал шилжүүлэхээс бусад зориулалтаар сонгуулийн зардлын данснаас бие даан зарлага гаргахыг хориглоно.

53 дугаар зүйл. Сонгуулийн хандив

53.1. Сонгуулийн хандив /цаашид "хандив" гэх/ нь мөнгөн, мөнгөн бус хэлбэртэй байна.

53.2. Хандивлагч энэ хуульд заасан шаардлага хангасан, Монгол Улсын иргэн байна.

53.3. Энэ хуулиар хориглоогүй, түүнчлэн тухайн хуулийн этгээдийн дүрэмд өөрөөр заагаагүй бол хуулийн этгээд хандивлагч байж болно.

53.4. Энэ хуулийн 4.3.2-т заасан жагсаалтаар нэр дэвшигч нь нам, эвслийн сонгуулийн сурталчилгаанд зориулан хандив өгч болох бөгөөд нэг нэр дэвшигчийн өгсөн хандивын хэмжээ нь энэ хуульд заасны дагуу тогтоосон нэр дэвшигчээс тойрогт зарцуулах зардлын хэмжээний дунджаас хэтрэхгүй байна.

[Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.](#)

54 дүгээр зүйл. Мөнгөн хандив

54.1. Мөнгөн хандив нь иргэний хувьд арван сая төгрөг хүртэл, хуулийн этгээдийн хувьд гучин сая төгрөг хүртэл байна.

[Энэ хэсэгт "таван" гэснийг "арван" гэж, "хорин" гэснийг "гучин" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.](#)

54.2. Иргэн, хуулийн этгээдээс нам, эвсэлд, эсхүл сонгуулийн тойрогт нэр дэвшигчид зардлын данс нээсэн өдрөөс хойш сонгуулийн үйл ажиллагаанд нь зориулан энэ хуулийн 54.1-т заасан хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр сонгуулийн зардлын дансанд хандив өгч болно.

[Энэ хэсэгт "эсхүл" гэсний дараа "сонгуулийн тойрогт" гэж, "хэтрүүлэхгүйгээр" гэсний дараа "сонгуулийн зардлын дансанд" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.](#)

54.3. Эвсэлд нэгдсэн намд сонгуульд зориулж хандив өгсөн бол тухайн намын нэгдэн орсон эвсэлд давхардуулан хандив өгөхийг хориглоно.

54.4. Хандив өгч байгаа иргэний нэр, иргэний бүртгэлийн дугаар, хуулийн этгээд нь нэр, регистрийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээллээ банкны гүйлгээний баримтад тусгах бөгөөд энэ шаардлагыг хангаагүй хандивыг хандив хүлээн авагч буцаан шилжүүлнэ.

[Энэ хэсэгт 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан.](#)

54.5. Буцах хаяг нь тодорхойгүй хандивыг холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын орлогод буюу төрийн санд шилжүүлнэ.

54.6. Хуулийн этгээд мөнгөн хандив өгсөн бол уг хандивыг санхүү, татварын тайландаа тусгана.

54.7. Бэлэн мөнгөөр хандив өгөх, авахыг хориглоно.

55 дугаар зүйл. Мөнгөн бус хандив

55.1. Мөнгөн бус хандивт дараах зүйл хамаарна:

55.1.1. Үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийг ашиглуулах, эзэмшүүлэх;

55.1.2.үйлчилгээ үзүүлэх.

55.2.Мөнгөн бус хандивыг сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс дуусах хүртэл хугацаанд зөвхөн нэр дэвшигчид өгнө.

55.3.Мөнгөн бус хандив өгч байгаа тохиолдолд хандивлагч нь нэр дэвшигч, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй хандивын гэрээг бичгээр байгуулж гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулна.

55.4.Мөнгөн бус хандивын үнэлгээг зах зээлийн дундаж ханшийг үндэслэн хандивын гэрээгээр тогтоох бөгөөд уг үнэлгээ нь иргэн болон хуулийн этгээдээс өгөх хандивын дээд хэмжээнээс хэтрэхгүй байна.

56 дугаар зүйл.Хандив өгөх, хүлээн авахыг хориглох

56.1.Дараах этгээд хандив өгөхийг хориглоно:

56.1.1.гадаад улс буюу гадаадын байгууллага, олон улсын байгууллага, гадаадын хөрөнгө оруулалттай байгууллага, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага;

56.1.2.гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн;

56.1.3.18 нас хүрээгүй хүн;

56.1.4.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд;

56.1.5.шүүхийн шийдвэрээр тогтоогдсон албан татварын өр төлбөртэй, дампуурсан хуулийн этгээд;

56.1.6.үйлдвэрчний эвлэл, шашны байгууллага;

56.1.7.байгууллагдаад нэг жил болоогүй хуулийн этгээд.

56.2.Хандив өгөхийг хориглосон этгээд сонгуулийн хандив өгсөн бол хандив хүлээн авах эрх бүхий этгээд буцаан шилжүүлнэ.

56.3.Хандивлагч хандив өгөх бол энэ хуулийн 56.1-д заасан шаардлага хангаж байгаа эсэхээ хандив хүлээн авагчид нотлох үүрэгтэй.

56.4.Энэ хуулийн 56.2-т заасныг зөрчиж хүлээн авсан хандивыг улсын орлогод буюу төрийн санд шилжүүлнэ.

56.5.Нам өөрийн өмчлөлийн хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгийг нам, эвслийн болон нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаанд ашиглуулж болох бөгөөд энэ нь хандивт тооцогдохгүй.

56.6.Нэр дэвшигч болон нам, эвслийн сонгуулийн зардлын данс хооронд шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг хандивт тооцохгүй.

57 дугаар зүйл.Сонгуулийн зардлын тайлан

57.1.Сонгуулийн зардлын тайланд орлого ба зарлагын мэдээллийг бүрэн тусгана.

57.2.Сонгуулийн зардлын тайлан нь мөнгөн ба мөнгөн бус хөрөнгийн санхүүгийн тайлан байна.

57.3.Нам, эвсэл санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ.

57.4.Зардлын тайланг дараах үзүүлэлтээр гаргана:

57.4.1.сонгуулийн зардлын дансанд орсон орлогын нийт хэмжээг энэ хуулийн 49.2-т заасан хөрөнгийн эх үүсвэр болон гүйлгээ тус бүрээр;

57.4.2.хандивлагч иргэн, хуулийн этгээдийн энэ хуулийн 54.4-т заасан мэдээлэл болон хандивын хэмжээ, хэлбэр;

57.4.3.зарлагын ангилал, гүйцэтгэл, гэрээний хамт;

57.4.4.үлдэгдлийн хэмжээ, байршил;

57.4.5.сонгуулийн зардлын данснаас зарлага гаргаж эхлэхийн өмнөх мөнгөн хөрөнгийн хэмжээ.

57.5.Сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч уг дансны бүх гүйлгээний хуулгыг гаргаж, санал авах өдрөөс хойш 30 хоногийн дотор төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ.

58 дугаар зүйл.Сонгуулийн зардлын тайлангийн хяналт ба нээлттэй, ил тод байдал

58.1.Төрийн аудитын дээд байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ.

/Энэ хэсэгт "нийтэд" гэсний дараа "мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

58.2.Төрийн аудитын дээд байгууллага сонгуулийн зардлын тайлангийн талаар дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

58.2.1.нам, эвсэл, нэр дэвшигчийн авсан хандив, санхүүжилт, зарцуулалтад дангаараа болон төрийн бусад байгууллагатай хамтран хяналт тавих;

58.2.2.нам, эвсэл, нэр дэвшигчээс сонгуулийн санхүүжилттэй холбоотой мэдээлэл авах;

58.2.3.сонгуулийн санхүүжилт, түүний зарцуулалтад гарсан зөрчлийн талаар баримт бичиг үйлдэх, бүрдүүлэх, холбогдох байгууллагад хүргүүлэх;

58.2.4.төрийн болон бусад байгууллага, албан тушаалтан, иргэдээс сонгуулийн санхүүжилттэй холбоотой баримт бичгийг гаргуулан авах;

58.2.5.зардлын тайлан гаргаа, хүлээн авах, нийтэд мэдээлэх, танилцуулахтай холбоотой журам, маягт батлах.

58.3.Төрийн аудитын дээд байгууллага энэ хуулийн 38.5, 38.13-т заасан мэдээллийг дүгнэлт гаргаж дууссан өдрөөс эхлэн, 58.4-т заасан мэдээллийг хүлээн авсан өдрөөс эхлэн өөрийн байгууллагын цахим хуудаст ил тавьж, нийтэд чөлөөтэй танилцах бололцоо олгоно.

/Энэ хэсэгт "26.3.6, 26.4.6, 38.5-д" гэснийг "38.5, 38.13-т" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

58.4.Нэр дэвшигч, нам, эвсэл авсан хандив болон сонгуулийн зардлын зарцуулалтын явцын тайланг санал авах өдрөөс гурав хоногийн өмнө нийтэд ил тод мэдээлж, төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ.

58.5.Төрийн аудитын дээд байгууллага энэ хуулийн 58.2-т заасан бүрэн эрхийн дагуу мэдээлэл, баримт шаардсан тохиолдолд холбогдох иргэн, хуулийн этгээд мэдээлэл, баримтыг гаргаж өгөх үүрэгтэй.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ САНАЛ АВАХ, СОНГУУЛИЙН ДҮН ГАРГАХ

59 дүгээр зүйл.Саналын хуудас

59.1.Саналын хуудас сонгогчоос саналаа илэрхийлэх, сонгуулийн дүн гаргах үндсэн баримт бичиг бөгөөд дараах шаардлагыг хангасан байна:

59.1.1.агуулга, бичилт, хэлбэрийн хувьд сонгогчоос саналаа илэрхийлэхэд хялбар, ойлгомжтой;

59.1.2.сонгогч саналаа тэмдэглэх тухай заавар агуулсан.

59.2.Саналын хуудаст нэр дэвшигчийн эцэг /эх/-ийн нэрийг жижиг үсгээр, өөрийнх нь нэрийг том үсгээр бичих ба нам, эвсэл нэр дэвшүүлсэн бол тухайн нам, эвслийн нэрийг бичнэ.

59.3.Саналын хуудас нь тусгай нууцлалтай байх бөгөөд аймаг, дүүргийн хэмжээнд нэгдсэн дугаартай байна.

59.4.Саналын хуудас нь дараах хэсэгтэй байна:

[Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

59.4.1.энэ хуулийн 4.3.1-д заасан сонгуулийн тойрогт нэр дэвшигчид өгсөн саналыг тэмдэглэх;

[Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

59.4.2.энэ хуулийн 4.3.2-т заасан нам, эвсэлд өгсөн саналыг тэмдэглэх.

[Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

60 дугаар зүйл.Саналын хуудаст нэр дэвшигчийн нэрийг бичих дараалал

60.1.Саналын хуудаст нам, эвсэл, тэдгээрээс тойрогт нэр дэвшигч, бие даан нэр дэвшигчийн нэрийг дараах дарааллын дагуу бичнэ:

[Энэ хэсэгт "тэдгээрийн нэр дэвшигч, бусад" гэснийг "тэдгээрээс тойрогт нэр дэвшигч, бие даан" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

60.1.1.намын нэрийг Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн дарааллаар;

60.1.2.эвслийн нэрийг тухайн эвсэлд нэгдсэн орсон намуудаас хамгийн түрүүнд Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн намын дарааллаар;

60.1.3.нам, эвслээс нэр дэвшигчийг тухайн нам, эвслээс тойрогт ирүүлсэн дарааллаар;

[Энэ заалтад "эвслээс" гэсний дараа "тойрогт" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

60.1.4.бие даан нэр дэвшигчийг Сонгуулийн ерөнхий хороонд бүртгэсэн дарааллыг баримтлан нам, эвслээс тойрогт нэр дэвшигчдийн нэрийн дараа.

[Энэ заалтад "эвслээс" гэсний дараа "тойрогт" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

61 дүгээр зүйл.Саналын хуудсыг хэвлүүлэх, хүргүүлэх, хадгалах, хамгаалах

61.1.Сонгуулийн ерөнхий хороо улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн сонгогчийн тоонд үндэслэн саналын хуудасны тоо, загварыг баталж, үнэт цаас хэвлэх тусгай зөвшөөрөлтэй, тагнуулын байгууллагаас олгосон аюулгүй байдлын гэрчилгээ бүхий хуулийн этгээдээр хэвлүүлнэ.

[Энэ хэсэгт "баталж" гэсний дараа "үнэт цаас хэвлэх тусгай зөвшөөрөлтэй, тагнуулын байгууллагаас олгосон аюулгүй байдлын гэрчилгээ бүхий хуулийн этгээдээр" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

61.2.Сонгуулийн ерөнхий хороо саналын хуудсыг санал авах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө санал авах байранд хүргүүлэх ажлыг удирдан зохион байгуулна.

61.3.Саналын хуудас хэвлүүлэх, хүргүүлэх, хадгалах үйл ажиллагааны хамгаалалтыг цагдаагийн болон төрийн тусгай хамгаалалтын асуудал эрхэлсэн байгууллага хариуцах бөгөөд тагнуулын асуудал эрхэлсэн байгууллага хяналт тавьж ажиллана.

61.4.Саналын хуудас санал авах өдөр хүртэл, санал авч эхэлснээс хойш санал тоолж дуусах хүртэл, санал авах ажиллагаа дууссанаас хойш холбогдох журмын дагуу аймаг, нийслэлийн архивт хүлээлгэн өгөх хүртэл цагдаагийн хамгаалалт, тагнуулын байгууллагын хяналтад байна.

61.5.Санал хураалт дууссаны дараа саналын хуудаст агуулагдсан мэдээллийн үнэн зөв, аюулгүй байдлыг хангах зорилгоор саналын хуудсыг битүүмжлэх бөгөөд битүүмжлэлийг задлахгүйгээр сонгуулийн бусад бичиг баримтын хамт аймаг, нийслэлийн архивт хадгална.

61.6.Архивт хадгалсан саналын хуудасны битүүмжлэлийг гагцхүү шүүхийн шийдвэрийн дагуу Сонгуулийн ерөнхий хорооны төлөөлөл, хөндлөнгийн хоёроос доошгүй гэрчийг байлцуулан, цагдаагийн байгууллагын хяналттайгаар нээж болно.

[Энэ хэсэгт "байлцуулан" гэсний дараа "цагдаагийн байгууллагын хяналттайгаар" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

61.7.Сонгуулийн ерөнхий хороо саналын хуудсыг хэвлүүлэх, хүргүүлэх, хадгалах, хамгаалах журмыг баталж, мөрдүүлнэ.

62 дугаар зүйл.Санал авах байр, хугацаа

62.1.Сонгогчийн саналыг Улаанбаатарын цагаар санал авах өдрийн 07:00 цагаас 22:00 цаг хүртэл хугацаанд санал авах байранд авна.

62.2.Тухайн хэсгийн харьяалагдах сум, дүүргийн Засаг дарга Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан зааврын дагуу санал авахад шаардлагатай дараах зүйлийг санал авах өдрөөс долоогоос доошгүй хоногийн өмнө бэлэн болгох үүрэгтэй:

62.2.1.санал авах байр;

62.2.2.сонгогч саналаа нууцаар өгөхөд шаардагдах бүхээг;

62.2.3.зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаг, санал өгөх сонгогч саналаа нууцаар өгөхөд шаардагдах бүхээг;

62.2.4.суурин болон зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаг;

62.2.5.сонгогчийн бүртгэлийн мэдээллийг ажиглагчид үзүүлэх дэлгэц;

62.2.6.хууль тогтоомжид заасан бусад.

62.3.Харааны бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулсан саналын хуудсыг унших, саналаа тэмдэглэх тусгай зориулалтын брайль үсэг бүхий хавтас санал авах байр бүрд байна.

62.4.Санал авах байранд сонгогчоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хэсэг дэх сонгогчийн тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх бөгөөд санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна.

62.5.Санал авах байр тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна.

62.6.Нэг барилга байгууламж, цогцолборт хэд хэдэн санал авах байр байрлаж болно.

62.7.Хэсгийн хороо нь санал авах байрын дугаар, нэр, хаяг, байршил, орчин тойрны зураглалыг 14 хоногийн турш нийтэд зарлан мэдээлнэ.

62.8.Санал авах байрын байршлыг нийтийн эмх замбараагүй байдал, үер ус, гал түймэр зэрэг давагдашгүй хүчин зүйлийн улмаас Сонгуулийн ерөнхий хорооны зөвшөөрлөөр өөрчилж болох бөгөөд энэ тухай сонгогчдод нэн даруй мэдээлнэ.

62.9.Санал авах ажиллагааг зохион байгуулах, санал авах байр бэлтгэх заавар, түүнчлэн саналын хайрцаг, санал бэлтгэх бүхээгийн хэмжээ, загварыг Сонгуулийн ерөнхий хороо батална.

62.10.Санал авах байранд санал тоолох төхөөрөмж, сонгогчийн бүртгэлийн техник хэрэгсэл болон саналын хуудас хүлээн авснаас хойш тухайн санал авах байрыг цагдаагийн хамгаалалтад авна.

62.11.Санал авах байрны хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах зорилгоор санал авах байранд хяналтын камер байрлуулна. Төв суурин газраас алслагдсан баг дахь санал авах байранд хяналтын камер байрлуулж болно.

[Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

62.12.Энэ хуулийн 62.11-д заасан хяналтын камерыг сонгогч саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэхэд саад учруулахгүйгээр байрлуулж, сонгогчийг бүртгэх болон санал өгөх орчинд явагдаж байгаа үйл ажиллагааг баримтжуулна.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

62.13.Санал авах байранд байрлуулах хяналтын камерт тавигдах шаардлага, түүнийг байрлуулах, ашиглах болон бичлэгийг хадгалах, хамгаалах, устгах журмыг цагдаагийн төв байгууллага Сонгуулийн ерөнхий хороотой хамтран батална.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

63 дугаар зүйл.Зөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах ажиллагаа

63.1.Дараах сонгогчийн саналыг зөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар түүний хүсэлт, эмнэлгийн магадлагаа, эсхүл холбогдох байгууллагын тодорхойлолтыг үндэслэн санал авах өдрийн өмнөх өдрийн 09:00-20:00 цагийн хооронд авна:

63.1.1.эрүүл мэндийн байдлын улмаас санал авах байранд өөрийн биеэр очиж чадахгүй сонгогч;

63.1.2.Дайчилгааны тухай хуульд заасны дагуу нийтийн дайчилгаанд хамрагдан ажиллаж байгаа сонгогч;

63.1.3.захиргааны журмаар албадан эмчлүүлж байгаа болон зөрчлийн хэрэгт холбогдуулан баривчлагдсан сонгогч;

[/Энэ заалтад "зөрчлийн улмаас" гэснийг "захиргааны журмаар албадан эмчлүүлж байгаа болон зөрчлийн хэрэгт холбогдуулан" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

63.1.4.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу баривчлагдсан, цагдан хоригдсон сонгогч;

63.2.Эрүүл мэндийн байдлын улмаас зөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх сонгогч өөрийн эрүүл мэндийн талаарх эмчийн магадлагааг зөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх хүсэлтийн хамт санал авах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө дараах байдлаар хүргүүлнэ:

63.2.1.эмнэлэг, сувилалд хэвтэн эмчлүүлж байгаа сонгогч тухайн байгууллагын захиргаанд;

63.2.2.бусад тохиолдолд өөрийн харьяа хэсгийн хороонд.

63.3.Энэ хуулийн 63.1.1-д заасан сонгогч нь асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй бол тухайн сонгогчийн харьяалагдах баг, хорооны Засаг дарга түүний хүсэлт, мэдээллийг холбогдох хэсгийн хороонд хүргүүлэх үүрэгтэй.

63.4.Энэ хуулийн 63.1.1, 63.1.2, 63.1.3, 63.1.4-т заасан сонгогч зөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх хүсэлтээ тухайн байгууллагын удирдлагад өгөх бөгөөд байгууллагын удирдлага уг хүсэлтийг тодорхойлолтын хамт санал авах өдрөөс долоогоос доошгүй хоногийн өмнө өөрийн байгууллагын нутаг дэвсгэрийн хувьд харьяалагдах сум, дүүргийн сонгуулийн хороонд хүргүүлнэ.

63.5.Сум, дүүргийн сонгуулийн хороо энэ хуулийн 63.4-т заасны дагуу ирүүлсэн хүсэлт, тодорхойлолтыг санал авах өдрөөс таваас доошгүй хоногийн өмнө тухайн сонгогчийн харьяалагдах хэсгийн хороонд хүргүүлнэ.

[/Энэ хэсэгт "байгууллагын нутаг дэвсгэрийн хувьд" гэснийг "сонгогчийн" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

63.6.Хэсгийн хороо болон хэсгийн хорооны дэргэд ажиллах итгэмжлэгдсэн ажилтан зөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх сонгогчийн хүсэлт, магадлагаа, тодорхойлолтыг хүлээн авч дараах ажиллагааг хийнэ:

63.6.1.тухайн хэсгийн сонгогч мөн эсэхийг итгэмжлэгдсэн ажилтны оролцоотойгоор нягтлан шалгах;

63.6.2.тухайн хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогч биш бол харьяалах хэсгийн хороонд нь мэдэгдэж хасалт хийлгэх;

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

63.6.3.зөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх сонгогчдын нэрсийг гаргаж, хэсгийн хорооны дарга зөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах хуваарь, чиглэлийг батлах.

63.7.Зөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх сонгогчийн саналыг тухайн хэсгийн хорооны хоёроос доошгүй гишүүн хэсгийн хорооны даргын баталсан хуваарь, чиглэлийн дагуу нийслэл, сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд оршин байгаа газарт нь очиж авна.

[/Энэ хэсэгт "дагуу" гэснийг дараа "нийслэл, сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

63.8.Зөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх сонгогчдын нэрийн жагсаалтад ороогүй сонгогчийн саналыг зөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар авахыг хориглоно.

63.9.Зөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх сонгогчийн иргэний үнэмлэхийг нь шалгасны үндсэн дээр саналын хуудас олгоно.

63.10.Зөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авч байгаа газар дараах этгээд байхыг зөвшөөрнө:

63.10.1.санал авч байгаа газар нь иргэний орон байр бол тухайн иргэний гэр бүлийн гишүүн;

63.10.2.тухайн газар нь эмнэлэг болон түүнтэй адилтгах байгууллага бол хүнд өвчтөн;

63.10.3.ажиглагч;

63.10.4.хамгаалалтад ажиллаж байгаа цагдаагийн алба хаагч.

63.11.Зөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах ажиллагаанд өөр өөр нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн төлөөлөл бүхий хоёроос доошгүй ажиглагчийг оролцуулж болно.

63.12.Зөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах ажиллагааны аюулгүй байдлыг цагдаагийн байгууллага хариуцан ажиллах бөгөөд энэ хуулийн 63.1.3, 63.1.4-т заасан сонгогчийн саналыг зөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар авах ажиллагааны аюулгүй байдлыг тухайн нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

63.13.Сонгогчийн саналыг зөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар авах журмыг Сонгуулийн ерөнхий хороо баталж, мөрдүүлнэ.

64 дүгээр зүйл.Зөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх

64.1.Зөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх сонгогч санал бэлтгэх зөврийн бүхээгт саналаа нууцаар тэмдэглэж, дугтуйд хийнэ.

64.2.Дугтуйд хийсэн саналын хуудсыг зөврийн битүүмжилсэн саналын хайрцагт хийнэ.

64.3.Зөврийн битүүмжилсэн саналын хайрцгийг санал авах өдөр, сонгогчийн санал авах ажиллагаа эхлэх хүртэл задлахыг хориглоно.

64.4.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 65 дугаар зүйлд заасан санал авах байранд санал өгөх журмыг баримтална.

64¹ дүгээр зүйл.Гадаад улсад байгаа иргэдийн санал авах газар, хугацаа

[/Энэ зүйлийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

64¹.1.Гадаад улсад байгаа сонгогчийн саналыг энэ хуульд заасны дагуу тогтоосон санал авах өдөр, тухайн улсын орон нутгийн цагаар 07:00-22:00 цаг хүртэлх хугацаанд салбар комиссын тогтоосон санал авах байранд авна.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

64¹.2.Салбар комисс нь санал авах өдөр, цаг, байрыг санал авах өдөр хүртэлх хугацаанд гадаад улсад байгаа сонгогчдод зарлан мэдээлнэ.

[Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.](#)

64¹.3.Сонгогчоос саналаа нууцаар өгөхөд шаардагдах санал бэлтгэх бүхээг бүхий байр, саналын хайрцгийг санал авах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө энэ хуульд заасны дагуу тухайн улсад байгаа Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн хариуцаж, бэлтгэнэ.

[Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.](#)

64¹.4.Санал авах байранд сонгогчоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хүрэлцэхүйц тооны санал бэлтгэх бүхээг бэлтгэсэн байна.

[Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.](#)

64¹.5.Гадаад улсад байгаа сонгогчийн саналыг Сонгуулийн ерөнхий хорооноос хүргүүлсэн саналын хуудсаар авна.

[Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.](#)

64¹.6.Сонгуулийн ерөнхий хороо нь саналын хуудсыг уутны хамт битүүмжлэн, төв комиссоор дамжуулан гадаад улсад байгаа сонгогчдын санал авах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө салбар комисст хүргүүлнэ.

[Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.](#)

64¹.7.Салбар комисс нь саналын хуудсыг бүрэлдэхүүнээрээ хүлээн авч, энэ тухай тэмдэглэл үйлдэж гарын үсэг зурна.

[Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.](#)

65 дугаар зүйл. Санал авах байранд санал авах ажиллагаа

65.1.Хэсгийн хорооны бүрэлдэхүүн санал авах байранд санал авах ажиллагаа эхлэхээс өмнө ажиглагчийг байлцуулан доор дурдсан дарааллын дагуу хэсгийн хорооны дарга мэдээлэл хийж, бэлтгэл ажлыг гүйцэтгэн тэмдэглэл хөтлүүлнэ:

65.1.1.тухайн хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчдын тоо, үүнээс зөөврийн битүүмжилсэн саналын хайрцагаар санал өгсөн сонгогчдын тоог мэдээлэх;

65.1.2.саналын хуудасны нэгдсэн дугаарыг мэдээлэх;

65.1.3.хүлээн авсан, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцагаар санал авахад зарцуулсан, үүнээс зөөврийн битүүмжилсэн саналын хайрцагаар санал авахад сонгогч саналаа буруу тэмдэглэсэн үндэслэлээр буцааж хураагдсан, түүнчлэн алдагдаж үрэгдүүлсэн, устгасан, үлдсэн саналын хуудасны тоог мэдээлэх;

65.1.4.зөөврийн битүүмжилсэн саналын хайрцагаас бусад санал авах бүх хайрцгийг нээж харуулах, санал тоолох төхөөрөмжийг битүүмжлэх, лацдах, санал авах ажиллагаанд бэлэн болгох.

65.2.Хэсгийн хорооны дарга санал авах ажиллагааны бэлтгэл ажлыг удирдан зохион байгуулах бөгөөд уг ажиллагаанд тухайн хэсгийн сонгогчдын төлөөллийг байлцуулж болно.

65.3.Санал авах өдрийн 07:00 цагт санал авах ажиллагаа эхэлнэ.

65.4.Санал авах ажиллагаа эхэлмэгц зөөврийн битүүмжилсэн саналын хайрцагаар санал өгсөн сонгогчийн иргэний бүртгэлийн дугаараар бүртгэл хийж, сонгогчийн бүртгэлийн хуудсыг итгэмжлэгдсэн ажилтнаар гаргуулан авах бөгөөд зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгийн битүүмжлэлийг нээж, саналаа өгсөн сонгогчдын саналын хуудсыг санал тоолох төхөөрөмж /саналын хайрцаг/-д хийнэ.

[Энэ хэсэгт 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан.](#)

65.5.Сонгогч өөрийн байнга оршин суугаа газрынхаа харьяа хэсэгт санал өгөх бөгөөд сонгогчдын саналыг энэ хуулийн 65.4-т заасан ажиллагааг хийж дууссаны дараа авч эхэлнэ.

65.6.Санал авах байранд ажиллаж байгаа итгэмжлэгдсэн ажилтан сонгогчийн гарын хурууны хээг сонгогчдын нэрийн жагсаалтын цахим хувилбартай тулгаж, энэ хуулийн 66.5-д заасан бэхэн тэмдэглэгээ хийгдсэн эсэхийг нягтлан, зөрчилгүй бол сонгогчийн бүртгэлийн хуудас олгоно.

[Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.](#)

65.7.Сонгогчийн бүртгэлийн төхөөрөмж ажиллахгүй, эсхүл ажиллах боломжгүй болсон бол тухайн сонгогчийн иргэний үнэмлэхийн мэдээллийг сонгогчдын нэрийн жагсаалттай тулган шалгаж, тэмдэглэл үйлдэх бөгөөд уг тэмдэглэлийг үндэслэн тухайн сонгогчид саналын хуудас олгоно.

65.8.Гарын хурууны хээгээр сонгогчийг таних боломжгүй бол сонгогчийн иргэний үнэмлэхийн мэдээллийг сонгогчдын нэрийн жагсаалттай тулган шалгаж, сонгогчийн бүртгэлийн хуудас олгоно.

65.9.Энэ хуулийн 24.1, 24.2-т заасны дагуу шилжин ирсэн сонгогчийн шилжих хуудсыг давхар шалгаж, сонгогчийн бүртгэлийн хуудас олгоно.

65.10.Хэсгийн хорооны гишүүн сонгогчийн бүртгэлийн хуудсыг авч саналын хуудас олгоно. Бүртгэлийн хуудсыг сонгуулийн бичиг баримтад хавсаргана.

65.11.Хэсгийн хорооны дэргэд ажиллах итгэмжлэгдсэн ажилтан энэ хуулийн 65.7, 65.8, 65.9-д заасны дагуу тэмдэглэл үйлдсэн буюу бүртгэлийн хуудас олгосон сонгогчдын жагсаалтыг тусад нь гаргаж, тухайн хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалттай тулгаж, тэмдэглэл үйлдэнэ.

65.12.Саналын хуудас авсан сонгогчоор сонгогчдын нэрийн жагсаалтад гарын үсэг зуруулна.

65.13.Санал авах ажиллагаанд хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг байлцуулж болно.

65.14.Санал авах байранд нэр дэвшигч болон зөвшөөрөлгүй бусад этгээд байхыг хориглох бөгөөд энэ нь тухайн этгээд саналаа өгөхөд хамаарахгүй.

65.15.Санал авах өдрийн 22:00 цагт сонгогчдын бүртгэл зогсох бөгөөд бүртгэлийн хуудсаа авсан сонгогчийн саналыг нь өгүүлнэ.

65.16.Бүртгэлийн хуудас авсан сонгогчийг сонгогчийн нэрийн жагсаалтын нэгдсэн санд бүртгэгдсэн тухай тэмдэглэгээ хийнэ.

[Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.](#)

65.17.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 65.6-д заасан сонгогчийн гарын хурууны хээгээр сонгогчдын нэрийн жагсаалтын нэгдсэн сантай тулган таниулах ажлыг хариуцна.

[Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.](#)

66 дугаар зүйл. Сонгогч саналаа өгөх

66.1.Сонгогч санал авах байранд иргэний үнэмлэхтэй ирж, саналаа биечлэн өгнө. Сонгогч саналын хуудаст бичигдсэн зааврын дагуу тэмдэглэгээ хийж саналаа өгнө.

[Энэ хэсэгт "биечлэн өгнө." гэсний дараа "Сонгогч саналын хуудаст бичигдсэн зааврын дагуу тэмдэглэгээ хийж саналаа өгнө." гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.](#)

66.2.Сонгогч энэ хуулийн 59.4.2-т заасан хэсэгт нэг нам, эвсэлд саналаа өгнө.

[Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.](#)

66.3.Сонгогч санал бэлтгэх бүхээгт саналаа нууцаар тэмдэглэнэ.

66.4.Сонгогч саналаа тэмдэглэсний дараа саналын нууцлалыг хангах зориулалт бүхий хавтас хэрэглэж саналын хуудсыг санал тоолох төхөөрөмж /саналын хайрцаг/-д хийнэ.

66.5.Сонгогч саналын хуудсаа санал тоолох төхөөрөмж /саналын хайрцаг/-д хийсний дараа тухайн сонгогч саналаа өгснийг илэрхийлэх бэхэн

тэмдэглэгээг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан зааврын дагуу хийнэ.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)
66.6. Сонгогч санал тэмдэглэхдээ алдаа гаргаж буруу тэмдэглэл хийсэн бол саналын хуудсаа санал тоолох төхөөрөмж /саналын хайрцаг/-д хийхээс өмнө энэ тухай хэсгийн хороонд мэдэгдэж, алдаатай саналын хуудсыг хураалгаж, дахин нэг удаа саналын хуудас авч, саналаа өгч болно.

66.7. Санал тоолох төхөөрөмж саналын хуудсыг таньж уншаагүй бол сонгогч энэ тухай хэсгийн хороонд мэдэгдэж, уг саналын хуудсыг хураалгаж, дахин саналын хуудас авч, саналаа өгч болно.

66.8. Хэсгийн хороо хураалгасан саналын хуудасны зүүн доод өнцгийг хайчлан, тэмдэглэл хөтлөн хадгална.

66.9. Эрүүл мэндийн байдал, хөгжлийн бэрхшээл болон боловсролын түвшингээс шалтгаалан саналаа биечлэн өгөх чадваргүй сонгогч өөрийн итгэмжилсэн сонгуулийн эрх бүхий иргэний туслалцаатайгаар саналаа өгч болно.

66.10. Энэ хуулийн 66.9-д заасан итгэмжилсэн иргэн нь хоёроос дээш сонгогчид туслалцаа үзүүлэхийг хориглоно. Сонгуулийн байгууллагын ажилтан, нэр дэвшигч, ажиглагч, улс төрийн албан тушаалтан нь итгэмжилсэн иргэн байж болохгүй.

66.11. Хэсгийн хороо санал авах ажиллагаа хуульд заасны дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавьж, сонгогчийн саналаа нууцаар өгөх эрх зөрчигдсөн тохиолдолд түүнийг таслан зогсоох арга хэмжээ авна.

66.12. Сонгуулийн ерөнхий хороо сонгогчдыг сонгуульд идэвхтэй оролцуулах талаар шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлж болно.

66.13. Сонгогчид дараах зүйлийг хориглоно:

66.13.1. тухайн санал авах байранд саналаа өгөх эрхгүй гэдгээ мэдсээр байж санал өгөх, эсхүл өөр хүний бичиг баримт, хуурамч бичиг баримт ашиглах зэргээр санал өгөх, санал өгөхийг оролдох;

66.13.2. тухайн хэсгийн хорооноос олгосноос өөр саналын хуудсыг санал өгөхөд ашиглах, эсхүл санал авах байранд гаднаас саналын хуудас авч орох, санал авах байрнаас саналын хуудас авч гарах;

66.13.3. саналын хуудсанд тэмдэглэсэн санал, саналын хуудасны зураг авах, дүрс бичлэг хийх, шууд дамжуулах зэрэг үйлдэл гаргах;

[/Энэ заалтад "саналаа болон бусад сонгогчийн саналыг баримтжуулан" гэснийг "санал, саналын хуудасны" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

66.13.4. саналын хуудсанд хийсэн тэмдэглэгээг бусдад харуулах, зориулалтын бус үзгээр санал тэмдэглэх;

66.13.5. аль нэг нэр дэвшигч, нам, эвслийн төлөө санал өгөх, эсхүл өгөхгүй байхаар амлалт авах, мөнгө, эд зүйл шаардах, авах.

[/Энэ заалтад "дэвшигчийн" гэснийг "дэвшигч, нам, эвслийн" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

66.14. Сонгогч саналаа өгснийг илэрхийлэх аливаа тэмдэг, тэмдэглэгээ хийхийг хориглоно.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

66.15. Сонгогч саналын хуудаст саналаа тэмдэглэх үед тухайн сонгогчийн дэргэд өөр хүн байхыг хориглоно. Энэ хуулийн 66.9-д заасан итгэмжилсэн иргэнд энэ хэсэг хамаарахгүй.

66.16. Санал авах өдөр ажиллаж байгаа сонгогчид тухайн байгууллагын удирдлага чөлөө олгож, түүнийг санал өгөх боломжоор хангах үүрэгтэй.

66¹ дүгээр зүйл. Гадаад улсад байгаа сонгогч санал өгөх

[/Энэ зүйлийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

66¹.1. Салбар комиссын бүрэлдэхүүн гадаадад санал авах өдөр тухайн улсын орон нутгийн цагаар 07:00 цагт ажиглагч, эсхүл сонгогчийн төлөөллийг байлцуулан саналын хайрцгийг нээж харуулан, шалган битүүмжилж, лацадсаны дараа салбар комиссын дарга дараах мэдээллийг хийж тэмдэглэл хөтлүүлнэ:

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

66¹.1.1. сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдсэн нийт сонгогчийн тоо;

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

66¹.1.2. хүлээн авсан, алдагдаж үрэгдсэн, устгагдсан, үлдсэн саналын хуудасны тоо;

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

66¹.1.3. саналын хуудасны нэгдсэн дугаар.

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

66¹.2. Салбар комисс энэ хуулийн 66¹.1-д заасан ажиллагааг гүйцэтгэсний дараа санал авах ажиллагааг эхлүүлэх бөгөөд салбар комисс сонгогчийн иргэний үнэмлэх, эсхүл үндэсний гадаад паспортыг сонгогчдын нэрийн жагсаалттай тулган үзэж, сонгогч бүрд саналын хуудсыг дугуйн хамт олгоно.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

66¹.3. Саналын хуудас авсан сонгогчоор сонгогчдын нэрийн жагсаалтад гарын үсэг зуруулна.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

66¹.4. Энэ зүйлд өөрөөр заагаагүй бол гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажиллагаанд энэ хуулийн 65, 66 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

66¹.5. Салбар комисс санал авах ажиллагааны тухай тэмдэглэл хөтөлж бүх бүрэлдэхүүн гарын үсэг зурж, тэмдэг дарах бөгөөд уг тэмдэглэлд дараах мэдээллийг заавал тусгана:

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

66¹.5.1. сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн нийт сонгогчийн тоо;

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

66¹.5.2. саналын хуудас авсан сонгогчийн тоо;

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

66¹.5.3. саналын хуудас дахин авсан сонгогчийн тоо;

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

66¹.5.4. ажиглагчийн нэрс;

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

66¹.5.5. санал авах өдрийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл.

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

66¹.6. Гадаад улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэн энэ хуулийн 59.4.2-т заасан хэсэгт саналаа өгнө.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

67 дугаар зүйл. Сонгууль ажиглах

67.1. Сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, эсхүл нэр дэвшигч нь нэг санал авах байранд хоёр хүртэл, Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн төрийн бус байгууллага нэг санал авах байранд хоёр хүртэл сонгуулийн ажиглагч /цаашид "ажиглагч" гэх/-ийг томилж ажиллуулах эрхтэй.

[/Энэ хэсэгт "дөрөв" гэснийг "хоёр" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

67.2. Ажиглагч нь 18 нас хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай Монгол Улсын иргэн байна.

67.3. Нэр дэвшигч болон төрийн албан хаагч ажиглагч байхыг хориглоно.

67.4. Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, нэр дэвшигчийн менежер, шадар туслагч, ухуулагч ажиглагчаар томилогдсон бол сонгуулийн хорооны ажиллах байр болон санал авах байранд сонгуулийн сурталчилгаа, түүнтэй холбоотой аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

67.5. Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн гадаадын болон олон улсын байгууллага, гадаад улсын иргэн сонгуулийг ажиглаж болно.

67.6. Сонгууль ажиглах журам, түүнд холбогдох маягт, загварыг Сонгуулийн ерөнхий хороо батална.

67.7. Ажиглагч томилох эрх бүхий этгээд ажиглагч ажиллуулах, бүртгүүлэх хүсэлтээ Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан журмын дагуу бичгээр гаргаж, санал авах өдрөөс долоогоос доошгүй хоногийн өмнө хэсгийн хороонд хүргүүлнэ.

[/Энэ хэсэгт "таваас" гэснийг "долоогоос" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

67.8. Ажиглагчийг бүртгэх хугацаа өнгөрсөн бол хэсгийн хороо ажиглагч ажиллуулах, бүртгүүлэх тухай хүсэлтийг хүлээн авахгүй.

67.9. Хэсгийн хороо хүсэлтийг хүлээн авч нягтлан шалгаж, санал авах өдрөөс таваас доошгүй хоногийн өмнө ажиглагчийн үнэмлэх олгоно.

[/Энэ хэсэгт "хоёроос" гэснийг "таваас" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

67.10. Ажиглагч хуульд заагаагүй эрх эдлүүлэхийг шаардах, хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх, худал мэдээлэл нийтэд тараах зэрэг хууль бус арга хэрэглэж хэсгийн хорооны ажилд хөндлөнгөөс оролцвол хэсгийн хорооны дарга ажиглагчийн бүртгэлийг хүчингүй болгож, санал авах байраас гаргана.

67.11. Ажиглагч бүртгэлээс хасагдсан бол ажиглагч томилсон этгээд түүний оронд өөр хүнийг томилох эрхгүй.

67.12. Санал авах байрын багтаамжаас хамаарч бүх ажиглагч санал авах байранд нэгэн зэрэг ажиглалт хийх боломжгүй бол хэсгийн хороо ажиглагчдыг ээлжээр ажиглалт хийх боломжоор хангана.

67.13. Төрийн хэргийг удирдахад иргэдийг оролцуулах зорилт бүхий дүрэмтэй, улс төрийн намын дэргэд үйл ажиллагаа явуулдаггүй төрийн бус байгууллага нь сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт, хөндлөнгийн хяналт хийх эрхтэй.

67.14. Энэ хуулийн 67.13-т заасан үйл ажиллагааг зохицуулах журмыг Сонгуулийн ерөнхий хороо батална.

67.15. Энэ хуульд өөрөөр заагаагүй бол гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажиллагааг ажиглахтай холбогдсон харилцаанд сонгууль ажиглах ерөнхий журмыг баримтална.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

67.16. Ажиглагч томилох эрх бүхий этгээд гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажиллагаанд хоёр хүртэл ажиглагчийг томилон ажиллуулж болно.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

67.17. Ажиглагч томилох эрх бүхий этгээд гадаад улсад байгаа сонгогчдоос санал авах ажиллагаанд ажиглагч томилох бол энэ тухай хүсэлтээ төв комисст гадаадад санал авах өдрөөс долоогоос доошгүй хоногийн өмнө хүргүүлнэ.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

67.18. Төв комисс нь гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажиллагааг ажиглахаар томилогдсон ажиглагчийн мэдээллийг холбогдох салбар комисст хүргүүлэх бөгөөд ажиглагч нь гадаадад санал авах өдрөөс өмнө салбар комисст бүртгүүлж, ажиглагчийн үнэмлэх авна.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

67.19. Сонгогчийг санал өгсний дараа өгсөн саналынх нь талаар асуухыг хориглоно.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

68 дугаар зүйл. Ажиглагчийн эрх

68.1. Ажиглагч санал авах, тоолох, дүн гаргах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу явагдаж байгаа эсэхийг зөвхөн хөндлөнгөөс ажиглана.

68.2. Ажиглагч дараах эрх эдэлнэ:

68.2.1. саналын хуудасны битүүмжлэгдсэн байдал болон зарцуулалтын тайлантай танилцах;

68.2.2. санал авах үйл ажиллагааг ажиглах;

68.2.3. санал бэлтгэх бүхээг, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаг, санал тоолох төхөөрөмж, саналын хайрцаг болон санал авах байр хууль тогтоомжийн дагуу бэлтгэгдсэн эсэхтэй танилцах;

68.2.4. санал авах үйл явцад зөрчил гарвал хэсгийн хороонд мэдэгдэж, залруулахыг хүсэх;

68.2.5. сонгогчийн саналаа нууцаар гаргах эрх болон сонгуулийн хорооны хэвийн үйл ажиллагаанд саад учруулахгүйгээр дуу болон дүрс бичлэгийн хэрэгсэл ашиглан сонгуулийн үйл явцыг баримтжуулах;

68.2.6. хэсгийн хорооны гишүүнээс холбогдох мэдээлэл авах;

68.2.7. ажиглалтын тайланг бодит тоо, баримтад тулгуурлан гаргах;

68.2.8. санал тоолох төхөөрөмжөөс гарсан дүнгийн хуудас авах;

68.2.9. цахим хэлбэрээр хуулбарласан саналын хуудасны зурган мэдээллийг авах;

68.2.10. энэ хуулийн 65.11-д заасан жагсаалт болон тэмдэглэлтэй танилцах, уг жагсаалтыг сонгогчдын нэрийн жагсаалттай тулган үзэх.

68.3. Ажиглагчийн эрх ажиглагчийн үнэмлэх авснаар эхэлж, энэ хуульд заасны дагуу санал хураалтын дүн гарснаар дуусгавар болно.

68.4. Энэ хуульд заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн төрийн бус байгууллага нь нэр дэвшигч, нам, эвслийн сонгуулийн зардлын тайлан, түүнд холбогдох баримттай танилцах, хөндлөнгийн хяналт тавих эрхтэй.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

69 дүгээр зүйл. Санал авах өдөр санал тоолох төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах

69.1. Санал тоолох төхөөрөмжийн хэвийн ажиллагааг Мэдээллийн технологийн төв, ажлын хэсэг, мэдээллийн технологийн баг, даамал хариуцан ажиллана.

[/Энэ хэсэгт "Сонгуулийн санал авах өдөр санал тоолох" гэснийг "Санал тоолох" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

69.2.Мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал нь төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагч байх бөгөөд Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна. Мэдээлэл, технологийн багийн гишүүн, даамал нь санал авах, тоолох төхөөрөмжөөс дөрвөн метрээс багагүй зайд байрлаж, төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хянаж ажиллана.

69.3.Сургалт явуулах, гэрчилгээ олгох тухай журмыг Сонгуулийн ерөнхий хороо батална.

69.4.Санал авах байранд санал тоолох төхөөрөмжийг хариуцан ажиллаж байгаа даамал гэмтэл, саатал гарсан тохиолдолд дараах арга хэмжээг авна:

69.4.1.мэдээллийн технологийн багт шуурхай мэдэгдэх ба гэмтэл, саатлыг арилгах, боломжгүй тохиолдолд мэдээллийн технологийн багаас туслалцаа авах, санал тоолох нөөц төхөөрөмжид санал авах, тоолох ажиллагааг шилжүүлэх арга хэмжээг нэн даруй авах;

69.4.2.санал тоолох хоёр дахь болон нөөц төхөөрөмж байхгүй тохиолдолд хэсгийн хорооны зөвшөөрлөөр саналын хайрцгийн нөөц тасалгааны лацыг хөндөж саналын хуудсыг хийлгэх;

69.4.3.санал тоолох төхөөрөмж хэвийн ажиллагаанд шилжсэний дараа саналын хайрцгийн нөөц тасалгаан дахь саналын хуудсыг холбогдох журамд заасны дагуу төхөөрөмжид уншуулна.

69.5.Даамал сонгогчийн саналаа нууцаар гаргах эрхийг аливаа хэлбэрээр зөрчихийг хориглоно.

70 дугаар зүйл. Санал авах өдөр хориглох үйл ажиллагаа

70.1.Санал авах өдөр дараах үйл ажиллагааг хориглох бөгөөд аймаг, нийслэлийн Засаг дарга холбогдох шийдвэр гарган хяналт тавьж ажиллана:

70.1.1.согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдах;

70.1.2.соёл урлаг, үзвэр, спортын зэрэг олныг хамарсан аливаа арга хэмжээ зохион байгуулах;

70.1.3.гадаа болон битүү талбайд үйл ажиллагаа явуулдаг худалдаа, үйлчилгээний төв ажиллах.

71 дүгээр зүйл. Санал хураалтын дүн гаргах, дамжуулах

71.1.Мэдээллийн технологийн даамал санал авах ажиллагаа дуусмагц доорх ажиллагааг гүйцэтгэнэ:

71.1.1.санал тоолох төхөөрөмжөөс дүнгийн хуудсыг шаардлагатай тоогоор хэвлэж, хэсгийн хороонд өгөх;

71.1.2.санал хураалтын дүнг энэ хуулийн 71.5-д заасан хэсгийн хорооны ажиллагаанаас хамаарахгүйгээр Сонгуулийн ерөнхий хороонд нэн даруй дамжуулах.

71.2.Санал авах ажиллагааны хуулиар тогтоосон цаг дуусаагүй байхад санал тоолох төхөөрөмжөөс дүнгийн хуудсыг хэвлэж гаргахыг хориглоно.

71.3.Санал хураалтын дүнг дамжуулахгүй байх, саатуулах, зогсоохыг хориглоно.

71.4.Санал хураалтын дүнг дамжуулах үеийн хамгаалалтыг тухайн санал авах байрны хамгаалалтад ажиллаж байгаа цагдаагийн албан хаагч хариуцна.

71.5.Хэсгийн хороо дараах ажиллагааг гүйцэтгэнэ:

71.5.1.хэсгийн хороо нь санал тоолох төхөөрөмжөөс гарсан дүнгийн хуудсыг ажиглагч нарт өгч, дүн танилцуулсан тухай тэмдэглэл хөтлөх;

71.5.2.санал авах байранд болон зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар саналаа өгсөн сонгогчийн тоо нь санал авахад олгосон саналын хуудасны тоо, буруу тэмдэглэл хийснээс болон санал тоолох төхөөрөмж саналын хуудсыг таньж уншаагүйгээс буцааж хураагдсан саналын хуудасны тоо нь тухайн хэсгийн хорооны хүлээн авсан саналын хуудасны тоотой тохирч байгаа эсэхийг тулган шалгаж, тооцоог эцэслэн гаргах; [/Энэ заалтад "хураагдсан саналын хуудасны" гэсний дараа "тоо нь тухайн хэсгийн хорооны хүлээн авсан саналын хуудасны" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

71.5.3.санал авахад зарцуулсан болон зарцуулагдаагүй үлдсэн саналын хуудасны нийлбэр нь тухайн хэсгийн хорооны хүлээн авсан нийт саналын хуудасны тооноос зөрвөл шалтгааныг тогтоох бөгөөд шаардлагатай гэж үзвэл саналын хуудсыг нэн даруй дахин тоолж, тэмдэглэл үйлдэнэ. Тэмдэглэлд хэсгийн хорооны дарга, гишүүд гарын үсэг зурна;

71.5.4.энэ хуулийн 4.8.1-д заасан нэмэлт санал хураалт явагдах нөхцөл үүссэнээс бусад тохиолдолд санал авахад зарцуулагдаагүй үлдсэн саналын хуудасны баруун доод өнцгийг нь хайчлан, энэ тухай тэмдэглэлд тусган боож, битүүмжлэх.

71.6.Хэсгийн хороо дүн дамжуулах, танилцуулах ажиллагааг ил тод, нээлттэй явуулна. Хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг байлцуулж болно.

71.7.Санал тоолох төхөөрөмжөөс гарсан дүн нь тухайн хэсгийн санал хураалтын дүн байна.

71.8.Санал хураалтын дүнгийн хуудас дараах мэдээллийг агуулна:

71.8.1.санал тоолох төхөөрөмжид уншигдсан нийт саналын хуудасны тоо;

71.8.2.тойрогт нэр дэвшигч бүрийн авсан саналын тоо;

[/Энэ заалтад "нэр дэвшигч" гэсний өмнө "тойрог" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

71.8.3.санал огт тэмдэглээгүй саналын хуудасны тоо.

71.8.4.нам, эвсэл бүрийн авсан саналын тоо.

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

71.9.Санал тоолох төхөөрөмжид уншигдсан нийт саналын хуудас нь хүчинтэй саналын хуудас байна.

71.10.Сонгогч нэг ч нэр дэвшигч, эсхүл нам, эвслийн төлөө санал өгөөгүй бол хэнийг ч дэмжээгүй санал гэж үзэн тухайн сонгогчийг санал өгсөн сонгогчдын тоонд оруулан тоолох ба энэ тохиолдолд уг саналын хуудсыг хүчинтэй саналын хуудаст тооцно.

[/Энэ хэсэгт "дэвшигчийн" гэсний "дэвшигч, эсхүл нам, эвслийн" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

71.11.Энэ хуулийн 71.5.3-т заасны дагуу саналын хуудсыг дахин тоолоход сонгогчдын саналыг тоолохгүй.

71.12.Санал хураалтын дүнг санал тоолох төхөөрөмжөөр гаргах боломжгүй нөхцөл байдал үүссэн бол тухайн хэсгийн санал хураалтын дүнг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан журмын дагуу гаргана.

71.13.Санал авах байранд ажилласан ажиглагчийн хүсэлтийг үндэслэн саналын хуудасны зурган мэдээллийг өгөх бөгөөд уг ажлыг хэсгийн хороо, мэдээллийн технологийн даамал болон итгэмжлэгдсэн ажилтан хариуцна.

71.14.Санал авах ажиллагаа дууссаны дараа бүх хэсэгт хяналтын тооллого хийнэ.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

71.15.энэ хуулийн 71.5-д заасан ажиллагааг гүйцэтгэж дуусмагц санал тоолох төхөөрөмжид уншигдсан саналын хуудсыг гар аргаар нэг бүрчлэн тоолно.

[/Энэ хэсгээс "Хяналтын тооллого хийхээр сонгогдсон хэсгийн хороо" гэснийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хассан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

- 71.16.Хяналтын тооллого хийх ажиллагаанд ажиглагч, хэвлэл мэдээллийн байгууллагын болон сонгогчдын төлөөллийг ажиглагчаар оролцуулж болно.
[/Энэ хэсэгт "байгууллагын" гэсний дараа "болон сонгогчдын" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)
- 71.17.Санал тоолж эхэлсэн бол завсарлахыг хориглоно.
- 71.18.Хяналтын тооллого хийх журмыг Сонгуулийн ерөнхий хороо батална.

72 дугаар зүйл.Саналын хуудсыг хүчингүйд тооцох

- 72.1.Тойрогт ногдсон мандатын тооноос илүү, эсхүл дутуу нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн, нам, эвслийн санал тэмдэглэх хэсэгт нэгээс илүү нам, эвсэлд санал тэмдэглэсэн саналын хуудсыг хүчингүйд тооцно.
[/Энэ хэсэгт "тэмдэглэсэн" гэсний дараа " нам, эвслийн санал тэмдэглэх хэсэгт нэгээс илүү нам, эвсэлд санал тэмдэглэсэн" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)
- 72.2.Баталсан загвар, шаардлагыг хангаагүй саналын хуудас хүчингүй байх бөгөөд хүчингүй саналын хуудсаар санал авах, өгөхийг хориглоно.

72' дүгээр зүйл.Гадаад улсад байгаа иргэдээс авсан саналыг тоолох

- [/Энэ зүйлийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)
- 72'.1.Гадаад улсад байгаа иргэдийн санал тоолох ажиллагааг Сонгуулийн ерөнхий хороо гүйцэтгэнэ.
[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)
- 72'.2.Сонгуулийн ерөнхий хороо санал тоолох ажиллагааг өөрийн байранд санал авах өдрийн 22:00 цагт эхэлж, ажиглагч, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг байлцуулан ил тод, нээлттэй явуулна.
[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)
- 72'.3.Сонгуулийн ерөнхий хороо дараах ажиллагааг гүйцэтгэсний дараа саналын хуудсыг санал тоолох төхөөрөмжид хийж саналыг тоолон санал хураалтын дүнг гаргаж нэн даруй мэдэвлэнэ:
[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)
- 72'.3.1.төв комиссоос ирүүлсэн саналын хуудас бүхий битүүмжилсэн дугтуйн нийт тоо нь санал авахад олгосон саналын хуудасны тоотой тохирч байгаа эсэхийг тулган шалгаж, эцсийн тооцоо гаргах;
[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)
- 72'.3.2.санал авахад зарцуулаагүй үлдсэн болон буруу тэмдэглэл хийснээс хураагдсан саналын хуудсыг тус тусад нь тоолох;
[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)
- 72'.3.3.битүүмжилсэн дугтуйнуудыг нээж, саналын хуудсыг санал тоолох төхөөрөмжид хийхэд бэлэн болгох.
[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)
- 72'.4.Гадаад улсад байгаа иргэдийн санал тоолох, дүн дамжуулах ажиллагааг явуулахад тухайн салбар комисст санал тоолох төхөөрөмжийг Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрээр хэрэглэж болно.
[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

73 дугаар зүйл.Санал хураалтын дүн, сонгуулийн баримт бичгийг хүргүүлэх

- 73.1.Хэсгийн хороо санал тоолох төхөөрөмжөөс хэвлэсэн тухайн хэсгийн санал хураалтын дүнг танилцуулсны дараа санал хураалтын дүнгийн хуудсыг сонгуулийн бусад бичиг баримтын хамт сум, дүүргийн сонгуулийн хороонд, сум, дүүргийн сонгуулийн хороо нь аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд, аймаг нийслэлийн сонгуулийн хороо нь Сонгуулийн ерөнхий хороонд тус тус нэн даруй хүргүүлнэ.
- 73.2.Хэсгийн хороо саналын хайрцаг /санал тоолох төхөөрөмж/-аас гарсан саналын хуудас, буцааж хураагдсан саналын хуудас, зарцуулагдаагүй үлдсэн саналын хуудсыг тус тусад нь тоолон, багцлан боож битүүмжлэн, сонгуулийн бусад баримт бичгийн хамт сум, дүүргийн сонгуулийн хороонд, сум, дүүргийн сонгуулийн хороо нь аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд хүргүүлэх бөгөөд холбогдох журамд заасны дагуу аймаг, нийслэлийн архивт хүлээлгэн өгнө.
- 73.3.Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо өөрийн нутаг дэвсгэрийн хэмжээн дэх санал хураалтын дүнг сум, дүүргийн сонгуулийн хорооноос ирүүлсэн хэсгийн хорооны санал хураалтын дүнг үндэслэн нэгтгэнэ.

74 дүгээр зүйл.Сонгуулийн дүн гаргах, мэдээлэх

- 74.1.Сонгуулийн ерөнхий хороо энэ хуулийн 4.3.1-д заасан сонгуулийн тойрогт нэр дэвшигчийн санал хураалтын дүнг дараах байдлаар гаргана:
[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)
- 74.1.1.Сонгуулийн ерөнхий хороо нь санал хураалтын дүнг үндэслэн тухайн тойрогт нэр дэвшсэн нийт нэр дэвшигчдийг авсан саналынх нь тоогоор дараалалд оруулан жагсаалт гаргана;
[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)
- 74.1.2.хамгийн олон санал авсан, тухайн тойрогт ногдох мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцно.
[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)
- 74.2.Дараах шаардлагыг хангасан нам, эвсэлд энэ хуульд заасны дагуу суудал хуваарилна:
[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)
- 74.2.1.энэ хуулийн 4.3.1-д заасан тойрогт ногдох нийт мандатын 50 буюу түүнээс дээш хувьд нь нэр дэвшүүлсэн байх;
[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)
- 74.2.2.намын тухайд нам, эвсэлд өгсөн нийт саналын 4 буюу түүнээс дээш хувийн санал авсан байх;
[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)
- 74.2.3.хоёр нам бүхий эвслийн тухайд нам, эвсэлд өгсөн нийт саналын 5 буюу түүнээс дээш хувийн санал авсан байх;
[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)
- 74.2.4.гурав буюу түүнээс дээш нам бүхий эвслийн тухайд нам, эвсэлд өгсөн нийт саналын 7 буюу түүнээс дээш хувийн санал авсан байх.
[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)
- 74.3.Сонгуулийн ерөнхий хороо энэ хуулийн 4.3.2-т заасан жагсаалтаар нэр дэвшигчийн санал хураалтын дүнг дараах байдлаар гаргана:
[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)
- 74.3.1.санал хураалтын дүнг үндэслэн нам, эвсэл тус бүрээр авсан саналынх нь тоо, хувиар дараалалд оруулан жагсаалт гаргана;
[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)
- 74.3.2.энэ хуулийн 74.2-т заасан шаардлага хангасан нам, эвслийн авсан саналын хувь болон нийт нам, эвсэлд өгсөн хүчинтэй саналын хувь хоорондын зөрүүг энэ хуулийн 74.2-т заасан шаардлага хангасан нам, эвсэлд тэнцүү хэмжээгээр хуваан нам, эвсэл тус бүрийн авсан саналын

хувь дээр нэмж тооцно;

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)
74.3.3.энэ хуулийн 74.3.2-т заасны дагуу тооцож гаргасан хувиудын нийлбэрийг 48-д хувааж нэг суудалд ногдох саналын тоо, хувийг тооцож гаргана;

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

74.3.4.энэ хуулийн 74.3.2-т заасны дагуу тооцож гаргасан нам, эвсэл тус бүрийн авсан саналын хувийг энэ хуулийн 74.3.3-т заасны дагуу тооцож гаргасан нэг суудалд ногдох саналын хувьд хувааж, Улсын Их Хурлын гишүүний 48 суудлыг их үлдэгдлийн зарчмаар хувь тэнцүүлэн хуваарилна;

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

74.3.5.энэ хуулийн 74.3.4-т заасны дагуу нэг суудалд ногдох саналын хувьд хуваахдаа бутархай нарийвчлалтай гаргаж, эхний ээлжид бүхэл хэсэгт нь тэнцэх суудлыг хуваарилах, хэрэв хуваарилагдаагүй суудал үлдвэл хамгийн их үлдэгдэлтэйгээс нь эхлэн нэг нэгээр суудлыг нам, эвсэлд нэмж хуваарилах зарчмаар бүх суудлыг хуваарилж дуусгана;

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

Тайлбар: "хуваарилагдаагүй суудал" гэж энэ хуулийн 74.3.4-т заасны дагуу нам, эвслийн авсан саналын бүхэл хэсэгт нь ногдох суудал хуваарилахад суудал хуваарилагдаагүй үлдсэн, мөн нам, эвслийн авсан саналд ногдох суудлын тоо нь тухайн нам, эвслийн жагсаалтаар нэр дэвшигчийн тооноос их тооцогдсоны улмаас суудал хуваарилагдаагүй үлдэхийг ойлгоно.

[/Энэ тайлбарыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

74.3.6.Сонгуулийн ерөнхий хороо энэ хуульд заасны дагуу нам, эвслээс ирүүлсэн нэр дэвшигчдийн жагсаалтыг үндэслэн энэ хуулийн 74.3.4-т заасны дагуу хуваарилсан суудлын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцно.

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

74.4.Сонгуулийн ерөнхий хороо энэ хуулийн 74.1, 74.3-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцсон тухай шийдвэр гаргаж, Улсын Их Хурлын гишүүний үнэмлэх олгож, нийтэд мэдээлнэ.

[/Энэ хэсгийн "74.3" дугаарыг "74.4" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

74.5.Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн дүн, Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцсон тухай шийдвэрийг сонгууль дууссанаас хойш 15 хоногийн дотор Улсын Их Хурал болон Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.

[/Энэ хэсгийн "74.4" дугаарыг "74.5" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

АРАВДУГААР БҮЛЭГ

ЭЭЛЖИТ БУС, НӨХӨН СОНГУУЛЬ ЯВУУЛАХ, ОРОН ГАРСАН СУУДЛЫГ НӨХӨХ, НЭМЭЛТ БОЛОН ДАХИН САНАЛ ХУРААЛТ ЯВУУЛАХ

75 дугаар зүйл.Нэр дэвшигчийг хасах

75.1.Нэр дэвшигч бүртгүүлсний дараа тухайн нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах үндэслэл тогтоогдсон бол Сонгуулийн ерөнхий хороо тухайн нэр дэвшигчийг бүртгэсэн тухай шийдвэрээ хүчингүй болгож, нийтэд мэдээлнэ.

75.2.Нэр дэвшигч энэ хуулийн 35.3, 38.2, 48.1, 48.5.1, 48.5.2, 56.2-т заасныг зөрчсөн болох нь санал хураалтын дүн гаргахаас өмнө тогтоогдсон бол Сонгуулийн ерөнхий хороо тухайн нэр дэвшигчийг бүртгэсэн тухай шийдвэрээ хүчингүй болгож, нийтэд мэдээлнэ.

75.3.Саналын хуудас хэвлэгдэхээс өмнө нэр дэвшигчийг бүртгэсэн тухай шийдвэрийг хүчингүйд тооцсон бол түүний нэрийг саналын хуудаст бичихгүй.

75.4.Саналын хуудас хэвлэгдсэний дараа нэр дэвшигчийг бүртгэсэн тухай шийдвэрийг хүчингүйд тооцсон бол саналын хуудсыг дахин хэвлэх бөгөөд дахин хэвлэх боломжгүй бол уг саналын хуудсаар санал авч, хасагдсан нэр дэвшигчид өгсөн саналыг санал хураалтын дүнд оруулан тооцохгүй.

76 дугаар зүйл.Ээлжит бус сонгууль явуулах

76.1.Энэ хуулийн 4.6-д заасан үндэслэлээр ээлжит бус сонгууль явагдана.

76.2.Ээлжит бус сонгуулийг энэ хуульд заасны дагуу зохион байгуулж явуулна.

77 дугаар зүйл.Нөхөн сонгууль явуулах, орон гарсан суудлыг нөхөх

[/Энэ зүйлийн гарчигт "явуулах" гэсний дараа " , орон гарсан суудлыг нөхөх" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

77.1.Энэ хуулийн 4.3.2-т заасан жагсаалтаар нэр дэвшиж сонгогдсон Улсын Их Хурлын гишүүний орон гарсан бол тухайн нам, эвслийн жагсаалтын дараагийн нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцсон тухай шийдвэрийг Сонгуулийн ерөнхий хороо орон гарснаас хойш 14 хоногийн дотор гаргаж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

77.2.Энэ хуулийн 4.3.1-д заасан сонгуулийн тойрогт нэр дэвшиж сонгогдсон Улсын Их Хурлын гишүүний орон гарсан, мөн энэ хуулийн 77.1-д заасны дагуу сонгогдсонд тооцох дараагийн нэр дэвшигч үлдээгүй бол нөхөн сонгууль явагдана.

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

77.3.Орон гарсан Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахад нэг жил хүрэхгүй хугацаа үлдсэн бол орон гарсан суудлыг нөхөхгүй.

[/Энэ хэсгийн "77.2" дугаарыг "77.3" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

[/Энэ хэсэгт "зургаан сар" гэснийг "нэг жил" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

77.4.Нөхөн сонгогдсон Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хугацаа нь орон гарсан гишүүний бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна.

[/Энэ хэсгийн "77.3" дугаарыг "77.4" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

77.5.Нөхөн сонгуулийг зохион байгуулахад тухайн тойрогт өөрчлөлт оруулахгүй бөгөөд энэ хуульд заасны дагуу зохион байгуулна.

[/Энэ хэсгийн "77.4" дугаарыг "77.5" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

78 дугаар зүйл. Нэмэлт санал хураалт явуулах

- 78.1. Нэр дэвшигчдийг авсан саналын тоогоор нь жагсааж, мандатын тоогоор таслахад нэр дэвшигчдийн авсан саналын тоо тэнцсэний улмаас мандатад хуваарилагдах боломжгүй болсон бол тухайн тойрогт нэмэлт санал хураалт явуулна.
- 78.2. Сонгуулийн тойрогт хамаарах сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдсэн нийт сонгогчдын тавь буюу түүнээс дээш хувь нь санал хураалтад оролцоогүй бол тавин хувь нь оролцоогүй хэсэг тус бүрд нэмэлт санал хураалт явуулна.
- 78.3. Нэмэлт санал хураалтад санал нь тэнцсэн нэр дэвшигчдийг оруулах бөгөөд эхний санал хураалтад оролцоогүй, сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчдыг нэмэлт санал хураалтад оролцуулна.
- 78.4. Нэмэлт санал хураалтад оролцсон сонгогчдын ирц, саналын тоог эхний санал хураалтад оролцсон сонгогчдын ирц, саналын тоо дээр нэмж тооцно.
- 78.5. Нэмэлт санал хураалтад орсон нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан, үлдсэн мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон тооцно.
- 78.6. Нэмэлт санал хураалт явуулах тухай шийдвэрийг Сонгуулийн ерөнхий хороо гаргах бөгөөд шийдвэр гарснаас хойш долоо хоногийн дотор зохион байгуулж явуулна.

79 дүгээр зүйл. Санал хураалтыг хүчингүйд тооцох, дахин санал хураалт явуулах

- 79.1. Санал хураалтыг дараах тохиолдолд хүчингүйд тооцно:
- 79.1.1. Байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон зэрэг хүндэтгэн үзэх шалтгаангүй байхад урьд нь зарласнаас өөр байранд санал авсан, түүнчлэн зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаг асваснаас бусад тохиолдолд санал авахаар зарласнаас өөр өдөр санал авсан нь сонгуулийн дүнд ноцтой нөлөөлөхөөр бол;
- 79.1.2. Саналын хуудас бүхий зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгийг алдсан, үрэгдүүлсэн, санал авах журам зөрчсөн нь сонгуулийн дүнд ноцтой нөлөөлөхөөр бол.
- 79.2. Энэ хуулийн 79.1-д заасан тохиолдолд санал авах ажиллагааг Сонгуулийн ерөнхий хороо хүчингүйд тооцож хүчингүйд тооцсон хэмжээгээр дахин санал хураалт явуулна.
- 79.3. Дахин санал хураалт явуулах тухай шийдвэрийг Сонгуулийн ерөнхий хороо гаргах бөгөөд шийдвэр гарснаас хойш долоо хоногийн дотор зохион байгуулж явуулна.
- 79.4. Дахин санал хураалтад дараах сонгогчийг оролцуулна:
- 79.4.1. Хэсгийн хэмжээгээр хүчингүйд тооцсон бол хүчингүйд тооцсон тухайн хэсгийн нийт сонгогчийг;
- 79.4.2. Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаг асваснаас бусад саналыг хүчингүйд тооцсон бол уг саналын хайрцагт саналаа өгсөн сонгогчийг.
- Тайлбар: "Сонгуулийн дүнд ноцтой нөлөөлөх" гэдгийг санал хураалтын явцад гарсан зөрчил нь сонгуулийн дүнд илт нөлөөлөхүйц буюу сонгогдсон тооцогдсон нэр дэвшигч ба түүний дараах нэр дэвшигчийн авсан саналын зөрүүтэй тэнцүү, эсхүл илүү байхыг ойлгоно.
- 79.5. Нэмэлт болон дахин санал хураалтын хугацаанд сонгуулийн сурталчилгаа явуулахыг хориглоно.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ХУУЛЬ ТОГТООМЖ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА, ГОМДОЛ МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ХАРЬАЛАЛ

80 дугаар зүйл. Сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

- 80.1. Сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Зөрчлийн тухай хууль болон Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

81 дүгээр зүйл. Сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн тухай гомдол, маргааныг шийдвэрлэх харьяалал

- 81.1. Сонгуулийн гомдол, маргааныг хянан шийдвэрлэж байгаа эрх бүхий этгээд нь тухайн гомдол, маргааны онцлог байдлыг харгалзан энэ хуульд өөрөөр заагаагүй бол тухайн сонгуулийн жилд багтаан шийдвэрлэнэ.
- 81.2. Сонгуулийн хороод энэ хуульд заасны дагуу шатлан захирагдах зарчмаар ажиллах бөгөөд сум, дүүргийн сонгуулийн хорооны шийдвэрт холбогдуулан аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд, аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны шийдвэрт холбогдуулан Сонгуулийн ерөнхий хороонд тус тус гомдол гаргана.
- 81.3. Энэ хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу санал хураалтын дүнг өргөн мэдүүлсэн Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдуулан гаргасан маргааныг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэнэ.
- [/Энэ хэсэгт "хуульд" гэснийг "хуулийн 74 дүгээр зүйлд" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)
- 81.4. Энэ хуулийн 81.3-т зааснаас бусад Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдох маргааныг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар, Улсын дээд шүүх давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ.
- 81.5. Сонгуулийн хороодын шийдвэр гарснаас хойш долоо хоногийн дотор өргөдөл, гомдол гаргах бөгөөд хугацаа хэтэрсэн гомдлыг хүлээн авахгүй.
- 81.6. Сонгогчид бэлэн мөнгө, эд зүйл тараасныг сонгогч баримттайгаар цагдаагийн байгууллагад мэдэгдэж болно.
- 81.7. Сонгогчид хууль бусаар мөнгө, эд зүйл тараасан болох нь тогтоогдсон бол мэдээлэл гаргасан иргэн тараасан бэлэн мөнгө болон эд барааны үнийн дүнг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг гэм бүрүүтэй этгээдээс гаргуулахаар шаардах эрхтэй.
- 81.8. Шүүх энэ хуулийн 81.3-т заасны дагуу маргаан хянан шийдвэрлэхдээ захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэхгүй.
- [/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ

БУСАД АСУУДАЛ

82 дугаар зүйл. Сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах

- 82.1. Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн санал авах өдрөөс өмнөх нэг жилийн хугацаанд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.

83 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

- 83.1. Энэ хуулийг 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Эх сурвалж: "Төрийн мэдээлэл" сэтгүүл, 2023 оны 09 дүгээр сарын 11, №34(1282)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ (Онцлог зохицуулалтууд)



СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын 126 гишүүнийг дараах байдлаар сонгоно:


1. Улсын Их Хурлын 78 гишүүнийг энэ хуульд заасны дагуу байгуулагдсан сонгуулийн тойргоос олныг төлөөлөх /мажоритар*/ аргаар;

2. Улсын Их Хурлын 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх /пропорционал**/ аргаар.

Улсын Их Хурлын гишүүнийг жагсаалтаар сонгох сонгуульд Монгол Улсын нутаг дэвсгэр сонгуулийн нэг тойрог байна.

* "олныг төлөөлөх /мажоритар/ арга" гэж тухайн тойрогт ногдох мандатын тоотой тэнцүү бөгөөд хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцохыг ойлгоно.

** "хувь тэнцүүлэн төлөөлөх /пропорционал/ арга" гэж сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвслийн авсан саналынх нь тоо, хувьд үндэслэн энэ хуульд заасны дагуу суудал хуваарилж, Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцохыг ойлгоно.



Монгол улсын дипломат төлөөлөгчийн газар байрладаг гадаад улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэн сонгуульд оролцож, санал өгөх эрхтэй.

Гадаадад санал авах өдөр нь дөрөв хүртэл өдөр байна.



СОНГОХ, СОНГОГДОХ ЭРХ

Сонгогчдын нэрийн жагсаалтын ил тод, хяналттай байдал

Сонгогч өөрийн болон өөрийн байнга оршин суугаа хаягийн бүртгэлд бүртгэгдсэн нийт сонгогчийн мэдээлэлтэй танилцана.

Сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвсэлд сонгогчдын нэрийн жагсаалтыг санал авах өдрөөс 20-иос доошгүй хоногийн өмнө болон санал авах өдрөөс 3 хоногийн өмнө тус тус цахим хэлбэрээр нэг удаа олгоно.

Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн төрийн бус байгууллагын төлөөлөл сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх ажиллагаатай танилцаж болно.



НЭР ДЭВШҮҮЛЭХ

Тойрогт болон жагсаалтад зэрэг нэр дэвшихийг хориглоно.

2024 оны ээлжит сонгуулиар
нийт нэр дэвшигчийн хувьд

30%

доошгүй хувь нь
аль нэг хүйсийнх

2028 оны ээлжит сонгуулиар

40%

доошгүй хувь нь
аль нэг хүйсийнх

Нам, эвсэл жагсаалтаар нэр дэвшүүлэхдээ 1:1 хүйсийн харьцаатай жагсаалтын дарааллыг үндэслэн нэр дэвшүүлнэ.

СОНГУУЛИЙН ЗАРДАЛ, СУРТАЛЧИЛГААНЫ АРГА ХЭЛБЭР

1

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ:

хоёр

2

ХЭВЛЭМЭЛ МАТЕРИАЛ:

хоёр хэвлэлийн хуудас сонин;

хоёр хэвлэлийн хуудас сэтгүүл;

3

Нам, эвслээс **жагсаалтаар нэр дэвшигчийн** сонгуулийн сурталчилгааны **нэгдсэн** хэвлэмэл материал нь **гурван хэвлэлийн хуудаснаас хэтрэхгүй** байна.

4

НЭГДСЭН САМБАР

Тойрогт нэр дэвшигчдийн зурагт хуудсыг байрлуулсан нэгдсэн самбарыг сум, дүүргийн Засаг дарга бэлтгэж, байршуулах ажлыг зохион байгуулна:

- нэр дэвшигчийн зурагт хуудас нь нэг хэвлэлийн **хуудасны дөрөвний нэг** хэмжээтэй байна.
- онгогчийн тоонд үндэслэн **суманд хоёр хүртэл, аймгийн төвийн суманд тав хүртэл, хороонд дөрөв хүртэл нэгдсэн самбарыг үнэ төлбөргүй байрлуулна.**

5

ЗУРАГТ САМБАР

Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага нь найман хэвлэлийн хуудаснаас илүүгүй хэмжээтэй зурагт самбарыг суманд нэг, хороонд хоёр хүртэл байрлуулж болно.

6

УХУУЛАГЧ:

Нийслэл болон аймгийн төвд **400 сонгогч** тутамд нэг ухуулагч, бусад газарт **200 хүртэлх** сонгогч тутамд нэг ухуулагчтай байж болно.

7

МЭТГЭЛЦЭЭН:

Олон нийтийн радио, телевиз сурталчилгааны болон мэтгэлцээний нэвтрүүлгийг төлбөргүй нэвтрүүлнэ.

8

ЦАХИМ СУРТАЛЧИЛГАА:

Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах зардал энэ хуулийн тойрогт нэр дэвшигчийн зардлын дээд хэмжээний **15 хувиас хэтрэхгүй** байна.



ЗАРДЛЫН ДЭЭД ХЭМЖЭЭГ 2 ШАТЛАЛТАЙГААР БУУРУУЛАХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН БҮРДСЭН:

Сонгуулийн зардлын дээд хэмжээ тогтоох аргачлал нь сонгуулийн зардлыг бууруулахад чиглэх бөгөөд сонгуулийн нутаг дэвсгэрийн хэмжээ, байршил, өрхийн болон сонгогчийн тоо, энэ хуульд заасан бусад шаардлагад үндэслэнэ.



САНАЛЫН ХУУДАС, САНАЛ АВАХ АЖИЛЛАГАА

Саналын хуудас нь дараах хэсэгтэй байна:

1. сонгуулийн тойрогт нэр дэвшигчид өгсөн саналыг тэмдэглэх;
2. нам, эвсэлд өгсөн саналыг тэмдэглэх. Сонгогч саналаа өгснийг илэрхийлэх бэхэн тэмдэглэгээг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан зааврын дагуу хийнэ

ХЯНАЛТЫН ТООЛЛОГО 100 ХУВЬ

Санал авах ажиллагаа дууссаны дараа бүх хэсэгт хяналтын тооллого хийнэ.



ДҮН ГАРГАХ

Дараах шаардлагыг хангасан нам, эвсэлд энэ хуульд заасны дагуу суудал хуваарилна.

1. Тойрогт ногдох нийт мандатын 50 буюу түүнээс дээш хувьд нь нэр дэвшүүлсэн байх;
2. Намын тухайд нам, эвсэлд өгсөн нийт саналын 4 буюу түүнээс дээш хувийн санал авсан байх;
3. Хоёр нам бүхий эвслийн тухайд нам, эвсэлд өгсөн нийт саналын 5 буюу түүнээс дээш хувийн санал авсан байх;
4. Гурав буюу түүнээс дээш нам бүхий эвслийн тухайд нам, эвсэлд өгсөн нийт саналын 7 буюу түүнээс дээш хувийн санал авсан байх.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 сарын 07 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын иргэний эвлэлдэн нэгдэх эрхийг хангах зорилгоор улс төрийн нам /цаашид "нам" гэх/ үүсгэн байгуулах, намын бүртгэлд бүртгэх, өөрчлөн байгуулах, татан буулгах, намын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, хяналт, санхүүжилт, хариуцлагын эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Улс төрийн намын хууль тогтоомж

2.1.Улс төрийн намын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

- 3.1.1."намын гишүүн" гэж намын зорилго, үзэл баримтлал, намын хөтөлбөр, дүрмийг хүлээн зөвшөөрч, сайн дурын үндсэн дээр намд эвлэлдэн нэгдэж элссэн, гишүүний татвар төлдөг, тухайн намын үйл ажиллагаанд саналын болон сонгох, сонгогдох эрхтэйгээр оролцох иргэнийг;
- 3.1.2."намын гишүүнээс түдгэлзэх" гэж намын гишүүний эрхгүй, намын гишүүний, эсхүл намын дэмжигчийн хувиар намын үйл ажиллагаанд оролцохгүй байхыг;
- 3.1.3."намын дэмжигч" гэж намын зорилго, үзэл баримтлалыг сайн дурын үндсэн дээр дэмжин намын үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог иргэнийг;
- 3.1.4."намын сонгуулийн мөрийн хөтөлбөр" гэж намын хөтөлбөрт үндэслэсэн тухайн төлөөлөгчдийн байгууллага, албан тушаалтны бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн бодлого, үйл ажиллагааны чиглэлийг;
- 3.1.5."намын санхүүгийн тайлан" гэж тайлант хугацаанд намаас энэ хуульд заасны дагуу гаргасан болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.1-д заасан тайлангийн цахим болон хэвлэмэл мэдээллийн бүрдлийг;
- 3.1.6."намын харьяа байгууллага" гэж намын зорилго, зорилтыг биелүүлэх хүрээнд намын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа эрхэлдэг, эсхүл намын үйл ажиллагааны хүрээнд үүсгэн байгуулагдсан, намтай холбоотой сан, холбоо болон төрийн бус байгууллагыг;
- 3.1.7."намын хөтөлбөр" гэж намын үзэл баримтлал, үнэт зүйл, зарчимд тулгуурлан үйл ажиллагааны үндсэн чиглэл, зорилгыг тодорхойлсон бодлогын баримт бичгийг;
- 3.1.8."сонгуульт гишүүн" гэж намаас төрийн улс төрийн албан тушаалд нэр дэвшин сонгогдсон, томилогдсон болон намын бүх шатны удирдах, төлөөллийн, гүйцэтгэх байгууллага, удирдах албан тушаалд сонгогдсон намын гишүүнийг;
- 3.1.9."төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг" гэж энэ хуульд заасан нөхцөлийг хангасан намд олгох төрийн санхүүжилт болон төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэгийг;
- 3.1.10."төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэг" гэж төрөөс намд олгож байгаа мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээний хэлбэрээр үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг;
- 3.1.11."төрийн санхүүжилт" гэж нам чиг үүргээ хэрэгжүүлэхэд зориулж, санхүүжилтийн зохих хэсэгт нь төрөөс мөнгөн хэлбэрээр олгож байгаа санхүүгийн дэмжлэгийг;
- 3.1.12."төрийн санхүүжилтийн эрх үүсэх жил" гэж Улсын Их Хурлын ээлжит болон ээлжит бус сонгуулийн дараа жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэх жилийг;
- 3.1.13."хандив" гэж иргэн, хуулийн этгээдээс намын өмчлөлд хариу төлбөргүйгээр шилжүүлсэн мөнгөн болон мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээ, төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг.

4 дүгээр зүйл.Улс төрийн нам, түүний чиг үүрэг

- 4.1.Нам нь иргэдийн улс төрийн хүсэл зоригийг илэрхийлдэг, улсын хэмжээний бодлого дэвшүүлэн сонгуульд оролцдог, хамтын шийдвэр гаргаж, сайн дураараа эвлэлдэн нэгдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл мөн.
- 4.2.Нам нь Үндсэн хуульт байгуулал, ардчилсан тогтолцооны зайлшгүй бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
 - 4.2.1.иргэдийн улс төрийн хүсэл зориг, олон нийтийн үзэл бодлыг илэрхийлэх;
 - 4.2.2.төр, иргэдийн хооронд байнгын, тогтвортой, идэвхтэй холбоо харилцаа үүсгэх;
 - 4.2.3.иргэдийн улс төрийн боловсрол, идэвхтэй оролцоог хөхиүлэн дэмжих;
 - 4.2.4.төрийн улс төрийн алба хаах хариуцлагатай иргэнийг бэлтгэх;
 - 4.2.5.Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцох;
 - 4.2.6.сонгуульд нэр дэвшүүлэн шударгаар өрсөлдөх.

5 дугаар зүйл. Улс төрийн намд эвлэлдэн нэгдэх иргэний эрх

- 5.1. Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэн сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэх, нам байгуулах, намд элсэх, намаас гарах, хууль тогтоомж болон тухайн намын дүрэм, намын хөтөлбөрт нийцүүлэн түүний үйл ажиллагаанд оролцох, намыг дэмжих, эс дэмжих эрхтэй.
- 5.2. Аль нэг намд эвлэлдэн нэгдсэний төлөө болон намын гишүүний хувьд иргэнийг аливаа хэлбэрээр мөрдөн мөшгих, заналхийлэх, дарамтлах, ялгаварлан гадуурхахыг хориглоно.
- 5.3. Намын гишүүн төрийн жинхэнэ албан хаагчаар томилогдвол уг албыг хаах хугацаанд намын гишүүнээс түдгэлзэнэ.
- 5.4. Иргэнийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр, эсхүл намд албадан элсүүлэх, эсхүл ийм зорилгоор хууль бус нөлөөлөл, шахалт үзүүлэхийг хориглоно.
- 5.5. Хуульд зааснаас бусад тохиолдолд намын гишүүн байх нь түүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, давуу байдал олгох үндэслэл болохгүй.
- 5.6. Хуульд зааснаас бусад тохиолдолд иргэний хувийн байдлыг тодорхойлсон албаны баримт бичигт тухайн иргэний зөвшөөрөлгүйгээр аль нэг намын гишүүн болох талаар тодорхойлохыг хориглоно.
- 5.7. Намын гишүүн хэдий ч өөрийн хүсэл зориогийн үндсэн дээр намаас гарах эрхтэй. Намын гишүүн намаас гарах тухай өргөдөл гаргаснаар түүнийг намаас гарсанд тооцно.
- 5.8. Төр иргэдийн сайн дураараа эвлэлдэн нэгдэх, нам байгуулах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх үндсэн эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалах үүрэгтэй.
- 5.9. Үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, нийтийн ёс суртахуун, хүн амын эрүүл мэнд, эсхүл хүний бусад үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалахад зайлшгүй, тохирсон бөгөөд хуульд зааснаас өөр хязгаарлалтыг эвлэлдэн нэгдэх, нам байгуулах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болон холбогдох бусад үндсэн эрх, эрх чөлөөг эдлэхэд тавьж үл болно.
- 5.10. Энэ хуулийн 5.9-д зөвшөөрсөн хязгаарлалт нь хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол зэргээр нь ялгаварлан гадуурхаж үл болно.
- 5.11. Хуульд өөрөөр заагаагүй бол намын зүгээс төрийн байгууллага, албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцохыг хориглоно.
- 5.12. Төрийн байгууллага, албан тушаалтан хуульд зааснаас бусад тохиолдолд намын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцож үл болно.
- 5.13. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн нам үүсгэн байгуулах, гишүүнээр элсэхийг хориглоно.

6 дугаар зүйл. Улс төрийн намын нэр, бэлгэ тэмдэг

- 6.1. Нам нь оноосон нэртэй байх бөгөөд түүний төгсгөлд "нам" гэсэн ерөнхий нэрийг заавал хэрэглэнэ.
- 6.2. Нам сонгуулийн сурталчилгаа болон бусад үйл ажиллагаанд зөвхөн намын бүртгэлд бүртгүүлсэн бүтэн болон товчилсон нэрийг хэрэглэнэ.
- 6.3. Сонгуульд эвсэл байгуулан оролцож байгаа намууд сонгуулийн үйл ажиллагаанд эвслийн гэрээнд заасан нэрийг хэрэглэнэ.
- 6.4. Намын бүтэн болон товчилсон нэр, бэлгэ тэмдэг нь төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, сүм хийд, өөр хуулийн этгээд, бусад намын нэр, бэлгэ тэмдэгтэй давхардсан буюу бусдыг төөрөгдүүлэхээр ижил, төсөөтэй байж болохгүй.
- 6.5. Орон нутаг дахь салбар нэгж нь намынхаа нэрийн өмнө тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг заасан тодотголыг хэрэглэнэ.
- 6.6. Нам татан буугдсан, нэгдэх замаар өөрчлөн байгуулагдсан, нам нэрээ өөрчилсөн бол тэдгээрийн бүтэн болон товчилсон нэр, бэлгэ тэмдгийг шинээр байгуулагдах болон өөр бусад нам 12 жилийн турш дахин хэрэглэхийг хориглоно.
- 6.7. Намаас бусад хуулийн этгээд өөрийн оноосон нэрд "нам" гэсэн үг хэрэглэхийг хориглоно.
- 6.8. Улсын дээд шүүхийн Тамгын газар намын нэрийн санг хөтөлж, лавлагаа олгоно.

7 дугаар зүйл. Улс төрийн намын эрх, үүрэг

- 7.1. Нам дараах эрхийг эдэлнэ:
 - 7.1.1. үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тайван жагсаал, цуглааныг хуулийн хүрээнд санаачлан зохион байгуулах;
 - 7.1.2. намын болон гишүүнийхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;
 - 7.1.3. хуульд өөрөөр заагаагүй бол намын бүтэц, зохион байгуулалт, зорилт, арга хэлбэрээ чөлөөтэй сонгох;
 - 7.1.4. хуульд заасны дагуу орлогын эх үүсвэрийг бүрдүүлэх, өөрийн өмчтэй байх;
 - 7.1.5. Монгол Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох;
 - 7.1.6. бусад намтай эвсэл байгуулах;
 - 7.1.7. олон улсын байгууллага, бусад орны нам, байгууллагатай хамтран ажиллах, улс төрийн намуудын олон улсын байгууллагад гишүүнээр элсэх;
 - 7.1.8. хуулийн төслийн тухай саналаа хууль санаачлагчид уламжлах;
 - 7.1.9. хууль тогтоомжид заасан журмын дагуу намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг боловсруулж, сонгогчдод танилцуулах, сурталчлах;
 - 7.1.10. хуульд заасан бусад эрх.
- 7.2. Улсын Их Хурлын сонгуульд тухайн нам, эвслээс нэр дэвшиж сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн бүхий нам, эвслийг Улсын Их Хуралд суудал бүхий нам гэж ойлгоно.
- 7.3. Намыг дараах тохиолдолд Улсын Их Хуралд суудал бүхий намд тооцохгүй:
 - 7.3.1. Улсын Их Хуралд төлөөлөлгүй болсон;
 - 7.3.2. нам татан буугдсан.
- 7.4. Улсын Их Хуралд суудал бүхий нам дараах эрхтэй:
 - 7.4.1. Монгол Улсын Ерөнхийлөгчид нам дангаараа буюу хамтран нэр дэвшүүлэх;
 - 7.4.2. хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл болон бодлогын талаарх асуудлыг Улсын Их Хурал дахь намын бүлгээрээ, хэрэв намын бүлэггүй бол Улсын Их Хурлын гишүүнээрээ дамжуулан Улсын Их Хуралд оруулах;
 - 7.4.3. Улсын Их Хурал дахь намын бүлгээрээ дамжуулан улс төрийн албан тушаалд нэр дэвшүүлэх санал тавих;
 - 7.4.4. Улсын Их Хурал дахь намын бүлгээрээ дамжуулан Улсын Их Хурлын чуулганы нээлтийн ажиллагаанд улс орны бодлогын асуудлаар байр сууриа илэрхийлэх.
- 7.5. Нам нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг сахин биелүүлэх үүрэгтэй.

8 дугаар зүйл. Улс төрийн намын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагааг ардчилсан зарчимд нийцүүлэх

- 8.1. Нам гишүүдээ намын удирдах байгууллага, албан тушаал, сонгуульд нэр дэвших, сонгох, томилоход аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байж, тэгш боломж олгоно.
- 8.2. Энэ хуулийн 16.1-д заасан байгууллагыг бүрдүүлэхдээ дараах шаардлагыг хангана:

- 8.2.1.нууц санал хураалт явуулах;
- 8.2.2.гишүүдийн оролцоо, ил тод байдлыг хангах;
- 8.2.3.нэр дэвшүүлэхдээ аль нэг хүйсийн төлөөлөл 30 хувиас доошгүй байх.

8.3.Энэ хуулийн 16.1-д заасан байгууллагын болон намын бусад хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэх, цөөнхийн саналыг хэлэлцэх боломж олгож хүндэтгэн үзэх бөгөөд тодорхой асуудлыг дийлэнх олонхын саналаар шийдвэрлэхээр намын дүрэмд зааж болно.

8.4.Намын дүрэм, хөтөлбөрийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах болон сонгуульд нэр дэвшигчийг санал болгоход намын гишүүдийн оролцоог хангаж, саналыг сонсоно.

8.5.Нам бодлого, үйл ажиллагаандаа эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн сонирхлын бүлгүүдийн төлөөлөл, оролцоог хангаж ажиллана.

8.6.Нам бодлого, үйл ажиллагаандаа хувь хүн болон нийгмийн бүлгийг аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хориглоно.

8.7.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 8.4-т заасны дагуу намын үйл ажиллагаа дахь жендэрийн эрх тэгш байдлын талаарх тайланг Жендэрийн үндэсний хороонд хүргүүлнэ.

8.8.Жендэрийн үндэсний хороо энэ хуулийн 8.2.3, 17.7-д заасан шаардлагыг хангасан эсэх талаарх дүгнэлтийг жил бүрийн 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ.

8.9.Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 8.8-д заасан дүгнэлтийг үндэслэн зөрчлийг арилгах талаарх шаардлагыг тухайн намд хүргүүлэх бөгөөд хүргүүлсэн өдрөөс хойш зургаан сарын дотор уг зөрчлийг арилгаагүй бол тухайн зөрчлийг арилгах хүртэл төрийн санхүүжилтийг зогсооно.

9 дүгээр зүйл. Улс төрийн намын үйл ажиллагааг цахимаар явуулах, ил тод байдлыг хангах

9.1.Хуульд өөрөөр заагаагүй бол намын үйл ажиллагааг ил тод, нээлттэй явуулна.

9.2.Нам өөрийн дүрэм, хөтөлбөр, бусад журам, санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны товч тайланг ил тод, нээлттэй байлгаж, нийтэд тогтмол мэдээлэх, мэдээлэл авах боломжоор хангана.

9.3.Нам өөрийн бүх шатны байгууллагын хуралдаан, санал хураалт, сургалт, зөвлөгөөн, гишүүн элсүүлэх, гишүүний татвар хураах, хандив цуглуулах болон бусад ажиллагаа, нийгэмд болон гишүүдэд чиглэсэн арга хэмжээг аюулгүй байдлыг хангасан программ хангамж ашиглан намын дүрэмд заасны дагуу цахимаар явуулж болно.

9.4.Нам цахим хуралдаан, санал хураалтыг зохион байгуулахдаа цахим системийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангах боломжит арга хэмжээг авах бөгөөд нууц санал хураалтыг цахимаар явуулсан тохиолдолд түүний нууцлалыг алдагдуулахгүй.

9.5.Нам албан ёсоор нийтэд зарласан цахим хуудас, нийгмийн сүлжээний хаягтай бол тэдгээрийг Харилцаа холбооны зохицуулах хороо, сонгуулийн төв байгууллагад бүртгүүлнэ.

9.6.Нам цахим хуудсандаа дараах баримт бичиг, мэдээллийг ил тод, байршуулж, тухай бүр шинэчилнэ:

- 9.6.1.намын бүтэн болон товчилсон нэр, бэлгэ тэмдэг;
- 9.6.2.намын дүрэм;
- 9.6.3.намын хөтөлбөр;
- 9.6.4.намын сонгуулийн мөрийн хөтөлбөр;
- 9.6.5.намын гүйцэтгэх төв байгууллага оршин байгаа газрын хаяг;
- 9.6.6.намын даргын ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;
- 9.6.7.намын ерөнхий нарийн бичгийн дарга, санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтны ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;
- 9.6.8.намын удирдах дээд, төлөөллийн төв, гүйцэтгэх төв болон хяналтын байгууллагын дарга, гишүүний ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;
- 9.6.9.намын утасны дугаар, цахим шуудангийн хаяг;
- 9.6.10.намын гишүүний тоо;
- 9.6.11.намын болон харьяа байгууллагын санхүүгийн тайлан;
- 9.6.12.намын үйл ажиллагааны товч тайлан;
- 9.6.13.нам аймаг, сум, нийслэл, дүүрэгт салбар нэгжтэй бол тэдгээрийн нэгжийн даргын ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;
- 9.6.14.намын бүтэц, зохион байгуулалт;
- 9.6.15.намын үйл ажиллагааны мэдээлэл;
- 9.6.16.бусад мэдээлэл.

9.7.Намын дансанд хүлээж авсан хандивын болон бусад мэдээллийг холбогдох хуульд заасны дагуу цахим хуудсанд байршуулна. Хандивлагчийг мэдээлэхдээ энэ хуулийн 43.8-д заасныг баримтална.

9.8.Нам жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгэж, жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан цахим хуудсандаа байршуулж олон нийт, гишүүд, дэмжигчдээ нээлттэй танилцуулж байна.

9.9.Нам энэ хуулийн 9.6.1, 9.6.3, 9.6.4, 9.6.5, 9.6.7, 9.6.8, 9.6.9, 9.6.10, 9.6.11, 9.6.12-т заасан баримт бичиг, мэдээлэлд өөрчлөлт оруулснаас хойш 30 хоногийн дотор сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ.

9.10.Сонгуулийн төв байгууллага цахим хуудсандаа тухайн намын цахим хуудас, нийгмийн сүлжээний хаяг, энэ хуулийн 9.6.1, 9.6.2, 9.6.3, 9.6.4, 9.6.5, 9.6.6, 9.6.7, 9.6.8, 9.6.9, 9.6.10, 9.6.11, 9.6.12-т заасан намын баримт бичиг, мэдээллийг байршуулж, тухай бүр шинэчилнэ.

10 дугаар зүйл. Улс төрийн намын үйл ажиллагаанд хориглох зүйл

10.1.Нам дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

- 10.1.1.Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэлд ноцтой аюул учруулах;
- 10.1.2.Үндсэн хуулийн бус аргаар төрийн эрхийг авах аливаа үйл ажиллагаа явуулах;
- 10.1.3.зэвсэглэх, эсхүл цэрэгжих, цэрэгжсэн бүтэцтэй болох, зорилгоо хүчирхийллийн замаар гүйцэлдүүлэх үйл ажиллагаа явуулах;
- 10.1.4.хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол зэргээр нь ялгаварлан гадуурхах;
- 10.1.5.энэ хуулийн 34.6-д заасан хориглосон этгээдээс хандив, тусламж, санхүүжилт шууд болон шууд бусаар авах;
- 10.1.6.сонгуульд нэр дэвших эрх олгохдоо намын гишүүн, дэмжигчээсээ барьцаа, дэнчин болон бусад аливаа хэлбэрээр мөнгө болон мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээ өгөхийг шаардах, авах;

- 10.1.7.намаас бусад байгууллага, хуулийн этгээдийн бүтэц, үйл ажиллагааны хүрээнд намын салбар нэгж байгуулах;
- 10.1.8.хуульд заасан бусад.
- 10.2.Шашны, цэргийн болон цэрэгжсэн, фашист, түүнчлэн гадаад улсын намын салбар нэгжийг Монгол Улсын нутаг дэвсгэрт байгуулахыг хориглоно.
- 10.3.Энэ хуулийн 10.1.7-д заасан зөрчлийг арилгах шаардлагыг сонгуулийн төв байгууллага намд үндэслэл бүхий хугацаа зааж хүргүүлэх бөгөөд уг шаардлагыг заасан хугацаанд биелүүлээгүй тохиолдолд уг зөрчлийг арилгах хүртэл сонгуульд намын нэрээ дэвшүүлэн оролцох эрхийг түдгэлзүүлнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ УЛС ТӨРИЙН НАМ ҮҮСГЭН БАЙГУУЛАХ

11 дүгээр зүйл. Улс төрийн нам үүсгэн байгуулах

- 11.1.Намыг зохион байгуулах Их Хурал /цаашид "үүсгэн байгуулах хурал" гэх/-аар үүсгэн байгуулна.
- 11.2.Намыг үүсгэн байгуулах хурлын бэлтгэлийг урьдчилан хангах бөгөөд зохион байгуулах газар, хугацааг нэг сарын өмнө төлөөлөгчдөд мэдэгдсэн байна.
- 11.3.Намыг үүсгэн байгуулах хуралд орон нутгаас төлөөлөх төлөөлөгчдийг оролцуулан зохион байгуулна.
- 11.4.Намыг үүсгэн байгуулах хурлаас дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ:
 - 11.4.1.намын бүтэн болон товчилсон нэр, бэлгэ тэмдгийн загварыг батлах;
 - 11.4.2.намын хөтөлбөр, дүрмийг батлах;
 - 11.4.3.төлөөллийн төв, гүйцэтгэх төв болон хяналтын байгууллагын бүрэлдэхүүнийг сонгон байгуулах, түүний зохион байгуулалтын бүтэц, эрх, үүргийг тогтоох;
 - 11.4.4.намын даргыг сонгох;
 - 11.4.5.нам үүсгэн байгуулсан тухай шийдвэрийг батлах.
- 11.5.Намыг үүсгэн байгуулах хурлаас нам үүсгэн байгуулсан тухай шийдвэр гарсан өдрийг тухайн нам үүсэн байгуулагдсан өдөрт тооцох бөгөөд энэ тухай нийтэд зарлан мэдээлнэ.
- 11.6.Монгол Улсын иргэд нам үүсгэн байгуулахад аливаа байгууллага, албан тушаалтны зүгээс заналхийлэх, дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

12 дугаар зүйл. Улс төрийн намыг бүртгүүлэх өргөдөл

- 12.1.Энэ хуулийн 11.4.4-т заасан намын даргаар сонгогдсон гишүүн, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч нам үүсгэн байгуулагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор намыг бүртгүүлэх өргөдлийг энэ хуулийн 12.3-т заасан баримт бичгийн хамт Улсын дээд шүүхэд бичгээр хүргүүлнэ.
- 12.2.Намыг бүртгүүлэх өргөдлийг Улсын дээд шүүхийн баталсан маягтын дагуу гаргаж, дараах мэдээллийг тусгах бөгөөд өргөдөл гаргагч гарын үсэг зурна:
 - 12.2.1.өргөдөл гаргасан он, сар, өдөр;
 - 12.2.2.намын нэр;
 - 12.2.3.намын гүйцэтгэх төв байгууллагын хаяг;
 - 12.2.4.намын үүсгэн байгуулагчийн талаарх мэдээлэл;
 - 12.2.5.өргөдөл гаргагчийн талаарх мэдээлэл.
- 12.3.Намыг бүртгүүлэх өргөдөлд дараах баримт бичгийг хавсаргана:
 - 12.3.1.нам үүсгэн байгуулах тухай шийдвэр, уг шийдвэрт хуралдаан даргалагч, эсхүл тэргүүлэгчид гарын үсэг зурсан байна;
 - 12.3.2.намын бүтэн болон товчилсон нэрийн бичвэр, намын нэр, бэлгэдэл, далбааны зургийг тайлбарын хамт;
 - 12.3.3.намын дүрэм;
 - 12.3.4.намын хөтөлбөр;
 - 12.3.5.намын гүйцэтгэх төв байгууллага оршин байгаа газрын хаягийн мэдээлэл;
 - 12.3.6.намын 801-ээс доошгүй гишүүний бүртгэл /ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, гарын үсэг/;
 - 12.3.7.намын дарга, намын санхүүгийн асуудал хариуцсан ажилтны бүртгэл /ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, гарын үсэг, иргэний үнэмлэхийн хуулбар/;
 - 12.3.8.намын хөрөнгийн жагсаалт, намд өгсөн хандивын жагсаалт, намыг үүсгэн байгуулахтай холбогдон гарсан зардлын эх үүсвэр зэргийг тусгасан намын хөрөнгийн мэдээлэл;
 - 12.3.9.нам үүсгэн байгуулах хурлын тов, байршлыг энэ хуулийн 11.2-т заасны дагуу мэдэгдэж, зарласан тухай баримт;
 - 12.3.10.шаардлагатай тохиолдолд итгэмжлэл.
- 12.4.Энэ хуулийн 12.3.8-д заасан намын хөрөнгийн мэдээлэлд намыг бүртгүүлэх өргөдөл гаргахаас өмнө тухайн намын аль нэг үүсгэн байгуулагчийн нэр дээр банкны түр данс нээж намын хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, мөнгөн болон мөнгөн бус хөрөнгө, гишүүний татвар, хандив, намыг үүсгэн байгуулахтай холбогдсон зардлыг тусгаж тайлагнана.
- 12.5.Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ хуулийн 12.1-д заасан хугацааг хэтрүүлсэн тохиолдолд уг хугацаа дууссанаас хойш 30 хоногийн дотор намыг бүртгүүлэх өргөдлийг энэ хуулийн 12.3-т заасан баримт бичгийн хамт Улсын дээд шүүхэд хүргүүлж болно.
- 12.6.Энэ хуулийн 12.3.6, 12.3.7, 12.3.8-д заасан мэдээллийн маягтыг Улсын дээд шүүх батална.

13 дугаар зүйл. Улс төрийн намыг бүртгүүлэх өргөдөл, баримт бичгийг нягтлан шалгах

- 13.1.Улсын дээд шүүх намыг бүртгүүлэх өргөдлийг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор тухайн өргөдөл, хавсаргасан баримт бичгийг бүрэн гүйцэд эсэхийг нягтлан шалгана.
- 13.2.Улсын дээд шүүх намыг бүртгүүлэх өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичигт дараах зөрчил илэрсэн тохиолдолд 30 хоногийн дотор уг зөрчлийг арилгаж, нэмэлт мэдээллийг ирүүлэх тухай өргөдөл гаргагчид мэдэгдэнэ:
 - 13.2.1.энэ хуулийн 12.3-т заасан баримт бичгийн бүрдэл дутуу;
 - 13.2.2.намын дүрэм энэ хуулийн 15.2-т заасан хэлбэрийн шаардлагыг хангаагүй;
 - 13.2.3.намын гишүүдийн тоо энэ хуулийн 12.3.6-д заасан тоонд хүрээгүй, бүртгэлд орсон гишүүн нь өөр намын харьяалалтай, эсхүл өөр хүн төлөөлсөн;
 - 13.2.4.намын бүтэн болон товчилсон нэр, бэлгэдэл, далбаа энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй.

13.3.Улсын дээд шүүх намыг бүртгүүлэх өргөдөл, баримт бичгийг хүлээн авч, нягтлан шалгахдаа энэ хуулийн 12.3-т болон хуульд зааснаас бусад баримт бичиг шаардахыг хориглоно.

13.4.Намын бүртгэлийн жагсаалт, бүртгэлийн хувийн хэрэг, холбогдох мэдээллийг Улсын дээд шүүх эрхлэн хариуцна.

13.5.Улсын дээд шүүх намын нэр энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагад нийцсэн эсэхийг нягтлан шалгахдаа Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8.1.5 дахь заалт, энэ хуулийн 6.8-д заасан нэрийн санг ашиглана.

13.6.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 13.5-д заасан нэрийн санг ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.

13.7.Нам хуулийн этгээд болохын хувьд оршин байгаа газрын албан ёсны хаяг, хөрөнгө, түүний өөрчлөлттэй холбоотой бүртгэлийг холбогдох шийдвэр гарснаас хойш 60 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлнэ.

14 дүгээр зүйл. Улс төрийн намыг бүртгэх, бүртгэхээс татгалзах

14.1.Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар энэ хуулийн 13.1, 13.2-т заасан хугацаа дууссанаас хойш 30 хоногийн дотор хэлэлцэн тухайн намыг намын бүртгэлд бүртгэх, эсхүл бүртгэхээс татгалзах тухай шийдвэр гаргаж, Улсын дээд шүүхийн Тамгын газар ажлын гурван өдрийн дотор өргөдөл гаргагчид бичгээр болон цахимаар хүргүүлж, нийтэд мэдээлнэ.

14.2.Улсын дээд шүүх энэ хуулийн 14.4-т зааснаас бусад тохиолдолд намыг улс төрийн намын бүртгэлд бүртгэх тухай шийдвэр гаргана.

14.3.Намыг улс төрийн намын бүртгэлд бүртгэх шийдвэрийг нийтэд мэдээлснээс хойш ажлын таван өдрийн дотор Улсын дээд шүүхийн Тамгын газар гэрчилгээ, тамга тэмдгийн хяналтын дугаар олгоно. Улсын дээд шүүхийн Тамгын газар тухайн намын зорилго, үнэт зүйл, үзэл баримтлалын товч, гүйцэтгэх төв байгууллага, албан тушаалтны мэдээлэл, намын оршин байгаа газрын хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаягийн талаарх мэдээлэл багтаасан танилцуулгыг нийтэд ил тод байршуулна.

14.4.Улсын дээд шүүх намыг дараах үндэслэлээр намын бүртгэлд бүртгэхээс татгалзана:

14.4.1.намын дүрэм, хөтөлбөр нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд харшилсан;

14.4.2.энэ хуулийн 10.1.1, 10.1.2, 10.1.3-т заасан үндэслэл байгаа бол;

14.4.3.гишүүдийн тоо энэ хуулийн 12.3.6-д заасан тоонд хүрээгүй, бүртгэлд орсон гишүүн нь өөр намын харьяалалтай, эсхүл өөр хүн төлөөлсөн;

14.4.4.энэ хуулийн 6 дугаар зүйлийг зөрчин нэр хэрэглэсэн.

14.5.Улсын дээд шүүх тухайн намыг бүртгэхээс татгалзсан тухай шийдвэрийг энэ хуулийн 14.1-д заасан хугацаанд гаргах бөгөөд уг шийдвэрт татгалзсан үндэслэлээ тодорхой заана. Энэ шийдвэрийг зохих этгээдэд албан ёсоор мэдэгдэж, нийтэд мэдээлнэ.

14.6.Улсын дээд шүүх энэ хуулийн 14.1-д заасан шийдвэр гаргахаас өмнө өргөдөл гаргагч, сонгуулийн төв байгууллага, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон бусад этгээдээс тайлбар авах, нэмэлт баримт бичиг, лавлагаа, мэдээлэл гаргуулан авч болно.

14.7.Энэ хуулийн 12.2, 12.3, 12.4, 13.7, 15.3, 21.1, 21.4-т заасан болон бусад мэдээлэл, баримт бичиг, түүнд оруулсан өөрчлөлтийг холбогдох байгууллагад хүргүүлэх журмыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, сонгуулийн төв байгууллагын дарга хамтран батална.

14.8.Энэ хуулийн 14.1-д заасны дагуу гаргасан Улсын дээд шүүхийн шийдвэр эцсийн байна.

14.9.Улсын дээд шүүх энэ хуулийн 14.5-д заасан шийдвэр гаргасан тохиолдолд уг зөрчлийг арилгасан этгээд энэ хуульд заасны дагуу намыг бүртгүүлэх өргөдлийг энэ хуулийн 12, 13 дугаар зүйлд заасан журмыг үндэслэн дахин гаргах эрхтэй.

14.10.Улсын Их Хурлын сонгуулийн санал хураалт болохоос 90 хоногийн дотор намыг бүртгүүлэх өргөдлийг Улсын дээд шүүх хүлээн авахгүй бөгөөд энэ хуулийн 12.1, 13.1, 14.1-д заасан хугацаа түдгэлзэнэ.

14.11.Улсын дээд шүүх намыг бүртгэхтэй холбоотой журмыг сонгуулийн төв байгууллага, улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг харгалзан энэ хууль болон бусад хуульд нийцүүлэн батална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ УЛС ТӨРИЙН НАМЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

15 дугаар зүйл. Улс төрийн намын дүрэм

15.1.Намын бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог энэ хуульд заасны дагуу намын дүрмээр зохицуулна.

15.2.Намын дүрэмд дараах нийтлэг зүйлийг тусгана:

15.2.1.намын үзэл баримтлал, үнэт зүйл, зорилго;

15.2.2.намын бүтэн болон товчилсон нэр, бэлгэ тэмдэг;

15.2.3.намын гишүүнээр элсэх, намын гишүүнээс түдгэлзэх, намын гишүүний эрх, үүрэг, намын гишүүнээс хасах болон бусад сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл;

15.2.4.намын удирдах дээд байгууллага, төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх төв байгууллага, хяналтын байгууллага болон бусад байгууллага, тэдгээрийн бүрэлдэхүүн, бүрэн эрхийн хугацаа, эрх хэмжээ, хуралдуулах, шийдвэр гаргах журам;

15.2.5.намын даргыг сонгох, чөлөөлөх, огцруулах, түүний бүрэн эрхийн хугацаа, эрх хэмжээ;

15.2.6.намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах журам;

15.2.7.намыг өөрчлөн байгуулах, үйл ажиллагааг нь зогсоох арга, журам;

15.2.8.төрийн улс төрийн албан тушаалд болон намын удирдах албан тушаалд нэр дэвшигчийг сонгох, томилох, чөлөөлөх, тэдгээрт жендэрийн тэгш байдлыг хангах журам;

15.2.9.намын хөрөнгө, орлогыг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам;

15.2.10.намын салбар болон бүтцийн нэгжийг байгуулах, татан буулгах үндэслэл, журам.

15.3.Намын дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, намын даргыг томилсон шийдвэрийг 60 хоногийн дотор Улсын дээд шүүхэд албан ёсоор хүргүүлнэ.

15.4.Улсын дээд шүүхийн Тамгын газар энэ хуулийн 15.3-т заасан шийдвэртэй холбоотой мэдээллийг бүртгэж энэ тухай нийтэд мэдээлж, сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ.

15.5.Улсын дээд шүүх энэ хуулийн 15.3-т заасны дагуу гаргасан хүсэлтийг 30 хоногийн дотор шийдвэрлэх бөгөөд Улсын дээд шүүхийн шийдвэр эцсийн байна.

16 дугаар зүйл. Улс төрийн намын бүтэц, зохион байгуулалт

16.1.Нам нь намын удирдах дээд байгууллага, төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх төв байгууллага болон хяналтын байгууллагатай байна.

16.2.Намын бүтцийн нэгжийг намын дүрмээр зохицуулах бөгөөд энэ хуулийн 16.1-д зааснаас бусад байгууллагыг намын дүрмээр байгуулж

болно.

17 дугаар зүйл. Улс төрийн намын удирдах байгууллага

- 17.1. Намын гишүүдийн, эсхүл тэдгээрийн төлөөлөгчдийн хурал нь намын удирдах дээд байгууллага мөн бөгөөд түүнийг дөрвөн жилийн хугацаанд нэгээс доошгүй удаа хуралдуулна.
- 17.2. Намын удирдах дээд байгууллага дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ:
 - 17.2.1. намын дүрэм, хөтөлбөрийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах;
 - 17.2.2. намын төлөөллийн төв байгууллагын бүрэлдэхүүнийг дөрвөн жилээс илүүгүй хугацаагаар сонгох, эсхүл батламжлах, хяналтын байгууллагын бүрэлдэхүүнийг дөрвөн жилээс илүүгүй хугацаагаар сонгох, эдгээр байгууллагын тайланг дөрвөн жилийн хугацаанд нэгээс доошгүй удаа хэлэлцэх;
 - 17.2.3. намын нэрийг өөрчлөх, намыг өөрчлөн байгуулах, үйл ажиллагааг нь зогсоох;
 - 17.2.4. намын дүрэмд заасан бусад асуудал.
- 17.3. Нам нь намын удирдах дээд байгууллагын чөлөө цагт ажиллах намын төлөөллийн төв байгууллагатай байх бөгөөд түүнийг жил тутам нэгээс доошгүй удаа хуралдуулна.
- 17.4. Намын төлөөллийн төв байгууллагын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь санал гаргавал намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болно. Энэ нэмэлт, өөрчлөлт нь намын дүрмийн гуравны нэгээс хэтрэхгүй байна.
- 17.5. Намын дүрэмд заасны дагуу намын удирдах дээд байгууллага, эсхүл төлөөллийн төв байгууллага нь намын гүйцэтгэх төв байгууллагыг дөрвөн жилээс илүүгүй хугацаагаар сонгоно. Гүйцэтгэх төв байгууллага нь гурваас доошгүй тооны гишүүнтэй байна.
- 17.6. Намын дүрэмд заасны дагуу намын даргыг удирдах дээд байгууллага, эсхүл төлөөллийн төв байгууллага, санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтныг гүйцэтгэх төв байгууллага тус тус сонгоно.
- 17.7. Намын төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх төв байгууллага болон хяналтын байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байна.

18 дугаар зүйл. Улс төрийн намын хяналтын байгууллага

- 18.1. Нам нь намын дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих, намын дүрмээр зохицуулах дотоод маргааныг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий хяналтын байгууллагатай байна.
- 18.2. Намын хяналтын байгууллагын гишүүнээр намын төлөөллийн байгууллага болон гүйцэтгэх төв байгууллагын гишүүн, орон тооны ажилтныг сонгохыг хориглоно.
- 18.3. Намын хяналтын байгууллага хараат бусаар ажиллах бөгөөд түүний үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.
- 18.4. Намын хяналтын байгууллага дараах маргааныг хянан шийдвэрлэж, шийдвэртээ үндэслэлээ тодорхой бичнэ:
 - 18.4.1. намын дүрэм зөрчсөн эсэх;
 - 18.4.2. нам болон түүний гишүүн хооронд үүссэн;
 - 18.4.3. намын дотоод сонгуультай холбогдон үүссэн;
 - 18.4.4. намын санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой.
- 18.5. Энэ хуулийн 18.4-т заасан маргааныг хянан шийдвэрлэх журмыг намын дүрэмд заасны дагуу батална. Энэ журам нь маргагч талаас тайлбар, нотлох баримт гаргаж өгөх, маргааныг шийдвэрлэх хуралдаанд биечлэн оролцох зэргээр шударгаар хянан шийдвэрлүүлэх эрхийн баталгааг хангасан байна.

19 дүгээр зүйл. Улс төрийн намын бусад байгууллага

- 19.1. Намын бодлого боловсруулахад зөвлөх, судалгаа хийх, намын гишүүдийг сургаж бэлтгэх, иргэдийн улс төрийн боловсролыг дэмжих үүрэг бүхий бодлогын судалгааны байгууллага намын дэргэд ажиллана.
- 19.2. Намын бодлогын судалгааны байгууллага сангийн хэлбэртэй байж болох бөгөөд үйл ажиллагаа, санхүүгийн тайланг энэ хуульд заасан журмын дагуу тайлагнах үүрэгтэй.
- 19.3. Энэ хуульд заасан намын бүтэц, зохион байгуулалтаас гадна нийгэм, эдийн засгийн болон бусад салбарын бодлогын асуудлаар зөвлөлдөх, намын бодлого, үйл ажиллагаа нь хүний эрх болон жендэрийн эрх тэгш байдалд нийцэж байгаа эсэхийг үнэлэх зэрэг чиг үүрэгтэй бүтцийн нэгж байгуулах эсэхийг нам дүрмээрээ зохицуулж болно.
- 19.4. Нам Монгол Улсын Их Хурлын сонгуульд намаас нэр дэвшигчийг сонгох ажлыг зохион байгуулах хороотой байж болно. Хорооны бүрэлдэхүүнд тавих шаардлага, түүнийг байгуулах, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах болон үйл ажиллагааны журмыг энэ хуулийн 8 дугаар зүйл, намын дүрэмд нийцүүлнэ.
- 19.5. Монгол Улсын Их Хурлын сонгуульд намаас нэр дэвшигчийг сонгохдоо энэ хуулийн 8.2.1, 8.2.2, 8.3-т заасныг баримталж, тухайн албан тушаалыг хаших ёс зүйн болон хууль тогтоомж, холбогдох журмаар тогтоосон бусад шаардлагад үндэслэнэ.
- 19.6. Энэ хуулийн 19.4, 19.5-д заасан журмыг намын төлөөллийн төв байгууллага батална.

20 дугаар зүйл. Улс төрийн намын гишүүний эрх, үүрэг, баталгаа

- 20.1. Намын гишүүн дараах эрхтэй байна:
 - 20.1.1. намын үйл ажиллагаанд тэгш эрхтэй оролцох;
 - 20.1.2. намын бүтцийн байгууллагад сонгох, сонгогдох;
 - 20.1.3. намын дүрэмд заасан бусад эрх.
- 20.2. Намын гишүүн дараах үүрэгтэй байна:
 - 20.2.1. намын дүрэмд заасан татвар төлөх;
 - 20.2.2. хууль тогтоомж, намын дүрэмд захирагдах;
 - 20.2.3. намын дүрэмд заасан бусад үүрэг.
- 20.3. Намын гишүүнээс хасах асуудлыг тогтоосон журмын дагуу намын хяналтын байгууллага шийдвэрлэнэ.
- 20.4. Намын дүрмийг санаатай зөрчсөн, эсхүл намын үнэт зүйл, зарчмыг ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд намын гишүүнээс хасахыг хориглоно.
- 20.5. Нам намын гишүүний бүртгэлийг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нийцүүлэн хөтөлж, жил бүр шинэчилнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

УЛС ТӨРИЙН НАМЫГ ИДЭВХГҮЙД ТООЦОХ, ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ

21 дүгээр зүйл. Улс төрийн намыг идэвхгүйд тооцох

21.1.Улсын дээд шүүх сонгуулийн төв байгууллагаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн дараах тохиолдолд намыг идэвхгүйд тооцох тухай шийдвэрийг гаргана:

21.1.1.Улсын Их Хурлын ээлжит сонгуульд хоёр удаа дараалан нэр дэвшүүлэн оролцоогүй;

21.1.2.энэ хуулийн 37.2-т заасан үүргээ зөрчин хоёр жил дараалан санхүүгийн тайлангаа сонгуулийн төв байгууллагад хүргүүлээгүй;

21.1.3.намын удирдах дээд байгууллагыг, эсхүл төлөөллийн төв байгууллагыг таван жилийн хугацаанд хуралдуулаагүй.

21.2.Намыг идэвхгүйд тооцсон бол тухайн намд олгох төрийн санхүүжилтийг зогсоох бөгөөд зөрчлийг арилгах хүртэл нам бүх шатны сонгуульд оролцох эрхгүй болно. Энэ хугацаанд намын гишүүнийг аливаа сонгуульд бие даан нэр дэвших эрхийг үл хязгаарлана.

21.3.Энэ хуулийн 21.1.1-д заасан зөрчил гаргасан намын эрх бүхий байгууллага сонгуульд оролцох шийдвэр гаргаж, сонгуулийн төв байгууллагад бүртгүүлсэн, эсхүл энэ хуулийн 21.1.2, 21.1.3-т заасан зөрчлөө арилгасан талаар холбогдох нотлох баримтыг сонгуулийн төв байгууллагад албан ёсоор хүргүүлнэ.

21.4.Энэ хуулийн 21.3-т заасан нотлох баримтыг сонгуулийн төв байгууллага хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор Улсын дээд шүүхэд хүргүүлэх бөгөөд Улсын дээд шүүх хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянан үзэж, намыг идэвхтэйд тооцох эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

21.5.Сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш санал хураалт явагдаж дуусах хүртэл намыг идэвхтэй, эсхүл идэвхгүйд тооцох шийдвэрийг Улсын дээд шүүх гаргахгүй.

21.6.Энэ зүйлд заасны дагуу гаргасан Улсын дээд шүүхийн шийдвэр эцсийн байна.

22 дугаар зүйл. Улс төрийн намыг татан буулгах

22.1.Намын удирдах дээд байгууллагын шийдвэрээр намыг өөрчлөн байгуулах, түүний үйл ажиллагааг зогсоох, эсхүл Улсын дээд шүүхийн шийдвэрээр намыг тараах замаар энэ хуульд заасны дагуу намыг татан буулгана.

22.2.Улсын дээд шүүх энэ хуулийн 23.1, 24.1-д заасан шийдвэрийг хүлээн авснаас хойш, эсхүл 25.3-т заасан шийдвэрийг гаргаснаас хойш ажлын таван өдрийн дотор тухайн намыг бүртгэлээс хасаж гэрчилгээ, тамга тэмдгийн хяналтын дугаарыг хүчингүй болгоно.

22.3.Улсын дээд шүүхийн Тамгын газар энэ хуульд заасны дагуу намыг татан буулгасан тухай шийдвэр, шаардлагатай бусад мэдээллийг сонгуулийн төв байгууллага болон бусад этгээдэд хүргүүлж, нийтэд мэдээлнэ.

22.4.Татан буугдсан намын хөрөнгийг гишүүдэд хуваарилахыг хориглоно.

22.5.Энэ хуулийн 23.6-д заасныг зөрчиж өөрчлөн байгуулагдсан намын өмч, хөрөнгийг эзэмшил, өмчлөлдөө байлгасан, эсхүл 22.4-т заасныг зөрчин гишүүддээ хуваарилсан тохиолдолд хуульд өөрөөр заагаагүй бол сонгуулийн төв байгууллага уг хөрөнгийг хураан авч, улсын орлого болгоно.

22.6.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол татан буулгах комисс томилох зэрэг намыг татан буулгахтай холбогдсон бусад харилцааг Иргэний хуулиар зохицуулна.

23 дугаар зүйл. Улс төрийн намыг өөрчлөн байгуулах

23.1.Нам энэ хуульд заасны дагуу нийлэх, нэгдэх замаар өөрчлөн байгуулагдаж болох бөгөөд энэ тухай шийдвэрийг намын удирдах дээд байгууллага гаргаснаас хойш ажлын 10 өдрийн дотор Улсын дээд шүүхэд хүргүүлнэ.

23.2.Нийлсэн намуудын эрх, үүрэг, хариуцлага, эд хөрөнгө нь нийлэх замаар өөрчлөн байгуулагдсан намд шилжих бөгөөд уг нам энэ хуульд заасны дагуу шинээр бүртгүүлнэ.

23.3.Нийлэх замаар өөрчлөн байгуулагдаж байгаа намууд нь аль нэг намынхаа нэрийг шинээр байгуулсан намын нэр болгон хэрэглэж болно.

23.4.Нийлэх замаар өөрчлөн байгуулагдсан намуудаас хамгийн эхэнд байгуулагдсан намын өдрөөр төлөөлүүлэн уг намын үүсгэн байгуулагдсан өдрийг тодорхойлно.

23.5.Нам үйл ажиллагаагаа зогсоож өөр намтай нэгдсэн бол тэр намын эрх, үүрэг, хариуцлага, намын гишүүдийн харьяалал, эд хөрөнгө нэгтгэн авсан намд шилжинэ.

23.6.Нам энэ хуульд заасны дагуу өөрчлөн байгуулагдсан тохиолдолд түүний өмч, хөрөнгийг дээрх шийдвэртэй санал нийлээгүй тус намын гишүүн болон бусад иргэн, хуулийн этгээд аливаа хэлбэрээр өмчлөх, үргэлжлүүлэн хэрэглэхийг хориглоно.

23.7.Намыг өөрчлөн байгуулахтай холбогдсон бусад харилцааг Иргэний хуулийн холбогдох заалтаар зохицуулна.

24 дүгээр зүйл. Улс төрийн намын үйл ажиллагааг зогсоох

24.1.Намын үйл ажиллагааг зогсоох тухай шийдвэрийг намын удирдах дээд байгууллага гаргаснаас хойш ажлын 10 өдрийн дотор Улсын дээд шүүхэд хүргүүлнэ.

24.2.Энэ хуулийн 22.2-т заасны дагуу шийдвэр гарсан бол татан буулгах комисс намын өр төлбөрийг барагдуулж дууссаны дараа үлдсэн хөрөнгийг сонгуулийн төв байгууллагад шилжүүлнэ.

24.3.Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 24.2-т заасны дагуу шилжүүлсэн хөрөнгийг иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэхэд зарцуулна.

25 дугаар зүйл. Улс төрийн намыг тараах

25.1.Энэ хуулийн 10.1.1, 10.1.2, 10.1.3-т заасан хориглолтыг зөрчсөн байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн бол сонгуулийн төв байгууллага намыг тараах тухай үндэслэл бүхий санал гаргаж, холбогдох нотлох баримт, хуралдааны тэмдэглэлийн хамт Улсын дээд шүүхэд хүргүүлнэ.

25.2.Энэ хуулийн 25.1-д заасан саналыг сонгуулийн төв байгууллага нийт гишүүнийхээ дөрөвний гурвын саналаар гаргана.

25.3.Намыг тараах тухай сонгуулийн төв байгууллагын саналыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар хянан хэлэлцэх бөгөөд энэ хуулийн 25.1-д заасан үндэслэл тогтоогдвол намыг тараах тухай шийдвэр гаргаж, Улсын дээд шүүхийн Тамгын газар ажлын 10 өдрийн дотор сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ.

25.4.Энэ хуулийн 25.3-т заасны дагуу гаргасан Улсын дээд шүүхийн шийдвэр эцсийн байна.

ТАВДУГААР БҮЛЭГ УЛС ТӨРИЙН НАМЫН САНХҮҮЖИЛТ

26 дугаар зүйл. Улс төрийн намын орлогын эх үүсвэр

26.1.Намын орлого дараах эх үүсвэртэй байна:

26.1.1.төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг;

26.1.2.гишүүний татвар;

26.1.3.хандив;

- 26.1.4.намын өөрийн хөрөнгө, түүнээс олсон орлого;
26.1.5.энэ хуулиар зөвшөөрсөн бусад орлого.
- 26.2.Монгол Улсын Үндсэн хуулийн Арван ес дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу төрөөс намд үзүүлэх санхүүгийн дэмжлэг нь энэ хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу олгох төрийн санхүүжилт болон энэ хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэгээс бүрдэнэ.
- 26.3.Намд олгох жил бүрийн төрийн санхүүжилтийн дараах хувийг доор дурдсан зориулалтаар зарцуулна:
26.3.1.төрийн санхүүжилтийн 20-оос доошгүй хувийг эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлгүүдийн улс төрийн оролцоог дэмжих, сургаж бэлтгэх;
26.3.2.төрийн санхүүжилтийн 15-аас доошгүй хувийг намын гишүүдийн болон иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, ардчилал, хүний эрхийн үнэт зүйлийг нийтэд таниулах;
26.3.3.төрийн санхүүжилтийн 15-аас доошгүй хувийг намын хөтөлбөр, бодлого боловсруулахад чиглэсэн судалгаа хийх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, намын дотоод ардчиллыг хөгжүүлэх.
- 26.4.Энэ хуулийн 26.3.1, 26.3.2, 26.3.3-т заасан зорилтот санхүүжилт тус бүрийн гуравны нэгээс доошгүйг намын бодлогын судалгааны байгууллагын үйл ажиллагаанд зарцуулна.
- 26.5.Энэ хуулийн 26.3-т заасан санхүүжилтийг тухайн зорилгоос өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.
- 26.6.Төрийн санхүүжилтийн холбогдох хувийг энэ хуулийн 26.3-т заасныг зөрчин зарцуулсан бол сонгуулийн төв байгууллага хууль бусаар зарцуулсан хөрөнгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэх, эсхүл дараагийн төрийн санхүүжилтээс хасаж тооцно.
- 26.7.Нам энэ хуулийн 26.1-д заасан орлогыг зөвхөн нэг банкны дансаар хүлээн авах бөгөөд өөр харилцах данстай байхыг хориглоно.
- 26.8.Нам энэ хуулийн 26.1-д заасан орлогыг цахим мөнгөөр хүлээн авахыг хориглоно.

27 дугаар зүйл.Төрийн санхүүжилт

- 27.1.Улсын Их Хурлын ээлжит, эсхүл ээлжит бус сонгуулиар сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн нийт сонгогч /цаашид "нийт сонгогч" гэх/-ийн тоог нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 0.7 хувиар үржүүлснээс илүүгүй төгрөгийг улсын төсвөөс намуудад энэ хуульд заасны дагуу хуваарилах замаар төрийн санхүүжилт олгоно.
- 27.2.Төрийн санхүүжилтийн хэмжээ энэ хуулийн 27.1, 27.8-д зааснаас хэтрэхгүй байна.
- 27.3.Нийт сонгогчийн нэг ба түүнээс дээш хувийн санал авсан намд төрийн санхүүжилт олгоно.
- 27.4.Энэ хуулийн 27.3-т заасан шаардлагыг хангаагүй намд төрийн санхүүжилт олгохыг хориглоно.
- 27.5.Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 27.3-т заасан шаардлагыг хангасан намд дараах томъёогоор төрийн санхүүжилтийг жил бүр олгоно:

$$H = /C1 \times T1/ + /C2 \times T2/$$

- 27.6.Энэ хуулийн 27.5-д заасан томъёо дахь дараах тэмдэглэгээг доор дурдсан утгаар ойлгоно:
27.6.1."H" гэж нийт сонгогчийн нэг ба түүнээс дээш хувийн дэмжлэг авсан намд хуваарилах нийт санхүүжилтийг;
27.6.2."C1" гэж Улсын Их Хурлын сонгуулиар тухайн намын авсан саналын тоог;
27.6.3."C2" гэж Улсын Их Хуралд тухайн намын авсан суудлын тоог;
27.6.4."T1" гэж нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 0.5 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгийг;
27.6.5."T2" гэж нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 25 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгийг.
- 27.7.Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 27.3-т заасан шаардлагыг хангасан намд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хууль тогтоомжид заасан нэр дэвшигчийн хүйсийн квотоос илүү нэр дэвшүүлсэн эмэгтэй улс төрчийн тоог болон хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчийн тоог энэ хуулийн 27.6.5-д заасан дүнгээр үржүүлсэнтэй тэнцэх төрийн санхүүжилтийг тухайн ээлжит сонгуулийн дараагийн жил зөвхөн нэг удаа олгоно.
- 27.8.Улсын төсвөөс нэг намд олгох санхүүжилтийн нийт хэмжээ нь тухайн намын энэ хуулийн 36.3.1, 36.3.2, 36.3.3, 36.3.4-т заасан орлогын нийлбэрээс хоёр дахин их, эсхүл түүнээс илүү байж болохгүй.
- 27.9.Хоёр буюу түүнээс дээш хэд хэдэн нам эвсэл болж сонгуульд оролцсон тохиолдолд энэ хуулийн 27.5-д заасан төрийн санхүүжилтийг эвсэлд олгоно. Эвсэлд олгосон санхүүжилтийг энэ хууль болон эвслийн гэрээгээр хуваарилна.
- 27.10.Эвслийн гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 27.5-д заасан төрийн санхүүжилтийн /C1 x T1/ хэсгийг эвсэлд нэгдсэн намуудад тэнцүү хувааж, төрийн санхүүжилтийн /C2 x T2/ хэсгийг тухайн суудалд сонгогдсон гишүүнийг нэр дэвшүүлсэн намд олгоно.
- 27.11.Намыг идэвхгүйд тооцсон, татан буулгасан, эсхүл эвсэл тарсан бол энэ тухай шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс тухайн нам, эвсэлд олгох төрийн санхүүжилтийг сонгуулийн төв байгууллага зогсооно.
- 27.12.Намд олгох төрийн санхүүжилтийг жил бүр сонгуулийн төв байгууллагын төсвийн багцад суулгаж, батлуулна.
- 27.13.Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг сонгуулийн төв байгууллагын шийдвэрийн дагуу намын төв байгууллагад олгох бөгөөд салбар болон бүтцийн нэгжид хуваарилах асуудлыг намын дүрмээр зохицуулна.

28 дугаар зүйл.Төрийн санхүүжилт авах тухай хүсэлт гаргах

- 28.1.Төрийн санхүүжилтийн эрх үүсэх жилд төрийн санхүүжилт авах зорилгоор уг санхүүжилтийн хэмжээг тогтоолгох, санхүүжилт авах тухай хүсэлтээ нам тухайн жилийн өмнөх жилийн 08 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө сонгуулийн төв байгууллагад гаргана. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ хугацаанд хүсэлт гаргаагүй бол сонгуулийн төв байгууллага энэ тухай сануулж, долоо хоногийн дотор хүсэлт гаргах боломж олгоно.
- 28.2.Намын санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтан энэ хуулийн 28.1-д заасан хүсэлтийг сонгуулийн төв байгууллагаас баталсан маягтын дагуу гаргана. Энэ маягтад намын шуудангийн хаяг, намын дансны дугаар зэрэг мэдээллийг бичихээр тусгана.
- 28.3.Намын төв байгууллага нь нийт намыг төлөөлж нэгдсэн хүсэлт гаргана.
- 28.4.Төрийн санхүүжилтийн эрх үүсэх жилийн өмнөх онд сонгуулийн төв байгууллага төрийн санхүүжилтийн хэмжээг тогтоосон шийдвэр гаргасан бол төрийн санхүүжилтийн эрх үүсэх жилд нам шинээр хүсэлт гаргах шаардлагагүй. Төрийн санхүүжилтийн хэмжээнд нөлөөлөх өөрчлөлт гарсан бол сонгуулийн төв байгууллагад даруй мэдэгдэх бөгөөд энэ талаар цаг тухайд нь мэдэгдээгүйн үр дагаврыг нам хариуцна.
- 28.5.Нам энэ хуулийн 27.5-д заасны дагуу үүссэн эрхээсээ татгалзах эрхтэй бөгөөд ийнхүү татгалзсан тохиолдолд тухайн намд олговол зохих төрийн санхүүжилт улсын төсөвт үлдэнэ.

29 дүгээр зүйл.Төрийн санхүүжилтийн хэмжээг тогтоох

- 29.1.Сонгуулийн төв байгууллага жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрөөс өмнө төрийн санхүүжилт авах эрх бүхий нам бүрд төрийн

санхүүжилтийн эрх үүсэх жилийн санхүүжилтийн хэмжээг энэ хуульд заасны дагуу тогтоож, нийтэд мэдээлнэ.

29.2.Энэ хуулийн 29.1-д заасан шийдвэрийн дагуу олгох санхүүжилтийг дараа жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн энэ хуульд өөрөөр заагаагүй бол ээлжит болон ээлжит бус сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан тухайн Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болох хүртэл хугацаанд жил бүр олгоно.

29.3.Сонгуулийн төв байгууллага нь намаас энэ хуулийн Зургадугаар бүлэгт заасан шаардлагыг хангаж ирүүлсэн санхүүгийн тайланг үндэслэн энэ хуулийн 27 дугаар зүйлд заасныг баримтлан төрийн санхүүжилтийн хэмжээг тогтоож олгоно.

29.4.Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу намын санхүүгийн тайланг хянасны дараа санхүүжилтийн хэмжээг эцэслэн тогтооно.

29.5.Төрийн санхүүжилтийн хэмжээг тогтоох үндэс нь төрийн санхүүжилтийн эрх үүсэх жилээс өмнө хамгийн сүүлд явагдсан Улсын Их Хурлын сонгуулиар авсан хүчинтэй саналын тоо болон энэ хуулийн 27.5-д заасан бусад үзүүлэлт байна.

29.6.Энэ хуулийн 37.2-т заасан хугацаанд хагас жилийн санхүүгийн тайланг ирүүлээгүй бол энэ хуулийн 27.5-д заасан санхүүжилтийн /C1 x T1/ хэсгийг тухайн намд дараагийн жилд олгохгүй.

29.7.Санхүүгийн тайлангаа энэ хуулийн 36 дугаар зүйлд заасан бүтэц, хэлбэрээр 38.10-т заасан аудитын дүгнэлтийн хамт тогтоосон хугацаанд ирүүлбэл хугацаа баримталсанд тооцно.

29.8.Бусад намд олгох төрийн санхүүжилтийн хэмжээ, олголт нь тухайн нэг намын үйлдлээс шалтгаалан өөрчлөгдөхгүй.

29.9.Энэ хуулийн 27.8-д заасан хязгаарыг тооцоолоход тайлант жилд авч, санхүүгийн тайланд тусгасан намын орлогын хэмжээг энэ хуулийн 36.3.1, 36.3.2, 36.3.3, 36.3.4-т үндэслэнэ.

29.10.Төрийн санхүүжилтийн хэмжээг тогтоохдоо эхлээд нам бүрээр энэ хуулийн 27.8-д заасан хязгаарыг, дараа нь энэ хуулийн 27.1-д заасан хязгаарыг баримтална. Төрийн санхүүжилт энэ хуулийн 27.1-д заасан хязгаараас хэтрэх тооцоо гарсан бол уг хязгаартай тэнцүү санхүүжилтийг намуудад ногдох хувь хэмжээгээр нь олгоно.

29.11.Төрийн санхүүжилтийг хуваарилахад харгалзан үзэх тухайн намд өгсөн хүчинтэй саналын тоо нь түүнд нөхөн болон дахин сонгуулийн дүн, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу өөрчлөлт орсноос бусад тохиолдолд тухайн Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд өөрчлөгдөхгүй.

30 дугаар зүйл. Төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэг

30.1.Нийт сонгогчийн нэг ба түүнээс дээш хувийн санал авсан нам нь сонгуулийн бус жилд төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэгийг дараах хэлбэрээр авах эрхтэй:

30.1.1.намын удирдах дээд байгууллагыг хуралдуулах, гишүүд, дэмжигчидтэй хийх уулзалт, хурал зохион байгуулах, иргэдийг мэдээллээр хангах, соён гэгээрүүлэх зорилгоор төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн уулзалтын танхим, хурлын заал, бусад танхимыг жилд нэг удаа үнэ төлбөргүй ашиглах;

30.1.2.намын хөтөлбөр, үйл ажиллагааны талаарх нэвтрүүлгийг олон нийтийн радио, телевизээс гаргасан хуваарийн дагуу 30 минутаар улирал тутам үнэ төлбөргүй нэвтрүүлэх.

30.2.Энэ хуулийн 30.1-д заасан шууд бус дэмжлэг авах тухай намын хүсэлтийг 30 хоногийн дотор сонгуулийн төв байгууллага шийдвэрлэнэ.

30.3.Энэ хуулийн 30.1.1-д заасан байгууллага уулзалтын танхим, хурлын заал, бусад танхимаа үнэ төлбөргүй ашиглуулах, энэ хуулийн 30.1.2-т заасны дагуу олон нийтийн радио, телевиз үнэ төлбөргүй нэвтрүүлэх үүрэгтэй.

30.4.Энэ хуулийн 30.1.2-т заасан нэвтрүүлгийн эхлэл, төгсгөлд төрөөс үзүүлсэн шууд бус дэмжлэгийг дурдана.

30.5.Сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс санал хураалтын дүн гарах хүртэл хугацаанд энэ хуулийн 30.1-д заасан шууд бус дэмжлэгийг намд үзүүлэхгүй.

31 дүгээр зүйл. Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгт тавих хяналт

31.1.Сонгуулийн төв байгууллага төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг, түүний зарцуулалтын тайланг хянаж, хүлээн авч нэгтгэн тайлагнана.

31.2.Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу намын санхүүгийн тайланд аудитын хуулийн этгээдээр хараат бусаар дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулж, хяналт тавина.

31.3.Төрийн аудитын байгууллага нь сонгуулийн төв байгууллагын төсвийн багцад туссан намд олгох төрийн санхүүжилт, түүний зарцуулалт, тайлагналд Төсвийн тухай хуульд заасан цаглаврын дагуу аудит хийж, дүгнэлт гаргана.

31.4.Намд төрийн санхүүжилт олгох, төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэгийг шийдвэрлэх, намын санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны товч тайланг хянах, дүгнэлт гаргах, тайлагнах, нийтэд мэдээлэх, намын баримт бичиг, мэдээллийг цахим хуудсанд байршуулах, шинэчлэх, хариуцлага тооцохтой холбоотой журмыг энэ хуульд нийцүүлэн төрийн аудитын байгууллагын саналыг харгалзан сонгуулийн төв байгууллага батална.

32 дугаар зүйл. Гишүүний татвар

32.1.Гишүүний татварын хэмжээ, бүрдүүлэлтийг тухайн намын дүрмээр тогтооно.

32.2.Гишүүний сарын татварын хэмжээ нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 5 хувиас хэтрэхгүй байна.

32.3.Сонгуульт гишүүний сарын татварын хэмжээ нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хэтрэхгүй байна.

32.4.Гишүүний татварыг тухайн намын гишүүн зөвхөн өөрийн орлогоос төлнө.

32.5.Намын гишүүн нь бусад гишүүний өмнөөс гишүүний татвар төлөхийг хориглоно.

32.6.Нам өөрийн дүрэм, журмаар намын гишүүний татварыг хөнгөлөх, чөлөөлөхөөр зохицуулж болно.

32.7.Хуульд өөрөөр заагаагүй бол намын гүйцэтгэх төв байгууллага нь гишүүний татвар төлсөн баримтыг 10 жилийн хугацаанд архивлан хадгална.

32.8.Намын гишүүнээс энэ хуулийн 32.2, 32.3-т заасны дагуу төлөх татвар, намд өгөх бусад аливаа мөнгийг хандив гэж үзэх бөгөөд тэдгээрийн нийлбэр нь энэ хуулийн 33.6-д заасан хэмжээнээс илүүгүй байна. Бүх төрлийн гэнэтийн зардлыг гишүүдэд ногдуулан хуваарилах, мөнгө цуглуулах, мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх эд хөрөнгө намд өгөхийг хандивт тооцно.

33 дугаар зүйл. Хандив

33.1.Хандив нь мөнгөн болон мөнгөн бус хэлбэртэй байна.

33.2.Иргэний болон хуулийн этгээдийн мөнгөн хандивыг зөвхөн данснаас дансанд шилжүүлэх хэлбэрээр намын дансанд хүлээн авах бөгөөд бэлэн мөнгөөр хандив авахыг хориглоно. Гишүүний татвар болон хандивыг нэг харилцах дансанд байршуулна.

33.3.Дараах зүйл нь үнэ төлбөргүйгээр, эсхүл зах зээлийн дундаж ханшаас доогуур үнээр хийгдэж байгаа тохиолдолд мөнгөн бус хандивт хамаарна:

- 33.3.1.хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус баялгийг ашиглуулах, эзэмшүүлэх;
- 33.3.2.үйлчилгээ үзүүлэх;
- 33.3.3.төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх;
- 33.3.4.арга хэмжээний зардлыг төлөх;
- 33.3.5.ивээн тэтгэх.

33.4.Хандивыг мөнгөн бус хэлбэрээр авах тохиолдолд түүнийг зах зээлийн дундаж ханшийг үндэслэн мөнгөн дүнгээр илэрхийлэн санхүүгийн тайланд тусгана.

33.5.Монгол Улсын иргэн, хуулийн этгээдээс нэг жилийн хугацаанд нэг намд өгөх хандив энэ хуулийн 33.6, 33.7-д заасан хэмжээнээс илүүгүй байна. Намд өгсөн хандивын хэмжээг уг нам, түүний салбар болон бүтцийн нэгжид өгсөн хандивын нийлбэр дүнгээр тооцно.

33.6.Нэг жилд нэг иргэнээс авах хандивын дээд хэмжээ нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэн үнийн дүнгээс илүү байхыг хориглоно.

33.7.Нэг жилд нэг хуулийн этгээдээс авах хандивын дээд хэмжээ нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50 дахин нэмэгдүүлсэн үнийн дүнгээс илүү байхыг хориглоно.

33.8.Хуулийн этгээдийн намд өгсөн хандивын хэмжээг уг хуулийн этгээд, хуулийн этгээдийн хараат болон охин компани, салбар, төлөөлөгчийн газрын өгсөн хандивын нийлбэр дүнгээр тооцно. Намд өгсөн хандивын хэмжээг мөнгөн болон мөнгөн бус хандивын нийлбэр дүнгээр тооцно.

33.9.Хандивлагч намын салбар болон бүтцийн нэгжид нэр зааж өгсөн хандивыг тухайн зориулалтын дагуу захиран зарцуулна.

33.10.Намын харьяа байгууллага нь энэ хуулийн 34.6-д хориглосон этгээдээс хандив авахыг хориглоно.

33.11.Нэг хуулийн этгээд, эсхүл иргэнээс намд болон тухайн намын харьяа байгууллагад өгөх нийт хандив энэ хуулийн 33.6, 33.7-д зааснаас илүүгүй байна.

33.12.Намын харьяа байгууллага санхүүгийн тайлангаа энэ хуулийн Зургадугаар бүлэгт заасан шаардлагын дагуу гаргаж тухайн намд болон сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ.

34 дүгээр зүйл.Хандивтай холбогдуулан хүлээх үүрэг, хориглох зүйл

34.1.Нам дараах хандив өгсөн иргэний ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, эсхүл хуулийн этгээдийн нэр, хандивын хэмжээ, хандивыг хүлээн авсан он, сар, өдрийг цахим хуудсандаа хайлт хийх боломжтой нээлттэй өгөгдлийн санд улирал тутам байршуулж, сонгуулийн төв байгууллагад хүргүүлэх бөгөөд уг мэдээллийг намын санхүүгийн тайланд тусгайлан заана:

34.1.1.нэг жилд нийлбэр дүнгээр нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх, эсхүл түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн;

34.1.2.нэг жилд нийлбэр дүнгээр нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх, эсхүл түүнээс дээш төгрөгийн үнийн дүнтэй мөнгөн бус хандив.

34.2.Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 34.1-д заасан мэдээллийг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор цахим хуудсандаа нийтэлж, ил тод, нээлттэй байлгана. Иргэн, хуулийн этгээд энэ хуульд тусгасан хандивын дээд хэмжээнд багтаан нэгээс дээш удаа хандив өгсөн бол хандивын дүнг өмнөх хандивын дүн, хүлээн авсан он, сар, өдрийн хамт мэдээлнэ.

34.3.Нам энэ хуулийн 34.1-д заасан мэдээллийг нээлттэй өгөгдлийн санд улирал тутамд байршуулаагүй, эсхүл сонгуулийн төв байгууллагад хүргүүлээгүй бол сонгуулийн төв байгууллага тухайн намд энэ хуулийн 27.5-д заасан төрийн санхүүжилтийн /C1 х T1/ хэсгийг дараагийн жилд олгохгүй.

34.4.Нэг жилд нийлбэр дүнгээр нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлснээс бага хандивыг намын санхүүгийн тайланд тусгана.

34.5.Нам хандивтай холбогдуулан дараах үүрэг хүлээнэ:

34.5.1.хандивлагч хандив өгөх эрхтэй эсэхийг хуулийн дагуу тодорхойлох;

34.5.2.хандивлагчийн нэр, хаягийн талаар бүртгэл хөтлөх;

34.5.3.энэ хуулийн 34.6-д заасан хориглосон этгээдээс хандив хүлээн авснаа мэдсэнээс хойш ажлын 10 өдрийн дотор тухайн хандивлагч болон сонгуулийн төв байгууллагад энэ тухай мэдэгдэж, хандивыг сонгуулийн төв байгууллагад шилжүүлэх;

34.5.4.хандив болон хандивлагчийн мэдээллийг санхүүгийн тайланд тусгаж, сонгуулийн төв байгууллагад мэдэгдэх, сонгуулийн төв байгууллагын шаардсан нэмэлт мэдээллийг тухай бүр гаргаж өгөх;

34.5.5.мөнгөн бус хандив авч байгаа тохиолдолд хандивлагчтай хандивын гэрээг бичгээр байгуулж гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулах;

34.5.6.энэ хуульд заасан бусад.

34.6.Нам дараах этгээдээс хандив авахыг хориглоно:

34.6.1.гадаадын иргэн, харьяалалгүй хүн;

34.6.2.гадаад улс буюу гадаад улсын төрийн байгууллага, нам, хуулийн этгээд, олон улсын байгууллага, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж;

34.6.3.төрийн байгууллага болон нутгийн өөрөө удирдах байгууллага;

34.6.4.үйлдвэрчний эвлэл, шашны болон бусад төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо;

34.6.5.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, тэдгээрийн захирал, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга;

34.6.6.18 нас хүрээгүй Монгол Улсын иргэн;

34.6.7.байгуулагдаад нэг жил болоогүй хуулийн этгээд;

34.6.8.тодорхой нэр, хаяггүй этгээд, эсхүл нэр нь тодорхойгүй гуравдагч этгээдийн хандивыг дамжуулж байгаа этгээд;

34.6.9.өөртөө, эсхүл бусдад давуу байдал бий болгох зорилгоор хандив өгч байгаа этгээд;

34.6.10.бусад иргэн, хуулийн этгээдийн нэрийн өмнөөс мөнгөн болон мөнгөн бус хандивыг намд өгч байгаа иргэн, хуулийн этгээд;

34.6.11.дампуурсан хуулийн этгээд;

34.6.12.хуулиар хориглосон бусад этгээд.

34.7.Иргэдийн улс төрийн боловсрол, ардчилал, хүний эрх, эрх чөлөөг дэмжих, эсхүл тухайн намыг ардчилсан зарчмын дагуу бэхжүүлэх зорилгоор хамтарч ажиллах хүрээнд олон улсын байгууллага болон гадаад улсын байгууллагатай хамтран зохион байгуулах арга хэмжээ, хэрэгжүүлэх төслийн санхүүжилт энэ хуулийн 34.6.2-т хамаарахгүй.

- 34.8.Хандивлагч өөртөө, бусдад давуу байдал бий болгох зорилгоор хандив өгөхийг хориглоно.
- 34.9.Намд хандив өгснийхөө төлөө хандивлагч нь өөртөө болон бусдад аливаа давуу байдал олгохыг болон намын дотоод асуудлыг ардчилсан бус зарчмаар шийдвэрлэхийг шаардах, шахалт үзүүлэхийг хориглоно.
- 34.10.Хандивлагч намд хандив өгөхдөө бусад этгээдийн нэр, хаяг, мэдээллийг ашиглахыг хориглоно.
- 34.11.Иргэн, хуулийн этгээд нь бусад иргэн, хуулийн этгээдийн нэрийн өмнөөс мөнгөн болон мөнгөн бус хандивыг намд өгөхийг хориглоно.
- 34.12.Хуулийн этгээд намд хандив өгсөн бол хандивын хэмжээ, зориулалтыг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайландаа тусгана.
- 34.13.Намын санхүүгийн тайланд аудит хийхээр гэрээ байгуулсан аудитын хуулийн этгээд хандивын талаарх баримт, мэдээллийг хандивлагчаас гаргуулан авна.

35 дугаар зүйл. Улс төрийн намын өөрийн хөрөнгө, түүнээс олсон орлого

- 35.1.Нам нь тухайн намтай холбоотой хэвлэл, сурталчилгааны материал болон өөрийн хөрөнгийг захиран зарцуулах замаар орлого олж болно.
- 35.2.Энэ хуулийн 35.1-д зааснаас бусад аж ахуйн үйл ажиллагаанаас орлого олохыг хориглоно.
- 35.3.Энэ хуулийн 35.1-д заасны дагуу захиран зарцуулах үнэ зах зээлийн дундаж ханшаас их байвал түүнийг намд өгсөн хандивт тооцох бөгөөд түүний хэмжээ энэ хуулийн 33.6, 33.7-д зааснаас илүүгүй байна.
- 35.4.Намын нэг жилд өөрийн хөрөнгө, түүнээс олсон орлого нь тухайн намд олгосон төрийн санхүүжилтийн 50 хувиас ихгүй байна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ УЛС ТӨРИЙН НАМЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

36 дугаар зүйл. Улс төрийн намын санхүүгийн тайлан

- 36.1.Намын санхүүгийн тайлан нь энэ хуульд заасан орлого, зарлагын тооцоо, түүнтэй холбоотой хөрөнгийн бүртгэл болон тайлбар хэсгээс бүрдэнэ.
- 36.2.Нам санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон энэ хуульд заасан шаардлагын дагуу гаргана.
- 36.3.Орлогод дараах зүйлийг бүртгэнэ:
- 36.3.1.намын гишүүний татвар;
 - 36.3.2.сонгуульт гишүүний татвар;
 - 36.3.3.иргэний өгсөн хандив;
 - 36.3.4.хуулийн этгээдийн өгсөн хандив;
 - 36.3.5.намтай холбоотой хэвлэл, сурталчилгааны материал захиран зарцуулах замаар олсон орлого;
 - 36.3.6.өөрийн хөрөнгийг захиран зарцуулах замаар олсон орлого;
 - 36.3.7.төрийн санхүүжилт;
 - 36.3.8.төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэг;
 - 36.3.9.бусад орлого;
 - 36.3.10.энэ хуулийн 36.3.1, 36.3.2, 36.3.3, 36.3.4, 36.3.5, 36.3.6, 36.3.7, 36.3.8, 36.3.9-д заасан нийт орлого.
- 36.4.Зардалд дараах зүйлийг бүртгэнэ:
- 36.4.1.цалин хөлс;
 - 36.4.2.урсгал зардал;
 - 36.4.3.энэ хуулийн 26.3.1-д заасан үйл ажиллагааны зардал;
 - 36.4.4.энэ хуулийн 26.3.2-т заасан үйл ажиллагааны зардал;
 - 36.4.5.энэ хуулийн 26.3.3-т заасан үйл ажиллагааны зардал;
 - 36.4.6.энэ хуулийн 36.4.3, 36.4.4, 36.4.5-д зааснаас бусад үйл ажиллагааны зардал;
 - 36.4.7.сонгуулийн зардал;
 - 36.4.8.эд хөрөнгийн ашиглалтын зардал;
 - 36.4.9.бусад зардал;
 - 36.4.10.энэ хуулийн 36.4.1, 36.4.2, 36.4.3, 36.4.4, 36.4.5, 36.4.6, 36.4.7, 36.4.8, 36.4.9-д заасан нийт зардал.
- 36.5.Хөрөнгөд дараах зүйлийг бүртгэнэ:
- 36.5.1.барилга;
 - 36.5.2.ээмшлийн газар;
 - 36.5.3.ажлын байрны тоноглол, техник хэрэгсэл;
 - 36.5.4.бэлэн мөнгөний үлдэгдэл;
 - 36.5.5.хуримтлал;
 - 36.5.6.бусад хөрөнгө.
- 36.6.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага намын санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, хөрөнгө, орлого, зарлагын ангиллыг тодорхойлон тайлагнах журмыг сонгуулийн төв байгууллагатай хамтран энэ хуульд нийцүүлэн батална.
- 36.7.Намын хандивыг дараах үзүүлэлтээр бүртгэнэ:
- 36.7.1.намын дансанд төвлөрүүлсэн нийт хандивын хэмжээ, хандивлагчийн тоо;
 - 36.7.2.хандивлагч иргэний ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, хандивын хэмжээ, хэлбэр, мөнгөн бус хандивын үнэлгээ;
 - 36.7.3.хандивлагч хуулийн этгээдийн нэр, оршин байгаа газрын хаяг, гүйцэтгэх удирдлагын ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хандивын хэмжээ, хэлбэр, мөнгөн бус хандивын үнэлгээ.
- 36.8.Иргэн намын дансанд мөнгөн хандив шилжүүлэхдээ өөрийн орлогоос шилжүүлэх бөгөөд төлбөрийн даалгаварт ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, байнга оршин суугаа газрын хаяг, регистрийн дугаарыг тус тус заана.
- 36.9.Нам хандивыг сонгуулийн төв байгууллагаас баталсан бүртгэлийн маягтын дагуу цаасаар болон цахимаар бүртгэнэ.
- 36.10.Мөнгөн бус хөрөнгийг ижил төстэй хөрөнгийн зах зээлийн жишиг үнээр үнэлж мөнгөн дүнгээр бүртгэнэ.
- 36.11.Эд зүйлийг худалдах, зарцуулахад түүний эд хөрөнгийн бүртгэлд бүртгэгдсэн үнээр зарлага гаргана.
- 36.12.Намын орон нутгийн салбар хооронд хийгдсэн дотоодын суутган тооцоонд хөрөнгө зарцуулсан салбар дээр зарлагын бүртгэл хийгдэнэ.

УИХ.МН
СУДАЛГААНЫ САН

36.13. Нам тайландаа нэмэлт тайлбар хавсаргаж болно.

36.14. Намын санхүүгийн тайланд намын салбар болон бүтцийн нэгж, намын дэргэдэх бодлогын судалгааны байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэж, харьяа байгууллагын санхүүгийн мэдээллийг тусгана.

36.15. Намын нэгдсэн тайланд намын төв байгууллагын тайланг доод шатны намын салбар нэгжийн тайлангийн хамт тус тус хавсаргана. Орон нутаг дахь салбар нэгжийн тайланд хандив өгсөн бүх хандивлагчийн ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, тус бүр өргөсөн хандивын хэмжээтэй хамт бичиж тусгана. Намын төв байгууллага энэ хандив болон хандивлагчийн жагсаалтыг нэгтгэж, авсан нийт хандивын хэмжээ, тодорхой нэг хандивлагчаас өргөсөн хандивын нийлбэр дүнг нэгтгэн гаргана.

36.16. Сонгуулийн төв байгууллага намын санхүүгийн тайлан, түүнд холбогдох баримт бичгийг тухайн тайлант хугацаа дууссанаас хойш 10 жил хадгална.

37 дугаар зүйл. Улс төрийн намын санхүүгийн тайлан гаргах

37.1. Нам санхүүгийн нэгтгэсэн тайланг үнэн зөвөөр гаргана. Намын салбар нэгжийн гүйцэтгэх байгууллага өөрийн санхүүгийн тайланг гаргаж, намын төв байгууллагад хүргүүлнэ.

37.2. Намын санхүүгийн хагас жилийн тайланг жил бүрийн 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ.

37.3. Нам санхүүгийн тайланг гаргахдаа Шилэн дансны тухай хуулийн 4, 5 дугаар зүйлд заасан зарчмыг баримталж, энэ хуулийн 36 дугаар зүйлд заасныг тусгана.

37.4. Намын санхүүгийн тайланд дараах агуулга бүхий намын үйл ажиллагааны товч тайланг хавсаргана:

37.4.1. намын гишүүний тоог тайлант жилийн 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар;

37.4.2. намын удирдах дээд байгууллага, төлөөллийн төв байгууллагыг хуралдуулсан эсэх мэдээлэл;

37.4.3. энэ хуулийн 26.3-т заасан үйл ажиллагааны талаарх мэдээлэл;

37.4.4. энэ хуулийн 35.1-д заасан үйл ажиллагааны талаарх мэдээлэл.

37.5. Намын дарга, санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтан нь аль нэг аж ахуйн нэгж, байгууллагад санхүүтэй холбогдсон ажил, албан тушаал эрхлэхийг хориглоно. Түүнчлэн намын санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтан нь төрийн алба, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд давхар алба хашихыг хориглоно.

37.6. Нам нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт хөтлөөгүй, санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн баримтыг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу хадгалаагүй тохиолдолд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

37.7. Намын санхүүгийн тайланг хянан шалгах нэг, эсхүл түүнээс дээш тооны дотоод аудиторыг намын төлөөллийн төв байгууллагаас дөрвөн жилийн хугацаатай томилно. Түүнийг нэг удаа улируулан томилж болно.

37.8. Намын санхүүгийн тайланг сонгуулийн төв байгууллагад хүргүүлэхээс өмнө намын гүйцэтгэх төв байгууллага хэлэлцэнэ.

37.9. Намын санхүүгийн тайланг баталгаажуулж намын дарга болон санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтан гарын үсэг зурна.

37.10. Санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтны зурсан гарын үсэг нь тайланд агуулагдаж байгаа мэдээлэл үнэн зөв хийгдсэний баталгаа болно.

37.11. Намын дарга энэ хуулийн 37.9-д зааснаас бусдаар намын санхүү, төсвийн үйл ажиллагаанд захиран зарцуулах эрхтэйгээр оролцохыг хориглоно.

38 дугаар зүйл. Санхүүгийн тайланг баталгаажуулах

38.1. Нам жилийн эцсийн санхүүгийн тайлангаа жил бүрийн 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор Аудитын тухай хуульд заасан шаардлагыг хангасан аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан аудит хийсэн санхүүгийн тайланг сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ.

38.2. Аудитын хуулийн этгээд холбогдох баримт бичигтэй танилцах боломжийг нам бүрдүүлэх үүрэгтэй.

38.3. Аудитын хуулийн этгээд намын санхүүгийн тайланг хянаад зөрчилтэй гэж үзвэл тайланг баталгаажуулахаас татгалзах эрхтэй бөгөөд энэ талаар сонгуулийн төв байгууллагад ажлын гурван өдрийн дотор бичгээр мэдэгдэнэ.

38.4. Энэ хуулийн 38.1-д заасан аудитын үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс гаргана.

38.5. Дараах этгээд намын санхүүгийн тайланд аудит хийхийг хориглоно:

38.5.1. тухайн намд болон тухайн намын улс төр, эдийн засгийн ашиг сонирхлыг хангахад чиглэсэн ажил, албан тушаал хашиж байгаа, эсхүл сүүлийн гурван жилийн хугацаанд хашиж байсан;

38.5.2. намын нягтлан бодох бүртгэлийг хөтлөхөд, эсхүл намын тайланг гаргахад оролцсон;

38.5.3. ашиг сонирхлын зөрчил үүссэн бусад нөхцөл.

38.6. Энэ хуулийн 38.1-д заасан аудитын хяналтыг хийхэд намын санхүүгийн тайлан болон аудитын хуулийн этгээдийн илрүүлсэн эрсдэлд үндэслэн орон нутгийн салбар нэгж байгууллагын 5-аас доошгүй хувийг түүвэрт хамруулна.

38.7. Аудитын хуулийн этгээд хянан шалгах үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэхэд шаардлагатай тодруулга, баримт бичгийг намын гүйцэтгэх төв байгууллага болон түүний ажилтнаас шаардах эрхтэй. Үүнтэй холбоотойгоор аудитор нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, эд хөрөнгийг шалгах эрхтэй.

38.8. Шалгуулж байгаа намын орон нутгийн салбар нэгжийн гүйцэтгэх байгууллагаас тайланд тусгагдах ёстой бүх орлого, зарлага, эд хөрөнгийг бүртгэсэн тухай баталгааг аудиторт бичгээр гаргаж өгнө. Баталгааг орон нутгийн салбар нэгжийн доод шатны намын гүйцэтгэх байгууллагаас гаргуулж болох ба санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтан бичгээр баталгаа гаргана.

38.9. Аудитын шалгалтын үр дүнг бичгээр тайлагнаж, намын гүйцэтгэх төв байгууллага болон шалгуулсан орон нутгийн салбар нэгжийн гүйцэтгэх байгууллагад хүлээлгэн өгнө.

38.10. Аудитын хуулийн этгээд намын санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэл, бусад баримт бичиг болон намын гүйцэтгэх төв байгууллагаас өгсөн тайлбар, тодруулгыг үндэслэн холбогдох олон улсын стандартын дагуу шалгаж, баталгаажуулан дүгнэлт, тайлан гаргана.

38.11. Аудитын дүгнэлтийг намын тайланд хавсаргах бөгөөд энэ хуулийн 43 дугаар зүйлд заасны дагуу бүрэн хэмжээгээр нийтэлнэ.

39 дүгээр зүйл. Улс төрийн намын санхүүгийн тайлангийн хяналт

39.1. Сонгуулийн төв байгууллага намын санхүүгийн тайланг хүлээн авч энэ хуульд заасан шаардлагад нийцсэн эсэхийг хянах бөгөөд энэ хуулийн 38.10-т заасан аудитын тайланг харгалзан үзнэ.

39.2. Хяналтын ажиллагаа дуусгавар болсны дараа сонгуулийн төв байгууллага дүгнэлт гаргах бөгөөд дүгнэлтэд дараах зүйлийг тогтооно:

39.2.1. тайланд алдаа, зөрчил байсан эсэх;

39.2.2. тайланг алдаа, зөрчилтэй гаргасан бол үүний улмаас намд олгосон санхүүжилт зөрүүтэй эсэх.

39.3.Хэрэв намын тайланд байгаа мэдээлэл үнэн, бодит эсэхэд эргэлзэх тодорхой үндэслэл байвал сонгуулийн төв байгууллага тухайн намд ажлын таваас доошгүй өдрийн хугацаа заан мэдэгдэж, тайлбар хийх, залруулах боломж олгоно.

39.4.Энэ хуульд заасны дагуу намын санхүүгийн тайланг сонгуулийн төв байгууллага хүлээн авч хянаад жил бүрийн 04 дүгээр сарын 05-ны өдрийн дотор Төрийн аудитын байгууллагад дүгнэлт гаргуулахаар хүргүүлнэ.

39.5.Төрийн аудитын байгууллага төрөөс намд олгосон санхүүжилт, гүйцэтгэлд гаргасан дүгнэлтийг жил бүрийн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусган тайлагнана.

39.6.Энэ хуулийн 39.2-т заасан алдаа, зөрчилтэй тайлан ирүүлсэн нам аудитын хуулийн этгээдийн тогтоосон хугацаанд тухайн алдаа, зөрчлийг арилгаж, тайлангаа бүрэн, эсхүл хэсэгчлэн шинэчлэн ирүүлнэ. Шинэчилсэн тайлангийн үнэн зөвийг аудит хийлгэж баталгаажуулна.

39.7.Санхүүгийн тайланг хянах явцад олж авсан боловч намын тайланд шууд хамаарахгүй мэдээллийг нийтэлж болохгүй бөгөөд төрийн бусад байгууллагад дамжуулахгүй.

40 дүгээр зүйл. Тайлангийн алдаа, зөрчлийг мэдүүлэх үүрэг

40.1.Нам сонгуулийн төв байгууллагад санхүүгийн тайланг албан ёсоор хугацаандаа хүргүүлсний дараа өөрийн тайланд алдаа, зөрчил байгааг мэдвэл сонгуулийн төв байгууллагад энэ тухай бичгээр даруй мэдэгдэх үүрэгтэй.

40.2.Алдаа, зөрчлийн тухай сонгуулийн төв байгууллагад мэдүүлсэн цаг мөчид тайланд алдаа, зөрчил агуулагдсан тухай олон нийт болон сонгуулийн төв байгууллага ямар нэгэн мэдээлэлгүй байсан, эсхүл хянах явцад алдаа, зөрчлийг илрүүлээгүй бөгөөд нам алдаа, зөрчлийг бүрэн хэмжээгээр ил тод болгож залруулсан бол энэ хуулийн 41, 42 дугаар зүйлд заасан эрх зүйн үр дагавар үүсэхгүй. Хууль бусаар олж авсан орлогыг сонгуулийн төв байгууллагад түүний тогтоосон хугацаанд нам шилжүүлэн өгнө.

41 дүгээр зүйл. Аудитын дүгнэлтээр тогтоосон алдаа, зөрчлийн үр дагавар

41.1.Нам энэ хуулийн 39.6-д заасан хугацаанд алдаа, зөрчлөө арилгаж, санхүүгийн тайлангаа шинэчлэн ирүүлээгүй бол сонгуулийн төв байгууллага тухайн намд энэ хуулийн 27.5-д заасан төрийн санхүүжилтийн /C1 х T1/ хэсгийг дараагийн жилд олгохгүй.

41.2.Энэ хуулийн 41.1-д заасан намын зөрчил нь бусад намын санхүүжилтийн хэмжээг тогтоох болон олгоход нөлөөлөхгүй.

41.3.Энэ хуулийн 41.1-д заасан арга хэмжээг авахад хүргэсэн алдаа, зөрчлийг намын орон нутгийн нэгж гаргасан тохиолдолд тухайн асуудлыг нам дүрмээр зохицуулна.

42 дугаар зүйл. Хууль бусаар олж авсан хандив

42.1.Нам энэ хуулийн 34.5.3-т заасны дагуу хандивыг шилжүүлээгүй бол тухайн нам хууль бусаар авсан хандивыг хоёр дахин өсгөсөн дүнгээр сонгуулийн төв байгууллагад төлнө. Ийнхүү төлөх шийдвэрийг сонгуулийн төв байгууллага гаргана.

42.2.Энэ хуулийн 36.16-д заасан хугацаа өнгөрсөн тохиолдолд энэ хуулийн 42.1-д заасан төлбөр шаардахгүй.

42.3.Сонгуулийн төв байгууллага намаас төрд буцааж төлөх мөнгөний хэмжээг тогтооно. Энэ хугацаанд төрөөс дараагийн санхүүжилт авах эрх намд үүссэн бол сонгуулийн төв байгууллага намаас буцааж төлөх мөнгийг дараагийн санхүүжилтээс суутгаж тооцно.

42.4.Энэ хуулийн 42.1-д заасан арга хэмжээг авахад хүргэсэн алдаа, зөрчлийг намын орон нутгийн салбар нэгж гаргах тохиолдолд зохицуулах заалтыг нам дүрэмдээ тусгана.

43 дугаар зүйл. Тайланг нийтэд мэдээлэх

43.1.Сонгуулийн төв байгууллага жил бүрийн 05 дугаар сард багтаан намуудын санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны товч тайланг нэгтгэж, Улсын Их Хуралд мэдээлэх бөгөөд өөрийн цахим хуудсанд байршуулж, тухай бүр эмхэтгэж хэвлэн нийтэлнэ.

43.2.Сонгуулийн төв байгууллага жил бүрийн 05 дугаар сард багтаан намуудын орлого, зарлага, хөрөнгийн байдлын талаар харьцуулсан товч мэдээлэл бэлтгэж, өөрийн цахим хуудсанд байршуулж, тухай бүр эмхэтгэж хэвлэн нийтэлнэ.

43.3.Энэ хуулийн 39.6-д заасны дагуу алдаа, зөрчлийг арилган шинэчилсэн тайланг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн нийтэлж, сонгуулийн төв байгууллагын цахим хуудсанд байршуулна.

43.4.Нам санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны товч тайлангаа сонгуулийн төв байгууллагад хүргүүлсэн өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор өөрийн цахим хуудсанд байршуулж, цахим хуудасгүй намын тухайд өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтэлж, нийтэд танилцуулах үүрэгтэй.

43.5.Энэ хуулийн 43.4-т заасны дагуу цахим хуудсанд байршуулсан тайланг 10 жилийн хугацаанд устгахыг хориглоно.

43.6.Намын тайланг энэ хуулийн 43.4-т заасны дагуу нийтэд мэдээлсний дараа санхүүгийн тайланд зөрчил илэрсэн бол залруулгыг сонгуулийн төв байгууллагад хүргүүлэх, өөрийн цахим хуудсанд байршуулах, хэвлэн нийтлэх 14 хоногийн хугацааг сонгуулийн төв байгууллагаас тухайн намд өгнө.

43.7.Намын санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны товч тайлан, харьцуулсан товч мэдээллийг энэ хуулийн 43.1, 43.2, 43.4-т заасны дагуу цахим хуудсанд бүхэлд нь татаж авах, хайлт хийх боломжтойгоор байршуулна.

43.8.Намын санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны товч тайлан, харьцуулсан товч мэдээллийг нийтлэхдээ хандивлагч иргэний ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, эсхүл хуулийн этгээдийн нэр, оршин байгаа аймаг, сум, багийн, эсхүл нийслэл, дүүрэг, хорооны нэр, дугаарыг нийтэлнэ.

ДОЛДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

44 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

44.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

44.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

45 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

45.1.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА (Онцлох зохицуулалтууд)



ХУУЛИЙН ЗОРИЛТ, НЭР ТОМЪЁНЫ ӨӨРЧЛӨЛТ

	2023 ОН	2005 ОН
БҮТЭЦ	7 бүлэг 45 зүйлтэй	5 бүлэг 24 зүйлтэй
НАМЫН ТОДОРХОЙЛОЛТ (2019 оны ҮХНӨ- тэй нийцсэн)	Нам нь иргэдийн улс төрийн хүсэл зоригийг илэрхийлдэг, улсын хэмжээний бодлого дэвшүүлэн сонгуульд оролцдог , хамтын шийдвэр гаргаж, сайн дураараа эвлэлдэн нэгдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл мөн (4.1-т).	Нам нь Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу нийгмийн ашиг сонирхол болон хувийн үзэл бодол, улс төрийн үйл ажиллагаа явуулах зорилгын үүднээс сайн дураараа эвлэлдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл мөн.
ГИШҮҮНЧЛЭЛ	“намын гишүүн,” “намын дэмжигч,” “сонгуульт гишүүн” гэж тусад нь хуульчилсан	Нэр томъёоны тайлбарыг хуульчлаагүй
ШИНЭ ОЙЛГОЛТ	“төрийн санхүүжилт,” “төрөөс үзүүлэх шууд болон шууд бус дэмжлэг”	



НАМЫН ЧИГ ҮҮРЭГ

Төрийн улс төрийн алба хаах хариуцлагатай иргэнийг бэлтгэх
Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцох
Сонгуульд нэр дэвшүүлэн шударгаар өрсөлдөх (хэрэв УИХ-ын сонгуульд хоёр удаа дараалан оролцоогүй бол “идэвхгүй” намд тооцно)



НАМ БАЙГУУЛЖ, БҮРТГҮҮЛЭХ

Нам үүсгэн байгуулж, бүртгүүлэх нийт хугацаа (146 хоног буюу 4-5 сарын хугацаа)


Нам үүсгэн байгуулагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор бүртгүүлэх өргөдлийг бичгээр хүргүүлнэ (хүндэтгэн үзэх шалтгаантай бол +30 хоног)	Өргөдлийг шалгаж, шийдвэр гаргах хугацаа 86 өдөр	
	- Өргөдлийг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор бүрэн гүйцэд эсэхийг нягтлан шалгана - Бүрдэл, хэлбэрийн шаардлага хангаагүй бол 30 хоногийн хугацаа олгоно	35 хоногийн дотор
		- Нийт шүүгчдийн хуралдаанаар бүртгэх, татгалзах шийдвэр 30 хоногийн дотор гаргана - Бүртгэх шийдвэр гарсан бол ажлын 5 өдрийн дотор гэрчилгээ, тамга тэмдгийн хяналтын дугаар олгоно

Улсын дээд шүүх өргөдлийг хүлээн авах, нягтлан шалгах, бүртгэх болон татгалзах, нийтэд мэдээлэх үүргийг хэвээр хуульчилсан



НАМЫН ДОТООД АРДЧИЛАЛ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1. Намын дотоод бүтэц, зохион байгуулалт тус бүрийн гүйцэтгэх чиг үүрэг тодорхойлж,
2. Намын дэргэд "бодлогын судалгааны байгууллага" ажиллахыг хуульчилсан.
3. Мөн нэр дэвшүүлэхэд аль нэг хүйсийн төлөөлөл 30%-иас доошгүй байна.




НАМЫН САНХҮҮЖИЛТ


Намд олгох
төрийн
санхүүжилтийн
багцыг
Сонгуулийн
Ерөнхий хорооны
багцад тусгана

- Нийгмийн бүлгүүдэд 20%-иас доошгүйг эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг
- Улс төрийн боловсролыг дээшлүүлэх: 15%-иас доошгүйг намын гишүүд болон иргэд
- Намын дотоод ардчиллыг хөгжүүлэх: 15%-иас доошгүйг хөтөлбөр, бодлогын судалгаа хийх

Анхаарах: Дээрх шаардлагыг зөрчвөл улсын төсөвт төвлөрүүлэх/дараагийн санхүүжилтээс хасна.



**УЛС ТӨРИЙН НАМЫН
ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭР**



ТӨРИЙН ШУУД САНХҮҮЖИЛТ

Дээд хэмжээ: Сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн нийт сонгогчийн тоог нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 0.7 хувиар үржүүлснээс илүүгүй хэмжээгээр улсын төсөвт тусгана.

Шалгуур: Нийт сонгогчийн нэг ба түүнээс дээш хувийн санал авсан байх

Томъёо: $H = /C1 \times T1/ + /C2 \times T2/$

"H" – нийт санхүүжилт

"C1" – УИХ-ын сонгуулиар тухайн намын санал авсан тоо


"C2"- УИХ-д тухайн намын авсан суудлын тоо

"T1" – нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 0.5%-тай тэнцэх хэмжээний төгрөг

"T2"- нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 25 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөг

Хязгаар: Улсын төсвөөс нэг намд олгох санхүүжилтийн нийт хэмжээ нь тухайн намын энэ хуулийн 36.3.1-36.3.4-т заасан орлогын нийлбэрээс хоёр дахин их эсхүл түүнээс илүү байж болохгүй.

Анхаарах: хүйсийн квотоос илүү нэр дэвшүүлсэн эмэгтэй улс төрчид+хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нэр дэвшүүлсэн тохиолдолд: T2 томъёогоор тооцон, 4 жилд нэг удаа олгоно.



ТӨРӨӨС ҮЗҮҮЛЭХ ШУУД БУС ДЭМЖЛЭГ

Нийт сонгогчийн 1%-иас доошгүй санал авсан нам нь сонгуулийн бус жилд төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэгийг авна. Үүнд:

- намын удирдах дээд байгууллагыг хуралдуулах, гишүүд, дэмжигчидтэй хийх уулзалт, хурал зохион байгуулах, иргэдийг мэдээллээр хангах, соён гэгээрүүлэх зорилгоор төрийн болон төрийн өмчийн оролцоотой **ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УУЛЗАЛТЫН ТАНХИМ, ХУРЛЫН ЗААЛ, БУСАД ТАНХИМЫГ ЖИЛД 1 УДАА ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ АШИГЛАХ;**
- намын хөтөлбөр, үйл ажиллагааны талаарх нэвтрүүлгийг олон нийтийн радио, телевизээс гаргасан хуваарийн дагуу **30 МИНУТААР УЛИРАЛ ТУТАМ ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ НЭВТРҮҮЛЭХ.**



САНХҮҮЖИЛТИЙН ИЛ ТОД БАЙДАЛ



Намын дансанд хүлээж авсан хандивын болон бусад мэдээллийг Шилэн дансны тухай хуульд заасны дагуу намын цахим хуудаст байршуулна.



Хандивлагчдыг мэдээлэхдээ хувь хүний хуулиар хамгаалбал зохих мэдээллээс бусад мэдээллийг ил тод мэдээлнэ.



Нам жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийж, жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан цахим хуудсандаа байршуулж олон нийт, гишүүд, дэмжигчдэдээ нээлттэй танилцуулж байна.



Нийт нам сонгуульд хэдэн хувийн санал авснаас үл хамааран жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх зардлыг улсын төсвөөс гаргана.

ЭНЭ ТУХАЙ

СОНГОГЧИЙН БОЛОВСРОЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХЭД УЛС ТӨРИЙН НАМЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ



Баярмагнайн Баярбаатар

Монгол Улсын Их Сургууль, ШУС, Улс төр судлалын тэнхимийн докторант

ОРШИЛ

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр арван ес¹дүгээр зүйлд улс төрийн намын төлөвшил, намын системийн хөгжил, хариуцлагыг сайжруулах агуулга бүхий хэд хэдэн чухал заалт батлагдсан байдаг. Тухайлбал: Арван ес²дүгээр зүйлд:

1. Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 10-т заасны дагуу байгуулагдаж, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана.
2. Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна.
3. Намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно.” гэжээ.

Эдгээр нь санхүүжилтийг ил тод болгож, намын дотоод ардчиллыг сайжруулж, улсын хэмжээнд бодлого дэвшүүлэн ажиллах, намуудыг төлөвшүүлэх, хариуцлагыг сайжруулахын тулд батлагдсан хэмээн хууль тогтоогчид тайлбарлаж буй. Тэдгээрээс “Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 10-т заасны дагуу байгуулагдаж, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана.” мөн 3 дахь хэсэгт “...Намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар

тогтооно.” гэсэн заалт нь **бодлогын нам төлөвшүүлэх, улс төрийн намын нийгэмд гүйцэтгэх үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, төрөөс улс төрийн намд үзүүлэх санхүүгийн дэмжлэгийн талаар нарийвчилсан зохицуулалтыг “Улс төрийн намын тухай” хуулийн шинэчилсэн найруулгаар бий болгох боломжийг олгож, нэг талаар намыг үүрэгжүүлж** буй тул улс төр судлаачид, эрдэмтэд хийгээд иргэд, олон нийтийн сонирхлыг татсан сэдэв болно. Тухайлбал УИХ-ын 2023 оны хаврын чуулганаар хэлэлцэн баталсан “Улс төрийн намын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгад “Төрийн санхүүжилт”, “Төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэг”, “Намын санхүүгийн тайлан”, “Намын гишүүн, намын дэмжигч, сонгуульт гишүүн”, “Намыг идэвхгүйд тооцох, өөрчлөн байгуулах, үйл ажиллагааг зогсоох, татан буулгах” зэрэг нэр томьёог тайлбарлаж улс төрийн намын санхүүжилт авах эрх үүсэх нөхцөл, санхүүжилтийн зарцуулалт, тайлан, хариуцлага, зарцуулалтын төрөл зэргийг тодорхойлон тусгажээ. Цаашлаад улс төрийн намын нийгэмд хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх үүднээс зарцуулалтын нэгэн төрөлд “Төрийн санхүүжилтийн 15-аас доошгүй хувийг намын гишүүдийн болон иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, ардчилал, хүний эрхийн үнэт зүйлийг олон нийтэд таниулах;”-д зарцуулах заалт оруулсан нь иргэдийн боловсролыг дэмжих, ирээдүйн хариуцлагатай, мэдлэгтэй сонгогчийг бэлтгэхэд чухал ач холбогдолтой байна.

Иймд 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дээрх заалтууд нь улс төрийн намыг үүрэгжүүлэх, бодлогын намыг төлөвшүүлэн бий болгоход чухал ач холбогдолтой тул энэхүү өгүүллээр улс төрийн намын нийгэмд гүйцэтгэх үүрэг, хариуцлагатай сонгогч бэлтгэх шаардлагыг онолын үүднээс тайлбарлах болно.

1 Монгол Улсын Үндсэн Хууль, Хоёрдугаар бүлэг “Хүний эрх, эрх чөлөө”, арван есдүгээр зүйл

2 Монгол Улсын Үндсэн Хууль, Хоёрдугаар бүлэг “Хүний эрх, эрх чөлөө”, арван есдүгээр зүйл



Сонгогчийн боловсролыг нэмэгдүүлэхэд улс төрийн намын гүйцэтгэх үүрэг

Улс төр судлаач Элмер Эрик Шатшнайдер [Elmer Eric Schattschneider] (1942) "Улс төрийн намууд ардчиллыг бий болгосон ба орчин цагийн ардчиллыг намгүйгээр төсөөлшгүй"³ гээд улс төрийн нам нь ардчилсан улс төрийн гол оролцогч болохыг тодотгож, улмаар "Ардчиллын хямрал" хэрхэн үүсдэг, улс төрийн намтай холбогддог талаар тайлбарлажээ. Улс төрийн байгууллагаас намын ялгагдах шинж нь өөрийн зохион байгуулалт, үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, нийгмийн онцгой байр суурь, төрийн тогтолцоонд гүйцэтгэх онцгой үүрэг, эрх зүйн онцгой дэглэм, нийгмийн хариуцлага юм. Тухайлбал, нийтлэг байдлаар авч үзвэл улс төрийн нам⁴ нь:

- Улс төрийн бодлого боловсруулна;
- Улс төрийн үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллага төдийгүй улс төрийн ардчиллыг хэрэгжүүлэх онцгой үүрэг гүйцэтгэдэг. Энэ утгаараа нийгмийн бусад байгууллагатай харьцуулшгүй ач холбогдолтой тооцогддог.
- Төлөөллийн ардчиллыг бэхжүүлж, хөгжүүлэх үндсэн субъект бөгөөд нийгмийг хөгжүүлэх мөрийн хөтөлбөр дэвшүүлж, бүх нийтийн сонгуульд өрсөлддөг.
- Улс төрийн аль нэг үзэл суртлыг үйл ажиллагааныхаа удирдлага болгон ажиллана.
- Засгийн эрх авсан үедээ өөрийн бодлогоо төрөөр дамжуулж, нийгэмд хүргэх ба энэ үедээ иргэний нийгэм-төр хооронд зуучлагчийн үүргийг улс төрийн агрегаци* хийх замаар гүйцэтгэнэ.
- Иргэдийн улс төрийн нийгэмшлийг хангана.

***Агрегаци:** Нам нь нийгэм дэх ашиг сонирхлын агрегацийг хэрэгжүүлдэг суваг болдог. Иргэний нийгэм-нам-төр гэсэн гурвалсан харилцааны хүрээнд намын гүйцэтгэх үүрэг улам бүр өсөн нэмэгддэг. Сонирхлын агрегаци бол иргэдийн хувийн эрх ашиг, сонирхлыг тэдний улс төрийн нэгдсэн сонирхол болгон нэгтгэж, улмаар төрийн бодлогын боломжит хувилбар боловсруулах үйл ажиллагаа юм.

Дээрх шинжүүдийг нэгтгэн үзвэл "Нам гэдэг нь сонирхол, үзэл баримтлалтай хүмүүсийг нэгтгэж, үйл ажиллагаа нь төр, засгийн эрхийг авах буюу түүний хэрэгжилтэд оролцоход чиглэсэн сайн дурын, улс

төрийн байгууллага"⁵ юм.

Улс төрийн нам шууд утгаар иргэдийн төлөөллийн асуудлыг агуулна. Улс төрд сонгогдсон төлөөлөл тодорхой хугацаанд хэсэг бүлэг хүний нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулахыг "Төлөөлөх үйл ажиллагаа" гэнэ. Төлөөллийн загваруудын гол онцлог нь үр ашиг тодорхой төлөөлөгчөөр хангах явдал байна. Төлөөллийн хэд хэдэн загвар бий. Үүнд:⁶

- Төлөөлөгчийн загвар
- Итгэмжлэгч-төлөөлөгчийн загвар
- Мандатын загвар
- Дүрсэлсэн\тодорхойлсон загвар зэрэг болно.



Төлөөлөгчийн загвар:

Төлөөлөгчөөр сонгогдсон хүмүүс өөрсдийн хувийн дүгнэлт, сонголтоо санал болгох цаашлаад хувийн үзлээ хэрэгжүүлэх ёсгүй гэсэн үзэл санаанд тулгуурладаг. Өөрөөр хэлбэл, **төлөөлөгчийн загварт сонгогдсон албан тушаалтан өөрийг нь сонгосон хүмүүсийн дуу хоолой байх** ёстой бөгөөд хувийн үзэл бодлоос үл хамааран сонгогчийн хүсэлд нийцүүлэн ажиллах ёстой.



Итгэмжлэгч-Төлөөлөгчийн загвар:

Эртний Грект ардчиллын тухай ойлголт үүсэхтэй зэрэгцэн хөгжсөн бөгөөд Афины ардчиллыг энэ төрлийн загварын анхны жишээнд тооцдог. Түүнчлэн 1215 онд Магна Харт **"Хаан нь хуулиас дээгүүр биш, ард түмний эрхийг хамгаалах зарчим бий"** гэсэн үзэл санаа уг загварын хөгжилд нөлөөлжээ. АНУ 1787 онд Үндсэн хуулиндаа "Итгэмжлэгч-төлөөлөгчийн загвар"-ийг тодорхойлж, "Төлөөлөгчдийн танхим" нь ард түмнийг, Сенат нь мужуудыг төлөөлөн ажиллах болсон. 18-р зуунд улс төрийн философич Эдмунд Берк тайлбарласан бол 20-р зуунд улс төрийн намууд эрчимтэй байгуулагдах болсноор итгэмжлэгч-төлөөлөгчийн загвар улам боловсронгуй болсон. Итгэмжлэгч-төлөөлөгчийн загварыг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулсан улс төрийн онолчдод Жеймс Мэдисон [James Madison]⁷ Жон Стюарт Милл [John Stuart Mill]⁸, Роберт Даль [Robert Dahl]⁹ нар багтдаг. Парламентын засаглал дахь итгэмжлэгч-төлөөлөгч нарын загварын хамгийн ерөнхий хэлбэрийг

3 White, John Kenneth. 1992. E. E. Schattschneider and the Responsible Party Model. PS: Political Science and Politics 25 (2): 167–171. Sidney A. Pearson Jr.

4 Ц.Ганболд, Ё.Довчин "Улс төрийн шинжлэх ухаан" сурах бичиг, "Улс төрийн нам, намын систем", 322 дахь тал

5 Мөн тэнд

6 Dovi, Suzanne, "Political Representation", The Stanford Encyclopedia of Philosophy (Fall 2018 Edition), Edward N. Zalta (ed.), <https://plato.stanford.edu/archives/fall2018/entries/political-representation>, [2023.04.10]


7 Жеймс Мэдисон (1751-1836) АНУ-ын 4 дэх ерөнхийлөгч, Улс төрийн онолч

8 Жон Стюарт Милл, (1806-1873) Английн утилитарист гүн ухаантан, эдийн засагч, улс төрийн либерал үзэлтэн, төрийн зүтгэлтэн

9 Роберт Даль (1915-2014) Улс төр судлаач, ардчиллын плюралист онолын төлөөлөгч

улс төр судлаач Петер Майр [Peter Mair]¹⁰, Ричард Катц [Richard Katz]¹¹ нар “Ардчилал ба Улс төрийн намын картелизаци” номондоо дүрсэлснийг зураг 1-т¹² харуулав.

Зураг 1: Ардчиллын “Итгэмжлэгч-Төлөөлөгч”-ийн ерөнхий загвар, 2014 он



Зурагт өгүүлснээр “Сонгогчид” төлөөллөө сонгох, хийсэн үйлдлийнх нь төлөө хариуцлага тооцох эрх мэдэлтэй этгээд, түүний дараа “Төлөөлөгч” буюу парламент дахь намуудын сонгогчдынхоо өмнөөс шийдвэр гаргах эрх мэдэл бүхий сонгогдсон албан тушаалтан байна. Итгэмжлэгдсэн-төлөөлөгч шийдвэр гаргахдаа сонгогчдынхоо үзэл бодол, хүсэл сонирхлыг тусгахын чацуу шийдвэр гаргахын тулд өөрийн мэдлэг, дүгнэлт, туршлагаа ашиглаж хувийн ашиг сонирхолгүй, мэргэжлийн үүднээс хандах учиртай. Харин сүүл хэсэгт “Засгийн газар”, “Нутгийн удирдлага”-ыг тусгасан нь төлөөлөгчдийн гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үүрэгтэй төрийн байгууллага, түүний бүтцийг харуулсан хэрэг юм. Засгийн газар нь төлөөлөгч, сонгогчдын өмнө хариуцлага хүлээж, төлөөлөгчдөөс гарсан шийдвэрийг үр дүнтэй, хариуцлагатай хэрэгжүүлэх чиг үүрэгтэй.

Төлөөлөгчийн загвар нь хувийн, хөндлөнгийн оролцоо, дүгнэлтгүйгээр өөрийг нь сонгосон хүмүүсийн нэрийн өмнөөс ажиллахаар сонгогддог бол **“Итгэмжлэгч-төлөөлөгч” нь шийдвэр гаргахын тулд өөрийн мэдлэг, дүгнэлт, туршлагаа ашиглах үүрэгтэй хүн** байна. Тус загвар нь сонгогч өөрийн ашиг тусын тулд шийдвэр гаргах эрх мэдлийг итгэмжлэгдсэн төлөөлөгчдөд даатгаж, итгэмжлэгдсэн төлөөлөгчид шийдвэр гаргах чадвартай байх ёстой гэж үздэг. Итгэмжлэгч-төлөөлөгчийн загварын хамгийн түгээмэл хэлбэр нь бүх нийтийн ардчилсан сонгууль юм. Төлөөлөгч нь ард түмний эрх ашгийг төлөөлнө хэмээн мөрийн хөтөлбөрөө танилцуулж, санал авч сонгогддог. Үүнд “Улс төрийн нам” ихээхэн чухал үүрэгтэй оролцогч байна. Иймд **сонгууль бол итгэмжлэгч-төлөөлөгчөөрөө дамжуулан иргэд өөрийн төлөөллийг бий болгох, төлөөлөгчдөө хариуцлага тооцох сонгодог арга** юм.

Улс төрийн намын үүрэг

Улс төр судлаачид “Чөлөөт, шударга сонгууль тогтмол явагдах нь ардчилал\ардчилсан дэглэм оршин байх хамгийн наад захын нөхцөл”¹³ гэж үздэг. Улс төрийн намын үүргийн тухай бичсэн хамгийн эртний, нөлөө бүхий онолчдын нэг нь АНУ-ын Үндсэн хуулийг зохиогчдын нэг Жеймс Мэдисон юм. Тэрбээр улс төрийн нам нь ардчилсан нийгмийн зайлшгүй нэг хэсэг бөгөөд иргэдийг зохион байгуулах, улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх механизмыг бүрдүүлэгч мөн гэжээ. Ардчилсан улс төрийн системд намын гүйцэтгэх чиг үүргийг 3 ерөнхий бүлэгт хувааж үздэг.¹⁴ Тухайлбал:

Нэгдүгээрт: Улс төрийн нам нь нийгэм, нийгмийн бүлгүүдтэй харилцах, тэдгээрийн эрх ашиг сонирхлыг илэрхийлэх (сонирхлын артикуляци), сонирхлыг нэгтгэх (сонирхлын агрегаци), улс төрийн нийгэмшлийг хангах зэрэг багтана.

Хоёрдугаарт: Улс төрийн системд намын гүйцэтгэх үүрэг нь нийгмийн болон улс төрийн системийг хөгжүүлэх, улс төрийн чиг шугамыг тодорхойлох, улс төрийн системд тухайн намын эзэлж буй байр сууриар цаашдын цар хүрээ нь хэмжигддэг. Ардчилсан нийгэмд эрх баригч нам, эвсэл нь бүх нийтийн чөлөөт, шударга сонгуулийн үр дүнд дээрх эрх мэдлийг олж авдаг. Намын зохион байгуулалт буюу боловсон хүчний бодлогыг тодорхойлохдоо намын дотор болон төрийн байгууллагад ажиллах хүмүүсийг бэлтгэх, дэвшүүлэн ажиллуулахтай холбоотой ба улс төрийн лидерүүдийг хүмүүжүүлж, төлөвшүүлэх явдал нь нийгмийн өмнө хүлээсэн чухал үүрэг болно.

Гуравдугаарт: Намын дотоод амьдралтай шууд холбоотой буюу намын эгнээг өргөжин тэлэх, нэгдэл, нягтралыг бэхжүүлэх, намын гишүүд, дэмжигчдийн баримтлах үнэт зүйлс, хэм хэмжээг тогтоох, намын удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох чиг үүрэг багтана.¹⁵

Улс төрийн нам нь дараах үндсэн үүрэгтэй байна. Үүнд: 1.Нийгмийн үүрэг – Иргэдийн ашиг сонирхлыг нэгтгэн тодорхойлохыг эрмэлзэж, хүсэл зоригоо илэрхийлэх арга замыг зааж өгөх;

2.Үзэл суртлын үүрэг – Нийгэмд болон өөрийн гишүүд дэмжигчдэдээ улс төрийн тодорхой үзэл суртлыг (либерал, консерватив, социал-демократ, фашист, коммунист гэх мэт) санал болгож итгэл үнэмшлээрээ дэмжиж, нэгдсэн хэсэгт боловсруулсан хөтөлбөрөө санал болгох;

3.Улс төрийн үүрэг – Төрийн сонгуульд оролцож, засаглах эрх мэдэл болон төрийн бодлого тодорхойлох, төрийн

10 Петер Майр (1951-2011) Улс төр судлаач, Европын их сургууль, харьцуулсан улс төрийн профессор

11 Ричард Катц, улс төр судлаач, Йелийн их сургуулийн профессор

12 Улс төр судлаач Петер Майр, Ричард Катц “Ардчилал ба Улс төрийн намын картелизаци” (Democracy and the Cartelization of Political Parties) ном, 6 дах тал

13 Dahl, Diamond (1971, 1999), “Democracy in Rhetoric and Reality” Palgrave Pivot, Cham.

14 Э.Гэрэлт-Од “Ардчилсан нийгэмд улс төрийн намын гүйцэтгэх үүрэг, роль”, Шинэ толь №70, 2010

15 Мөн тэнд

албан тушаалд өөрсийн хүмүүсийг бэлтгэн байршуулах;
4.Ард түмэн, дэмжигчдийнхээ эрх ашигт нийцүүлэх ажиллах явдал юм.

Эдгээрийг нэгтгэн харвал нам улс төрийн зорилгоо тодорхойлж, үзэл суртал, мөрийн хөтөлбөр боловсруулж нийгмийн хэтийн хөгжлийн төлвийг тодруулан иргэдэд итгүүлэн үнэмшүүлэх үүрэгтэй ба иргэдийг гэгээрүүлж улс төрийн ухамсар суулгаж, улс төрийн хувьд нийгэмшүүлэх нь намын зорилгод голлох байр суурьтай аж. Сонгуульд улс төрийн намын гүйцэтгэх үүргийн талаарх судалгааг хамгийн анх 19-р зууны сүүлч, 20-р зууны эхэн үед Вудро Вилсон [Woodrow Wilson]¹⁶, Роберт Михельс [Robert Michels]¹⁷ зэрэг улс төр судлаач хийж, улс төрийн намуудын зохион байгуулалтын бүтэц, улс төрийн динамикийг судалсан ба улс төрийн намууд сонгуульд дараахь үүрэг гүйцэтгэнэ хэмээсэн.¹⁸ Үүнд:



Нэр дэвшигчийг сонгон шалгаруулж бэлтгэх:

Улс төрийн нам нь өөрийн үзэл баримтлал мөрийн хөтөлбөр, төлөвлөгөө дор сонгуульд нэр дэвших хүмүүсийг сонгон шалгаруулж бэлтгэх үүрэгтэй.



Сонгуулийн сурталчилгааны зохион байгуулалт, удирдлага:

Улс төрийн намууд нэр дэвшигчдийнхээ сурталчилгааг зохион байгуулах, удирдах, үүнд санхүүжилт босгох, сонгуулийн сурталчилгааны стратеги боловсруулах, сайн дурынхан, дэмжигчдийг дайчлах үүрэгтэй.



Бодлогын байр суурь, мөрийн хөтөлбөрөө танилцуулах:

Татвар, эрүүл мэнд, гадаад бодлого зэрэг олон талт асуудлаар намууд бодлогын байр сууриа боловсруулж, илэрхийлдэг үүрэг нь сонгогчдод нэр дэвшигчдийн ялгааг ойлгож, зөв сонголт хийхэд тусалдаг.



Сонгогчдыг идэвхжүүлэх: Улс төрийн намууд сонгуулийн өдөр сонгогчдын ирцийг бүрдүүлж, сонгогчдыг идэвхжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын хувьд 1992 оны шинэ, ардчилсан Үндсэн хууль батлагдсан цагаас хойш нийт 34 удаагийн сонгууль зохион байгуулагдсан түүхтэй. 1992-2021 оны хугацаанд явагдсан УИХ-ын сонгуулийн ирцийг үзэхэд 1992–2012 оны сонгуульд сонгогчдын ирц 28.32%-иар буурч, 2016 онд 73.58%, 2020 онд 73.64% болж тогтворжсон боловч

2020 оны сонгуулийг 1992 онтой харьцуулахад 21.96%-иар буурсан үзүүлэлттэй¹⁹ байна.



ДҮГНЭЛТ:

Дүгнэж хэлэхэд, “Улс төрийн нам” нь орчин цагийн бүгд найрамдах засаглалтай улс орнуудад намын үндсэн үүрэг болох иргэдийн ашиг сонирхлыг илэрхийлэх, төлөөлөх, нийгэмшилтийн хангах нийгмийн үүрэг, улмаар гишүүд дэмжигчдэдээ улс төрийн тодорхой үзэл суртлыг санал болгож, итгэл үнэмшлээр нь нэгтгэх үзэл суртлын үүрэг, төрийн сонгуульд оролцож эрх мэдэл болон төрийн бодлого тодорхойлох улс төрийн үүргүүдийг биелүүлж байх онцгой институци юм. Гэтэл сүүлийн 20 жилийн хугацаанд Монголд олон намууд үүсэн байгуулагдаж өнөөдрийн байдлаар 37 улс төрийн нам Улсын Дээд Шүүхэд бүртгэлтэй байгаа ч зонхилох хоёр намаас бусад улс төрийн намууд улс төрийн идэвхгүй үйл ажиллагаатай байж, хоёр нам л төрийн бодлогыг тодорхойлж иржээ. 2023 оны дөрөвдүгээр сард “Сант Марал” сан, ХБНГУ-ын Конрад-Аденауэрын сантай хамтран явуулсан “Улс төрийн барометр №22” судалгаанд “Улс төрийн намууд олон түмний санал бодлыг илэрхийлж байгаа эсэх”-ийг тодруулахад судалгаанд оролцогчдын 87% нь “Илэрхийлдэггүй” гэж хариулжээ. Түүнчлэн “Намын талаарх таны бодол” гэсэн асуултад “Намууд хэрэггүй” гэсэн хариултыг 46.5% нь сонгосон байгаа нь иргэдийн зүгээс улс төрийн намд итгэх итгэл буурсан, намаас илүүтэй нэр дэвшигчийг дэмжих хандлага нэмэгдсэн, улс төрийн намууд үндсэн үүргээ биелүүлэхгүй байгааг илтгэнэ.


Иймд 2023 оны хаврын чуулганаар шинэчлэн батлагдсан “Улс төрийн намын тухай хууль” болон “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт”-д тусгасан “Улс төрийн намын нийгмийн өмнө хүлээх хариуцлага”, “Намын санхүүжилт, түүний тайлан, хяналт” зэрэг намыг идэвхжүүлэх, хариуцлагыг нэмэгдүүлэх, намын хөгжлийг шат ахиулах зарчмын суурь шинэчлэлтийг иргэдийн улс төрийн боловсрол, ирээдүйн сонгогчдыг бэлтгэхэд анхаарах үйл ажиллагааг цаашид эрчимжүүлэх, хуулиар үүрэгжсэн чиг үүргээ биелүүлэх цаг иржээ хэмээн үзэж болох талтай юм.

16 Вудро Вилсон, АНУ-ын 28 дахь Ерөнхийлөгч (1913–1921)

17 Роберт Михельс (1876-1936) - Германы улс төр судлаач, социологич.

18 Wilson Carey McWilliams, “The Anti-Federalists, Representation, and Party,” Northwestern University Law Review 84 (Fall 1989): 28, 36.

19 Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн дүн 1992-2020 он, Сонгуулийн Ерөнхий Хорлоо, https://gec.gov.mn/uploads/ih_huraliin_songuuli-2022.03.22.pdf [2023.04.10]



САНАЛ ТООЛОХ ТӨХӨӨРӨМЖИЙН ҮР ДҮН БА ХЯНАЛТЫН ТООЛЛОГО

Магистр П.Алтанчимэг, Б.Ууганцэцэг

Сонгуулийн Ерөнхий Хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн ахлах референт

Монгол Улс Улсын Их Хурлын 2012 оны ээлжит сонгуулиас эхлэн 9 удаагийн ээлжит сонгууль, 24 удаагийн ээлжит бус сонгуулийг Сонгуулийн Автоматжуулсан Систем /САС/-ээр зохион байгуулсан юм. САС нь санал тоолох төхөөрөмжийн иж бүрдэл, Сонгогчийн бүртгэлийн иж бүрдэл гэсэн 2 хэсгээс бүрддэг.

Монгол Улсын Их Хурлаас сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийг 2011 онд баталж, улмаар санал тоолох төхөөрөмжийн системийг хэрхэн баталгаажуулах талаар нарийн тусгасан байдаг. Уг хуульд зааснаар Автоматжуулсан системийг сонгуульд хэрэглэх эсэх шийдвэрийг гаргах эрх гагцхүү УИХ-д хадгалагддаг. Манай улсад санал тоолох төхөөрөмжийг хэрэглэх болсон шалтгаан нь саналын хуудас тоолох, дүн нэгтгэх үйл ажиллагаан дахь хүний хүчин зүйл, нөлөөллийг багасгах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, санал хураалтын дүнг хурдан шуурхай нэгтгэх зорилготой байсан билээ. Манайд ашиглаж буй систем нь санал тоолох, дүн гаргах, нэгтгэх үйл явцыг хүний оролцоогүйгээр явуулж, санал хураалтын үр дүнг найдвартай байлгах, нягтлан шалгах, баталгаажуулах цаасан болон цахим баримтуудыг үлдээдэг, сонгуульд оролцогч талууд хянах боломжтой байдгаараа давуу талтай юм.



САНАЛ ХУРААЛТЫН ӨМНӨХ ТӨХӨӨРӨМЖИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ

Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн мэргэжлийн албан хаагчид санал тоолох төхөөрөмж, түүний иж бүрдлийг сонгуульд бэлтгэх, шалгах, өгөгдөл дамжуулах сүлжээг бэлтгэх ажлыг тухайн сонгуулийн жил эхэлсэн үеэс хийж гүйцэтгэдэг. Төхөөрөмж, иж бүрдлийг туршин шалгаж, баталгаажуулахдаа Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн дагуу харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Тагнуулын ерөнхий газар болон Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн хамтарсан Ажлын хэсэг¹ хийж гүйцэтгэнэ.

Ажлын хэсэг шалган, туршиж баталгаажуулах үйл ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөө боловсруулж ажилладаг. Төлөвлөгөөнд системийн эх кодыг шалгах, санал тоолох төхөөрөмжийг бэлтгэх ажиллагаанд хяналт тавих, логик нарийвчилсан тестийн үйл ажиллагааг хянах, санал тоолох төхөөрөмж болон VPN сүлжээг шалгах, туршиж баталгаажуулах зэрэг үндсэн

¹ Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль

ажил багтана. Ажлын хэсэг Санал тоолох төхөөрөмжийг баталгаажуулахдаа тухайн сонгуульд оролцож буй улс төрийн нам, эвсэл, иргэний нийгмийн байгууллагуудад санал тоолох төхөөрөмжийн шалган турших үйл ажиллагаанд оролцож туршиж үзэх, хөндлөнгийн хараат бус хяналт тавих, ажиглах ажиглагч ажиллуулахыг санал болгон албан хүсэлт хүргүүлж, оролцох нөхцөл боломжоор хангаж ажилладаг.



САНАЛ ХУРААЛТЫН ДАРААХ ХЯНАЛТЫН ТООЛЛОГО

Манай улсад хэрэглэж буй санал тоолох төхөөрөмжийн үйл ажиллагааг олон шүүлтүүрээр хянан шалгагдах боломжтойгоороо давуу талтай. Санал авах байранд ажиллуулж буй төхөөрөмж нь өдрийн турш ямар нэгэн сүлжээнд холбогдохгүйгээр ажиллаж, санал хураалт дуусахад "Хаалтын тайлан" буюу тухайн өдрийн турш төхөөрөмжид бүртгэгдэн уншуулсан саналын хуудасны тайлан/үр дүнг хэвлэдэг.

Хаалтын **тайланд** бүртгэгдсэн нийт саналын хуудасны тоо, нэр дэвшигч тус бүрийн авсан саналын тоог харуулдаг. Уг тайланг тухайн санал авах байранд ажиллаж буй бүх нам, эвсэл, ТББ-ын ажиглагчдад хэвлэн өгдөг. Үүний дараа төхөөрөмжийг тусгай хамгаалалт бүхий сүлжээнд холбож, төхөөрөмжийн дүнг Сонгуулийн ерөнхий хорооны төв серверт илгээнэ.

Тухайлбал Монгол Улсын хэмжээнд сонгууль тус бүрээс шалтгаалан 2064 орчим санал авах байр ажилладаг. Тэдгээр байр бүрт нам, эвсэл өөрсдийн итгэмжит төлөөлөгч ажиглагчдаа томилон ажиллуулах боломжтой байдаг. Тэдгээр ажиглагчдаараа дамжуулан тухайн санал хураалтын дүнг Сонгуулийн ерөнхий хорооноос урьтаж сонгуулийн үр дүнг мэдэх боломжтой байдаг онцлогтой. Жишээлбэл, орон нутаг дахь 200 гаруй санал авах байр төвөөс алслагдсан тул цахим сүлжээ нэвтрээгүй, дүн мэдээг шууд дамжуулах боломж хараахан бүрдээгүй тул тухайн шатны сонгуулийн хорооноос дүнг дамжуулахад 1-4 цагийн хугацаа зарцуулах тохиолдолд тухайн байранд ажилласан нам, эвслийн ажиглагч хэвлэж авсан хаалтын тайлангаа түрүүлж мэдээлэх нь бий.

Хяналтын тооллого: Хаалтын тайланг хэвлэсний дараа төхөөрөмжид уншуулсан бүх саналын хуудсыг гараар дахин тоолж ХЯНАЛТЫН ТООЛЛОГО явуулдаг. Улмаар үр дүнг төхөөрөмжийн хаалтын тайлантай тулгаж хянаж шалган баталгаажуулдаг. Хяналтын тооллогыг УИХ-ын 2012 оны ээлжит сонгуулиас буюу автоматжуулсан төхөөрөмжийг ашигласан үеэс эхэлсэн бөгөөд 11 жилийн хугацаанд хяналтын тооллогын дүн, төхөөрөмжийн дүнгээс зөрсөн удаагүй юм.

ХЯНАЛТЫН/ ТЕХНИКИЙН ТООЛЛОГЫГ ХЭРХЭН ЯВУУЛЖ ИРЭВ?

Хяналтын тооллогыг Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Орон нутгийн Хурлын сонгуулийн тухай хууль, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Сонгуулийн тухай хуулиудад нийцүүлэн Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан "Хяналтын тооллого хийх нийтлэг журам"-ын дагуу сонгууль тус бүрээр хийж ирсэн билээ. Шат, шатны сонгуулийн хороод уг журмын дагуу хяналтын тооллогыг явуулж, дүнг нэгтгэн, тэмдэглэл үйлдэж Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлдэг журамтай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ХЯНАЛТЫН ТООЛЛОГЫН МЭДЭЭНИЙ НЭГТГЭЛ						
№	Аймаг	Нийт хэсгийн тоо	2020.6.24-25ны өдөр		2020.6.27-28-ны өдөр	
			Хяналтын тооллого хийсэн хэсгийн тоо	Хувь	Нэмж хяналтын тооллого хийсэн хэсгийн тоо	Хувь /Өссөн дүнгээр/ тоо
1	Архангай	105	48	45.7	5	50.5
2	Баян-Өлгий	96	46	47.9	-	-
3	Баянхонгор	105	50	47.6	-	-
4	Булган	68	31	45.6	-	-
5	Говь-Алтай	87	37	42.5	-	-
6	Говьсүмбэр	55	32	58.2	-	-
7	Дорнод	72	33	45.8	3	50.0
8	Дорноговь	59	23	39.0	-	-
9	Завхан	111	56	50.5	-	-
10	Өвөрхангай	106	52	49.1	2	50.9
11	Өмнөговь	61	25	41.0	10	57.4
12	Сүхбаатар	64	27	42.2	-	-
13	Сэлэнгэ	56	25	44.6	-	-
14	Төв	96	40	41.7	-	-
15	Увс	92	42	45.7	-	-
16	Ховд	91	33	36.3	-	-
17	Хөвсгөл	129	70	54.3	-	-
18	Хэнтий	89	38	42.7	-	-
19	Дархан-Уул	39	18	46.2	21	100.0
20	Орхон	38	18	47.4	-	-
21	Орхон- Уул	26	13	50.0	-	-
22	Баянзүрх дүүрэг 22 дугаар тойрог	47	11	23.4	12	48.9
23	Баянзүрх дүүрэг 23 дугаар тойрог	53	14	26.4	12	49.1
24	Сүхбаатар 24 дүгээр тойрог	42	5	11.9	16	50.0
25	Баянгол дүүрэг	44	5	11.4	17	50.0
26	Сонгинохайрхан дүүрэг - 27-р тойрог	77	38	49.4	-	-
27	Сонгинохайрхан дүүрэг - 28-р тойрог	43	4	9.3	18	51.2
28	Хан-Уул дүүрэг	59	6	10.2	24	50.8
29	Хан-Уул дүүрэг	60	6	10.0	24	50.0
НИЙТ ДҮН		2070	846	40.9	164	48.8

МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО

Хяналтын тооллогыг олон нийтэд нээлттэйгээр буюу хэвлэл мэдээлэл, нам, эвсэл, иргэний нийгмийн төлөөлөл, ажиглагчдын хяналт дор явуулдаг. Хяналтын тооллогын үйл ажиллагааг бүхэлд нь хяналтын камерт бичиж буулган баталгаажуулна.²

Зурагт-файл: Санал тоолох төхөөрөмжөөс дүнг төв серверт илгээсний дараа төхөөрөмжид уншигдсан саналын хуудасны зурагт-файлыг ажиглагч тус бүрт хуулж өгдөг. Санал тоолох төхөөрөмжийн дүнг баталгаажуулах бас нэг арга нь саналын хуудасны зурагт мэдээллийг хаалтын тайлан, хяналтын тооллогын дүнтэй тулгаж үзэх явдал юм. Өөрөөр хэлбэл санал тоолох төхөөрөмжийн үр дүнг хянах олон арга бий.

2 Хяналтын тооллого хийх нийтлэг журам



СОНГУУЛЬ ДЭЛХИЙ ДАХИНД

СОНГУУЛИЙН АСУУДЛААРХ ИССЫК-КУЛЫН ФОРУМД ОРОЛЦСОН НЬ

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн бөгөөд Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, зөвлөх Ч.Баттөмөр нар 2023 оны зургадугаар сарын 22-23-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Киргиз Улсын Иссyk-Кул тойргийн Чолпо-Ата хотноо “XXI зууны сонгууль: Сонгуулийн хэлбэрүүд, сайн туршлага, тулгамдаж буй асуудал, хөгжлийн зам” сэдэвт олон улсын форумд оролцоод ирсэн билээ. Тус улсад ажилласан тэмдэглэлийг уншигч танаа хүргэж байна.

Киргиз Улсын Сонгуулийн болон Бүх нийтийн санал асуулгын төв комиссоос анх удаа **ЗОХИОН байгуулсан** уг форумд Киргиз, Казахстан, Турк, Узбекистан, Армен, Туркменистан, Беларусь, Азербейджан, ОХУ, Гүрж, Монгол зэрэг 10 гаруй улсын сонгуулийн төв байгууллагын дарга, гишүүд, төлөөлөл, Дэлхийн сонгуулийн байгууллагуудын Холбооны Нарийн бичгийн даргын орлогч Чой Кванжае, Турк гаралтай улсуудын байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч Эржан Серикович, Турк гаралтай улсуудын парламентын Ассамблейн Ерөнхий нарийн бичгийн дарга Сурэя Эр Мехмэт, Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн орнуудын парламент хоорондын ассамблейн Зөвлөлийн Нарийн бичгийн дарга нарын газрын орлогч Иван Ильич Мушкет нар

оролцлоо.

Тус форумын ажиллагаанд амжилт хүсч БНКУ-ын Ерөнхийлөгч Жапаров С.Н дэлгэцээр мэндчилж, Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн орнуудын байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга Лебедев С. Н бичгээр мэнд мэдэж, Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга Занг Мин дүрст мэндчилгээ ирүүлжээ.

Зохион байгуулагч талыг төлөөлж, БНКУ-ын Сонгуулийн болон Бүх нийтийн санал асуулгын төв комиссын дарга, хатагтай Шайлдабекова Нурзан Кармабековна форумыг нээж хэлсэн үгэндээ энэ удаагийн арга хэмжээг Ерөнхийлөгчийн Тамгын газартай хамтран зохион байгуулж байгааг дурдаад гадаад улс орны сонгуулийн систем, сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, дэлхийн улс орнууд сонгуулиа хэрхэн зохион байгуулдаг туршлага, тавьж буй зорилт, харилцан мэдээлэл, туршлага солилцоход гол зорилго оршино хэмээн онцлон тэмдэглэв.

Киргиз Улсад сүүлийн жилүүдэд зохион байгуулсан сонгуулиудад боловсронгуй болгох, ялангуяа санал хураалтын дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд Монгол анд нөхөд сэтгэл харамгүй дэмжлэг туслалцаа үзүүлж, зөвлөж ирснийг онцлон тэмдэглэж байгаа гэв.

Форумаар “Сонгуулийн хууль тогтоомж, сонгуулийн үйл ажиллагааг боловсронгуй болгох нь”, “Технологийн баталгаат байдал”, “Залуучууд ба Сонгууль” гэсэн 3 бүлэг сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг явуулж, Киргизийн сонгуулийн төв байгууллагын удирдлагууд болон бие даасан судлаач, экспертүүд илтгэл, танилцуулга хийж, харилцан мэдээлэл солилцлоо.

Нэгдсэн хуралдааны үеэр оролцогч улс орнуудын төлөөллүүд сонгуулийн хууль тогтоомжийн орчин, ололт ахиц, цаашдын зорилтын талаар байр сууриа илэрхийлж үг хэлэв. Ийн форумаар хэлэлцүүлсэн асуудлыг дүгнэж, шийдвэрлэх арга замыг тодорхойлсон баримт бичиг баталсан бөгөөд сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр оролцогч улсуудаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, сонгуулийн үйл ажиллагаанд нэвтрүүлж буй технологи, ололт амжилтын талаар мэдээлэл солилцож, төлөөлөгчид нүүр тулан уулзаж, ажил хэргийн холбоо тогтоосонд Форумын ач холбогдол оршино.

Манай төлөөлөгчид Дэлхийн сонгуулийн байгууллагуудын Холбооны төлөөлөлтэй уулзаж, манай улс дахь эрх зүйн орчин, УИХ-ын ээлжит сонгуулийн талаар мэдээлэл солилцсон юм.



**МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН
ЕРӨНХИЙ ХОРОО**

Засгийн газрын 11 дүгээр байр
Ж.Самбуугийн гудамж,
Улаанбаатар – 15141, Монгол Улс

Санал хүсэлт хүлээн авах хаяг:

gecm@m-election.mn
(976) -51 262127